



## ДОТООДОД БОЛОН ГАДААДАД БОЛОВСРУУЛАХ ГОРИМЫН ТУХАЙ ДГБ-ЫН ГАРЫН АВЛАГА

2020 он

Орчуулсан: ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ

Хянасан: Д.Баярсайхан

Эх бэлтгэсэн: Б.Бужидмаа

Цаасны хэмжээ: 145x210

Хэвлэлийн хуудас: 8.25

# ГАРЧИГ

I. ОРШИЛ .....	7
II. УДИРТГАЛ .....	9
III. БОЛОВСРУУЛАХ ГОРИМ АШИГЛАН ХИЙГДЭХ ХУДАЛДАА (НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН ХУДАЛДАА - PROCESSING TRADE) .....	11
a. ДГБ-ын стандарт, баримт бичиг, арга хэрэгсэл .....	13
b. Дотоодод боловсруулах горим (Inward processing) .....	14
c. Гадаадад боловсруулах горим (Outward processing) .....	17
IV. ГИШҮҮН ОРНУУДЫН ТУРШЛАГА .....	20
a. Хууль тогтоомж, дүрэм журам .....	20
i. Эдийн засгийн үр нөлөө бүхий дүрэм журам .....	21
ii. Татвар буцаан олгох горим (Drawback procedure) .....	23
iii. Татварын баталгаа (Guarantee) .....	24
iv. Зөвшөөрөл (Authorization) .....	26
v. Техникийн тодорхойлолтыг баталгаажуулах (Validation of Specifications) .....	33
vi. Хяналт (мониторинг), аудит .....	35
b. Мэдээллийн технологийн тус дэм .....	38
i. Гаалийн байгууллага .....	38
ii. Аж ахуйн нэгж .....	41
c. Удирдлага .....	42
i. ДГБ-ын гишүүн орнуудад дотоодод/гадаадад боловсруулах горим ашиглаж буй байдал .....	42
ii. Мэдээлэл хүргэж буй байдал .....	44
iii. Сургалт .....	45
XAVСРАЛТУУД .....	47
Хавсралт 1. Дотоодод болон гадаадад боловсруулах горимын талаар ДГБ-аас явуулсан судалгааны хүрээнд гишүүн орнуудын гаалийн байгууллагаас ирүүлсэн хариултын нэгтгэл (2016 оны 12 дугаар сар) .....	47

Хавсралт 2. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын заалтууд: Тусгай хавсралт F, Дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай, мөн татвар буцаан олгох тухай 1, 2 болон З дугаар бүлэг .....	61
Хавсралт 3. Барааг дотоодод болон гадаадад боловсруулахтай холбогдсон хууль тогтоомж, заавар, дүрэм журам, өргөдлийн маягт зэргийг агуулсан гишүүн орнуудын вэбсайтуудын хаяг.....	76
Хавсралт 4. Зөвшөөрлийн маягтын загварууд .....	81
Хавсралт 5. Гишүүн орнуудын нөхцөл байдлын судалгаа .....	127

## I. ОРШИЛ

ДГБ-ын Техникийн байнгын хороо өөрийн 213/214 дүгээр чуулганаараа Дэлхийн үнийн сүлжээ (DYC)-ний талаар, мөн улс орнууд ДYC-нд илүү гүн гүнзгий татагдан оролцоход гаалийн байгууллага хэрхэн тус дэм болох талаар хэлэлцсэн болно. Техникийн байнгын хороо нь дотоодод болон гадаадад боловсруулах горимыг хэрэгжүүлж буй ажлын арга туршлага зэрэг энэ чиглэлээр гишүүн орнуудаас өнөөдрийг хүртэл авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, арга туршлагын талаар авч хэлэлцсэн.

Техникийн байнгын хороо ДYC-г хөгжүүлэх зорилгоор дотоодод болон гадаадад боловсруулах горимын одоогийн зааврыг шинэчлэх, эсхүл нэмэлт баримт бичиг боловсруулах, мөн өөр бусад арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр болсон. Ингээд ДГБ-ын Нарийн бичгийн даргын газраас 2016 оны 12 дугаар сард дотоодод болон гадаадад боловсруулах горимын талаар судалгаа авсан бөгөөд энэ дагуу 78 гишүүн орон өөрсдийн хууль тогтоомж, дүрэм журам, мэдээллийн технологи, засаглал (удирдлага) зэрэг олон асуултад хариулт өгсөн байна.

Энэхүү гарын авлагыг дээрх судалгааны үр дүн, гишүүн орнуудаас гаргаж өгсөн нэмэлт мэдээлэл, түүний дотор зарим нэг хууль тогтоомж, зөвшөөрлийн маятууд, заавар зэргийг үндэслэн 2017 оны 5 дугаар сард боловсруулан гаргав. Судалгааны хүрээнд өгсөн хариултыг энэхүү гарын авлагын Хавсралт 1-ээс нэгтгэсэн байдлаар харах боломжтой.

Тус гарын авлага нь шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын тусгай хавсралт F (дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай 1, 2 дугаар бүлэг)-ийн зааварт сууриссан бөгөөд ДГБ-ын гишүүн орнуудад ашиглаж буй дотоодод болон гадаадад боловсруулах горим, мэдээллийн технологийн шийдэл, засаглалын (удирдлагын) тогтолцоог зохицуулсан янз бүрийн хууль тогтоомж, дүрэм журмаас

ДГБ-ын гишүүн орнуудад мэдээлэл өгөх зорилготой болно. Гадаадад боловсруулах горимоос дотоодод боловсруулах горим ашиглах нь илүү түгээмэл байдаг учир энхүү гарын авлага нь дотоодод боловсруулах горимд тулхүү анхаарав.

Эдгээр горим нь аж ахуйн нэгжүүдийн хувьд өндөр ашиг тустай гэдгийг бодолцож, гишүүн орнууд болон аж ахуйн нэгжүүдийн аль аль нь эдгээр горимыг бүр сайн ашиглахыг уриалж, дэмжиж байна. Ингэснээр эдийн засгийн өрсөлдөх чадвар дээшилж, ялангуяа худалдааг улам бүр хөнгөвчлөх болно. Мөн гишүүн орнууд ДҮС-нд хамрагдах нөхцөл бүрдэнэ. ДХБ-ын 2017 оны 2 дугаар сард хүчин төгөлдөр болсон Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр (10.9 дэх заалт)-т дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай дэлгэрэнгүй заалт үндэсний хууль тогтоомжид заавал байх ёстой гэж заасан байдгийг анхаарч ажиллах нь юу юунаас чухал болно.

Аж ахуйн нэгжүүд нь дотоодод болон гадаадад боловсруулах горимын ашиг тусын талаар илүү сайн ойлголттой болох хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд гаалийн байгууллага эдийн засгийн ашиг тустай эдгээр горимын талаарх тэдний (бизнесийнхний) ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх боломжийг энхүү гарын авлага бүрдүүлж өгч байна.

## II. УДИРТГАЛ

Дэлхийн худалдааны 80 орчим хувь нь Дэлхийн үнийн сүлжээ (DYC)-гээр дамжин явагдаж байгаа гэж бодвол бараа нийлүүлэх сүлжээ улам даяарчлагдаж, худалдааны бодлого болон түүнтэй холбоотой бодлогыг илүү дэс дараатай, уялдаа холбоотой байдлаар авч үзэх шаардлагатай болж байна.

Үйлдвэрлэлийг хэсэгчлэн хуваасан нь хөгжиж буй орнууд болон жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ-үүд) өөрсдөө бүхэл бүтэн үнийн сүлжээ бий болголгүйгээр уг үнийн сүлжээний нэг бүрдэл хэсэг, эсхүл үйлчилгээ үзүүлэгч болж дэлхийн зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж байгаа юм. ЖДҮ-үүд ихэвчлэн завсрлын бүтээгдэхүүн нийлүүлж, туслан гүйцэтгэгчээр оролцож байна. Цахим худалдаа нь DYC өргөжин тэлж, улмаар ЖДҮ-үүд тус сүлжээнд нэгдэн ороход чухал үүрэг гүйцэтгэж байна. Түүний зэрэгцээ DYC нь ялангуяа үйлдвэрлэлийн шат дамжлага хооронд болон олон улс даяар найдвартай зохицуулалт, эрчимтэй уялдаа холбоо бий болгох хэрэгцээ шаардлага байгаа гэдэг үүднээс авч үзвэл пүүсүүдийн хувьд шинэ эрэлт бий болгож байна. Гэвч хэрэв илүү олон улс оролцож, олон талт яриа хэлэлцээний үндсэн дээр зах зээлээ нээж өгвөл илүү ихийг хожих юм. Гуравдагч орнуудын хооронд тулгараах саад тогтор нь шууд худалдаа эрхэлж буй түншүүдийн хооронд тогтсон саад тогторой адил байх бөгөөд эдгээрийг хамтад нь авч үзвэл илүү дээр учир DYC нь олон талт хэлэлцээг урагшлуулах эдийн засгийн үндсийг бэхжүүлж өгдөг.

### **Гаалийн горим болон худалдааг хөнгөвчлөх арга хэмжээнээс Дэлхийн үнийн сүлжээнд үзүүлэх нөлөө**

DYC-нд оролцох оролцоог зөвхөн худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогоо өөрчлөн шинэчлэх замаар бус бас гаалийн дүрэм журам, ложистикийг сайжруулах замаар хөхүүлэн дэмжиж болно.

Олон улсын дүрэм, журам, стандарт нь ДҮС-тэй холбоотой хэлцлийг улам хялбар дөхөм болгодог. Бодлогын чанартай саад тогтор болон хүнд суртлаас ихээхэн хамааралтай байдаг гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ДҮС-нд оролцох гол хэрэгсэл юм.<sup>1</sup> Орчин үед бараа бүтээгдэхүүн нь эхлээд түүхий эд байдлаар, дараа нь эцсийн бүтээгдэхүүн байдлаар хилээр олон удаа нэвтэрдэг тул бараа нийлүүлэх сүлжээний хэвийн жигд ажиллагааг хангахын тулд гаалийн дүрэм журам, ложистик нь түргэн шуурхай, үр ашигтай байдлыг хангах ёстой. Үйлдвэрлэлийн үе шатанд аутсорсинг хайж байгаа гаднын компаниудын хувьд түүхий эдийг түргэн шуурхай оруулж, хугацаанд нь найдвартай гаргадаг улс орон хамгаас чухал хэрэгтэй юм. Иймээс дэлхийн үйлдвэрлэлийн сүлжээнд нэгдэх, дэлхийн зах зээлд гарах явдлыг дэмжихэд худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ чухал болно<sup>2</sup>.

Хувийн хэвшлийн хүрээнд явуулсан судалгаанаас үзэхэд ялангуяа толгой компаниудын хувьд нэгдүгээрт гаалийн дүрэм журам, дараа нь стандарт хангах асуудал хөгжиж буй улсын бэлтгэн нийлүүлэгчийг ДҮС-нд татан оруулахад хамгийн их саад болдог болох нь харагдаж байна.

ДҮС-нд гүн гүнзгий нэгдэн ороход тус дөхөм болох худалдааг хөнгөвчлөх арга хэмжээнд дотоодод болон гадаадад боловсруулах горимууд, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн болон итгэмжлэгдсэн худалдаа эрхлэгчийн хөтөлбөрүүд, нэг цонхны систем, бараа олголтыг гаалийн татвар ногдуулахаас тусгаарлах арга ажиллагаа, урьдчилсан шийдвэр гаргах зэрэг арга хэмжээ хамаарна.

1 П.Ковалски болон бусад зохиогч (2015), “Дэлхийн үнийн сүлжээнд хөгжиж буй орнууд оролцож буй байдал: Худалдааны болон худалдааны холбогдолтой бодлогод үзүүлэх нөлөө”, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын худалдааны бодлогын баримт бичгүүд, №179, ЭЗХАХБ-ын Хэвлэх үйлдвэр, Парис хот. [http://www.oecdilibrary.org/trade/participation-of-developing-countries-in-global-value-chains\\_5js33lfw0xxn-en](http://www.oecdilibrary.org/trade/participation-of-developing-countries-in-global-value-chains_5js33lfw0xxn-en).

2 ЭЗХАХБ, ДХБ, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурал, “Худалдаа, хөрөнгө оруулалт, хөгжил, ажлын байранд Дэлхийн үнийн сүлжээний үзүүлэх нөлөө”, 2013 оны 8 дугаар сарын 6, ОХУ-ын Санкт Петербург хотноо 2013 оны 9 дүгээр сард болсон G-20-ын тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтад зориулж бэлдсэн.

### III. БОЛОВСРУУЛАХ ГОРИМ АШИГЛАН ХИЙГДЭХ ХУДАЛДАА (НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН ХУДАЛДАА – PROCESSING TRADE)

ДҮС-ний төрон хэлхээг дурандан харах нэг өвөрмөгц тал нь боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) юм. Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа гэдэг нь компаниуд түүхий эдээ өөр өөр улсаас авч, өөр нэг улсад угсарч, эцсийн бүтээгдэхүүнийг гуравдагч орны зах зээлд гаргах процесс юм. Энэ нь сүүлийн 10 жилд, ялангуяа Хятадын экспортод чухал үүрэг гүйцэтгэж байна.<sup>3</sup>

БНХАУ боловсруулах горимыг 1979-2016 оны хооронд ашиглан хийгдэх худалдааны нийт импорт, экспортын үнийн дүн 235 сая ам.доллараас 1,112.58 тэрбум ам.доллар болж өссөн бөгөөд түүний Хятадын гадаад худалдаанд эзлэх хувь нь 1.5%-иас 30.2% хүртэл нэмэгдсэн. Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдааны ачаар шууд байдлаар 40 сая, шууд бус байдлаар 60 сая ажлын байр бий болсон. Хятадын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа нь Хятад оронд өөрчлөлт, шинэчлэлт хийгдэж, нээлттэй бодлого явуулсан цагаас эхлэн ийнхүү хурдацтай өссөн юм; энэ нь Хятадын аж үйлдвэржилтийн процессыг хурдасгах, аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөн шинэчлэх ажлыг идэвхжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, Хятадын эдийн засгийг дэлхийн эдийн засгатай нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. (Хятадын нөхцөл байдлын дэлгэрэнгүй судалгааг энэхүү гарын авлагын V хавсралтад оруулав).

Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/ДХБ-ын Нэмүү өртөг шингэсэн худалдааны мэдээллийн сангаас үзэхэд Хятадаас гадна Ирланд,

3 Л.Цернат болон М.Пажот (2012), “Европт угсрav – Бараа боловсруулах горим ашиглан хийгдэх худалдааны Европын Холбооны экспортод гүйцэтгэх үүрэг”. [http://trade.ec.europa.eu/doclib/docs/2012/october/tradoc\\_150006.pdf](http://trade.ec.europa.eu/doclib/docs/2012/october/tradoc_150006.pdf)

Люксембург, Малайз, Сингапур, Бүгд Найрамдах Словянк улс, Тайланд, Тунис, Вьетнам зэрэг өөр бусад улс орны нийт экспортод эзлэх ДҮС-ний хувь хэмжээ өндөр байна. Энэ тохиолдолд экспортод гаргах бараа, үйлчилгээ үйлдвэрлэх зорилгоор гаднаас түүхий эд оруулах (эргуулэн татах) явдал өндөр байна гэсэн үг юм.

Улс орнуудыг ДҮС-нд илүү гүнзгий татан оролцуулахын тулд гаалийн боловсруулах горимуудтай холбоотой одоогийн стандарт, практик ажиллагааг сайтар судалж, сайжруулах шаардлагатай байгаа асуудлуудыг анхаарч үзэх нь чухал. Үүнд үндсэндээ дараах горимууд хамаарах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй:

**i. дотоодод боловсруулах горим** (гаалийн татвар, бусад татвар, эсхүл хяналт шалгалтаас чөлөөлөх боломжийг ашиглан барааг түр хугацаагаар оруулан боловсруулж, буцаан гаргах горим);

**ii. гадаадад боловсруулах горим** (гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөх боломжийг ашиглан завсрлын бүтээгдэхүүнийг түр хугацаагаар гарган боловсруулж, буцаан оруулах горим).

Бараа боловсруулах өөр бусад хэд хэдэн горим байна. Тухайлбал, чөлөөт бүсийн горим, баталгаат бүсийн горим, барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах горим г.м. Харин энэхүү гарын авлагад зөвхөн дотоодод болон гадаадад боловсруулах горимыг чухалчлан авч үзсэн болно. Энэ 2 горим нь ялангуяа ЖДҮ-үүдийг ДҮС-нд улам гүнзгий татан оролцуулахад шаардлагатай худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ бөгөөд дотоодод боловсруулах горим нь боловсруулалтын бусад горимуудтайгаа ихээхэн хамааралтай болохыг анхаарах хэрэгтэй. Тус гарын авлагад тусгагдсан асуудлыг үндсэндээ худалдааг хөнгөвчлөх өнцгөөс авч үзсэн хэдий ч барааны бүрэн бүтэн бөгөөд аюулгүй байдлыг хангах, татварын орлого бүрдүүлэх зорилго

бүхий гаалийн хяналт шалгалтын өөр бусад нэн чухал ач холбогдолтой үүрэг ролийг үл хөндсөн болно.

### **а. ДГБ-ЫН СТАНДАРТ, БАРИМТ БИЧИГ, АРГА ХЭРЭГСЭЛ**

Барааг дотоодод, эсхүл гадаадад боловсруулахтай холбоотой ДГБ-ын стандартуудыг шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын “боловсруулах горим”-ын тухай тусгай хавсралт F –ээс харж болно. Энэ хавсралт нь дөрвөн бүлэгтэй: 1-р бүлэг нь дотоодод боловсруулах горимын тухай, 2-р бүлэг нь гадаадад боловсруулах горимын тухай, 3-р бүлэг нь татвар буцаан олгох тухай, 4-р бүлэг нь барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах горимын тухай болно. Шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын тусгай хавсралт F-ийн 1-3 дугаар бүлгийн заалтуудыг энэхүү гарын авлагын II хавсралтад оруулсан болно.

ДҮС-нд хамаарлтай хамгийн чухал бүлэг нь 1 болон 2 дугаар бүлэг, мөн тэдгээрийг дагалдах зааврууд юм. Эдгэр бүлэг болон тэдгээрийн зааварт холбогдох горимын ашиг тус, үйлчлэх хүрээ, зөвшөөрлүүд, хяналт, аудит, шалгалт, түхий эд, барааг ялган таних арга хэрэгсэл г.м. зүйлсийн талаар тусгагдсан байдаг. Мөн холбогдох зааварт хаягдалд бүрдүүлэлт хийх тухай; гаалийн өөр горим (өөрөөр хэлбэл, дамжуулан өнгөрүүлэх горим, эсхүл гаалийн агуулахын, эсхүл чөлөөт бүсийн горим)-д байсан барааг боловсруулах журмын тухай; тодорхой нэг улсаас ирсэн бараанд хориг, хязгаарлалт тавихгүй байх тухай; орлох бүтээгдэхүүнд орсон импортын барааны тоо хэмжээг тодорхойлох аргын тухай; зөвшөөрөл олгох тухай; барааг дотоодод болон гадаадад боловсруулах үйл ажиллагааны тайлан бүртгэлийн тухай; буцаж үйлчлэх зөвшөөрөл олгох тухай; ерөнхий зөвшөөрөл олгох тухай; бүтээмжийн хувь хэмжээний тухай; импортын барааны эзэмших эрхийг шилжүүлэх тухай; гуравдагч этгээдийн гүйцэтгэх боловсруулалтын үйл ажиллагааны тухай; импортын барааг буцаан гаргахад тавих хяналтын

журмын тухай; импортын барааг, эсхүл орлох бүтээгдэхүүнийг гаалийн өөр горимд байршуулах замаар боловсруулалтын горимыг дуусгавар болгох тухай зэрэг мэдээлэл тусгагдсан байдаг.

Гэхдээ өнөөдрийн байдлаар шинэчлэн найруулсан Киотогийн конвенцын Хэлэлцэн тохиролцогч 110 талын зөвхөн цөөн хэд нь F хавсралтын холбогдох бүлгүүдэд нэгдэн орсон байна: 1-р бүлэгт 24 улс (үүнээс 6 нь тайлбартайгаар), 2-р бүлэг хүртэл 24 улс (үүнээс 4 нь тайлбартайгаар) гарын үсэг зурсан байна.

## **b. Дотоодод боловсруулах горим (Inward processing)**

Үндэсний хууль тогтоомжид барааг тодорхой зорилгоор үйлдвэрлэж, боловсруулж, эсхүл засвар үйлчилгээ хийсний дараа экспортлох тохиолдолд импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор чөлөөлөх тухай заасан байдаг. Энэ нь дотоодод боловсруулах горим юм.

Дотоодод боловсруулах горим нь буцаан гаргахаас өмнө боловсруулалт хийх импортын бараанд татварын хөнгөлөлт олгодог гаалийн ганц горим буюу практик ажиллагаа биш юм. Энэ зорилгоор бас татвар буцаан олгох горим, эсхүл чөлөөт бусийн горим ашиглаж болно. Дотоодод боловсруулах горимын үндсэн зорилго нь өөрийн бараа, үйлчилгээгээ өрсөлдөхүйц үнээр гадаадын зах зээлд гаргах боломжийг үндэсний үйлдвэрийн газруудад олгох явдал юм. Ингэснээр тэд эдийн засгийн өсөлтийг хангаж, дотоодын ажлын байрыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Зарчмын хувьд дотоодод боловсруулах горим нь импортын гаалийн болон бусад татвар (үүнд импортын бараанд ногдуулдаг НӨАТ, эсхүл бараа, үйлчилгээний татвар зэрэг дотоодын албан татвар хамаарна)-аас болзолтойгоор бүрэн чөлөөлөх боломж олгодог. Гэвч тухайн барааг боловсруулах, эсхүл үйлдвэрлэх явцад гарсан хаягдалд импортын гаалийн болон бусад татвар ногдуулж болно.

## Канад

### Өөдөс буюу хаягдал

Импортын барааг боловсруулаад экспортлох тохиолдолд боловсруулах үйл ажиллагаанаас гарсан өөдөс буюу хаягдлыг бас Татвараас чөлөөлөх хөтөлбөрийн дагуу татвараас чөлөөлж болно. Гэвч уг өөдөс буюу хаягдлыг экспортоор гаргалгүйгээр импортлох бөгөөд тэдгээр нь арилжааны үнэ цэнэтэй, бас импортын татвартай бол татвараас чөлөөлгөхгүй. Энэ тохиолдолд хаягдалд хамаарах гаалийн татварыг төлөх ёстай. Тийм өөдөс буюу хаягдал үүссэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж буй гаалийн татварын хувь хэмжээг баримтална.

Тухайн импортын барааг үйлдвэрлэж, боловсруулж, эсхүл засвар үйлчилгээ хийсний дараа буцаан гаргавал зохино. Тийм үйлдвэрлэл, боловсруулалт, засвар үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг “орлох бүтээгдэхүүн” гэдэг. Эдгээр орлох бүтээгдэхүүнийг зөвхөн дотоодод боловсруулах горимд байршуулсан бараанаас гаргаж авах албагүй. Тэдгээрийг үйлдвэрлэхдэд дотоодын (үндэсний) гарал үүсэлтэй бараа, эсхүл өмнө нь импортын гаалийн болон бусад татвар төлсөн бараа ашиглах шаардлагатай байж болно.

Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулсны дараа шууд дотоодод боловсруулах горимд байрлуулж болно. Түр хугацаагаар оруусан бараа, гаалийн дамжин өнгөрөх горимд байгаа бараа, гаалийн агуулахаас, эсхүл чөлөөт бүсээс гаргаж буй барааг бас дотоодод боловсруулах горимд байршуулж болохоор байх ёстай. Барааг анх оруулахад байршуулсан гаалийн горимыг зохих ёсоор дуусгавар болгох явдлыг түүнийг дотоодод боловсруулах горимд байршуулах урьдчилсан нөхцөл болгож болно.

Энэхүү гаалийн горим нь олон талын ашиг тустай. Худалдааны үүднээс авч үзвэл гол ашигтус нь гэвэл экспортлох зорилготой үйлдвэрлэлд ашиглах, эсхүл боловсруулах импортын барааг гаалийн болон бусад татвар төлөлгүйгээр үйлдвэрлэх буюу боловсруулах боломж юм. Тухайн улсад тусах гол ашиг тус нь гэвэл дотоодын эдийн засаг бараа боловсруулах буюу үйлдвэрлэх энэхүү үйл ажиллагааны хэр хэмжээгээр нэмэгдэн тэлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татсан салбарын өрсөлдөх чадвар дээшлэхийн зэрэгцээ эдийн засгийн үйл ажиллагаа ийнхүү өсөн нэмэгдсэний улмаас шууд татварын орлого нэмэгдэх боломж бүрдэж байгаа явдал болно.

Дотоодод боловсруулах горимын хүрээнд зөвхөн худалдааны барааг боловсруулах нийтлэг асуудал яригдаад зогсохгүй бас гаднын харилцагч нь тухайн импортын барааны эзэмшигч (өмчлөгч) хэвээр байх асуудлыг зохицуулсан гэрээ буюу "ажлын байр"-ны асуудал яригдах болно.

Дотоодод боловсруулах горимын утга нь заавал барааны үнэ өргтийг өсгөх ямар нэгэн томоохон өөрчлөлт хийх ёстой гэсэн үг бас биш юм. Энэ горимоор бас барааг савлах, тээвэрлэлтэд зориулж баглаж боох, дахин савлах зэрэг жижиг ажилбар хийж болно.

Зөвшөөрөл олгох нэг урьдчилсан нөхцөл нь эцсийн бүтээгдэхүүнд орсон импортын барааг ялган таних боломжтой байх явдал юм.

### **Монтенегро**

Эцсийн бүтээгдэхүүнд орсон импортын барааг дараах байдлаар ялган таниж болно:

- тусгай дугаар буюу тодорхойлолт (бичиглэл) ашиглах, тухайлбал серийн дугаар ашиглах;
- тамга тэмдэг, лац ломбо, мөн өөр бусад тэмдэглэгээ тавих;
- загвар (дээж, сорьц) авах, зураг авах, эсхүл техникийн тодорхойлолт авах;
- шинжилгээ хийх;
- дотоодод боловсруулах горимын явцыг тусгасан бөгөөд тухайн эцсийн бүтээгдэхүүнийг импортын бараагаар үйлдвэрлэсэн болох нь тодорхой харагдах бүртгэл мэдээлэл болон өөр бусад бичиг баримтыг шалгах.

### **с. Гадаадад боловсруулах горим (Outward processing)**

Үндэсний хууль тогтоомжид чөлөөт эргэлтэд байсан барааг түр хугацаагаар гарган түүнийг ашиглан үйлдвэрлэл явуулж, боловсруулалт хийж, эсхүл засвар үйлчилгээ хийсний дараа эцсийн бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар мэдүүлсэн бол импортын гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөхөөр заасан байх нь олонтаа тохиолддог. Татвараас ийнхүү чөлөөлсөн гаалийн горимыг гадаадад боловсруулах горим гэдэг.

Гадаадад боловсруулах горимын үндсэн зорилго нь үндэсний үйлдвэрийн газруудад үйлдвэрлэлийн өртөг зардлаа бууруулах боломж олгох, улмаар холбогдох бүтээгдэхүүнийг илүү өрсөлдөхүйц үнэ өртөгтэй болгоход оршино. Энэ утгаар “боловсруулах” гэдэг нэр томъёонд гадаадад боловсруулах горимын тодорхойлолтод заасан

үйлдвэрлэл, боловсруулалтын үйл ажиллагаанаас гадна барааг савлах, тээвэрлэлтэд зориулж баглаж боох, дахин савлах ажилбарууд хамаарна. Үйлдвэрлэл явуулах, боловсруулалт хийх үйл ажиллагаанд ч гэсэн бас жижиг ажилбар хийгдэж байгаа бараа бүтээгдэхүүн хамаарна.

Бараагаа энэ горимд байршуулах өргөдөл гаргах тохиолдолд бараа боловсруулахаар төлөвлөсөн үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэхээргүй байх ёстой гэсэн болзол нөхцөл тавьж болно. Барааг гадаадад боловсруулсны дараа оруулж ирэхэд татвараас ихэвчлэн хэсэгчлэн чөлөөлдөг. Гэвч тийм барааг, ялангуяа гадаадад үнэ төлбөргүй засварласан барааг татвараас бүрэн чөлөөлж болно. Ийнхүү чөлөөлөх гаалийн болон бусад татварт НӨАТ, эсхүл бараа, үйлчилгээний татвар зэрэг барааг импортоход үед ногдуулдаг дотоодын татварууд бас хамаарна.

Гадаадад боловсруулах горимоор чөлөөт эргэлтэд байгаа барааг гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргах боломж олгож байгаа. Тэгэхээр гадаадад боловсруулах горимын үр дүнд бий болсон орлох бүтээгдэхүүнийг нь импортын гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж болно.

Иймээс бүрмөсөн гаргах горимд байршуулсан барааг бодвол гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байсан барааг түр хугацаагаар гаргаад (засвар үйлчилгээ хийж, бараа үйлдвэрлэгдэж, эсхүл өөр бараанд шингээсний дараа) гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах тохиолдолд чөлөөт эргэлтэд байгаа хэвээрээ гэж үзэх бөгөөд импортын гаалийн болон бусад татвараас (бүрэн, эсхүл хэсэгчлэн) чөлөөлнө.

Энэ үүднээс, түр хугацаагаар гаргасан барааг ялган таних арга хэмжээ авбал зохих бөгөөд ингэснээр тийнхүү түр хугацаагаар гаргасан бараанаас бүрэн, эсхүл хэсэгчлэн гаргаж авсан орлох бүтээгдэхүүнийг ялган тогтоох боломжтой болно.

Холбогдох барааг экспортлох үед түүнийг гадаадад боловсруулах горимд байршуулахаар мэдүүлсэн байх нь чухал. Холбогдох экспортын мэдүүлэг нь нэг талаас экспортлогч уг барааг гадаадад боловсруулах горимд байршуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн баримт бичиг болох бөгөөд нөгөө талаас гаалийн байгууллага аливаа шаардлагатай хяналт шалгалт хийх албан ёсны баримт бичиг болох юм.

Зарим гаалийн байгууллага энэ горимыг дотоодод боловсруулах горимын дагуу гаалийн нутаг дэвсгэрт байсан бараанд бас ашигладаг. Эдгээр гаалийн байгууллагын хувьд тухайн экспортын барааг, эсхүл орлох бүтээгдэхүүнийг буцаан оруулахад дотоодод боловсруулах горимд дахин байршуулж болно.

## IV. ГИШҮҮН ОРНУУДЫН ТУРШЛАГА

### а. Хууль тогтоомж, дүрэм журам

Судалгааны дүнгээс харахад хариулт өгсөн бараг бүх гишүүн орон дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай заалт бүхий хууль тогтоомжтой байна. Нэг гишүүн орон саяхан тийм хууль тогтоомжтой болсон бол өөр нэг гишүүн орон удахгүй тийм хууль тогтоомжтой болох шатандаа явж байна.

Гэвч энэхүү гарын авлагад дурдсан дотоодод болон гадаадад боловсруулах горим гэдгээс арай өөр, янз бүрийн нэр томъёо ашигласан байdag. Дотоодод боловсруулах горимыг зарим тохиолдолд гаалийн татвараас чөлөөлөх болон гаалийн татварыг буцаан олгох хөтөлбөр (duty relief and duty drawback programs), эсхүл барааг боловсруулсан тохиолдолд татварыг хорогдуулан тооцох горим (rebate due to processing of goods) гэж нэрлэсэн байdag.

Мөн хууль эрхзүйн өөр өөр шийдлүүд байна. Жишээлбэл, дотоодод боловсруулах горимд бараа байршуулах зөвшөөрөл олгоходоо тухайн аж ахуйн нэгж заавал холбогдох гаалийн нутаг дэвсгэрт байгуулагдсан байх ёстой гэсэн шаардлага тавьдаггүй байна. Зарим тохиолдолд зүйтэй гэж үзвэл зөвшөөрөл олгосон этгээд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгуулагдсан байж болдог.

Энэхүү гарын авлагын III хавсралтад хууль тогтоомж, заавар, дүрэм журам, өргөдлийн маягт болон барааг дотоодод болон гадаадад боловсруулах схемийг ДГБ-ын гишүүнчлэлийн хүрээнд сайтар боловсруулсан болохыг тодорхой харуулсан бусад хэрэгцээтэй материал агуулсан гишүүн орнуудын вэбсайтын хаяг (холбоос, линк)-ыг жагсаан оруулсан байгаа. Гэвч эдгээр дүрэм журам нь нарийвчлалын түвшингийн хувьд өөр өөр байна. Зарим гишүүн орнууд дотоодод болон гадаадад боловсруулах горимыг аль ч

салбарт мөрдөх ерөнхий дүрэм журамтай байдаг бол зарим нь тодорхой салбарт мөрдөх тухайлсан дүрэм журамтай байна. Тодруулбал, ялангуяа дотоодод боловсруулах горимын үзэл санаа нь тухайн улс орны экспортыг дэмжих, аж үйлдвэрийн хөгжил болон эдийн засгийн өсөлтийг дээшлүүлэх зэрэг өөр өөр зорилго чиглэлтэй байсан учир эдийн засгийн янз бүрийн орчин нөхцөлөөс шалтгаалж өөр өөр загварууд гаргасан байдаг.

Гэвч дотоодод болон гадаадад боловсруулах горимууд бүгд нэг ижил зарчим дээр тогтсон байна. Энэ нь: үйлдвэрлэл явуулах, боловсруулалт хийх, эсхүл засвар үйлчилгээнд явуулах зорилгоор бараа оруулах/гаргах, мөн уг барааг гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж буцаан гаргах/оруулах.

Мөн судалгаанаас харахад ялангуяа барааг дотоодод боловсруулах дүрэм журам нь эдийн засгийн үр нөлөө бүхий гэгдэх өөр бусад дүрэм журамтай нягт холбоотой байдаг байна.

## **i. Эдийн засгийн үр нөлөө бүхий дүрэм журам**

Гишүүн орнууд нь барааг дотоодод болон гадаадад боловсруулах дүрэм журмаас гадна тийм зорилготой бөгөөд худалдаа эрхлэгч нарыг гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөх боломж бүхий бараа боловсруулах өөр бусад дүрэм журам нэвтрүүлсэн байна. Зарим гишүүн оронд эдгээр дүрэм журмыг эдийн засгийн үр нөлөө бүхий дүрэм журам, гаалийн болон бусад татвараас чөлөөлөх болон тэдгээрийг хойшлуулах схем (duty and tax relief and suspension schemes), эдийн засгийн дэглэм (economic regimes), гаалийн тусгай дэглэм (special Customs regimes) зэргээр нэрлэдэг байна.

Жишээлбэл, судалгаанаас харахад гишүүн орнуудын 50 гаруй хувь нь дараах журмыг хэрэгжүүлж байна:

- барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах горимын журам;
- чөлөөт бүсэд боловсруулах журам.

Түүнээс гадна гишүүн орнууд дараах журмуудыг мөрддөг болохоо мэдэгдсэн байдаг:

- баталгаат бүсэд боловсруулалт хийх журам (processing in a bonded area),
- экспортын бараа боловсруулах бүсэд боловсруулалт хийх журам (processing in an export processing zone),
- чөлөөт боомтын журам (free ports),
- аж үйлдвэрийн агуулахын журам (industrial warehousing),
- татваргүйгээр дүүргэлт хийх (бараа татах) журам (duty-free replenishment),
- гаалийн хяналтад доор боловсруулалт хийх журам (processing under Customs control),
- заримыг нь (зарим барааг) экспортог зорилгоор боловсруулалт хийх журам (processing for partial exportation),
- бүгдийг нь (бүх барааг) экспортог зорилгоор боловсруулалт хийх журам (зөвхөн экспортын бараа үйлдвэрлэдэг компаниудын хүрээнд) (processing for full exportation (within completely export-oriented companies)), гм.

Судалгааны явцад дээр дурдсан журмуудыг нарийвчлан тодруулаагүй. Гэвч эдгээр журам нь хэдийгээр өөр өөр нэртэй боловч өөр хоорондоо олон талаараа ижил төстэй байх өндөр магадлалтай. Эдгээр журам нь барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимд, эсхүл бүрмөсөн гаргах горимд байршуулах хүртэл татвараас чөлөөлөгдөх, эсхүл татвараа хойшлуулах боломжийг худалдаа эрхлэгч наарт олгох замаар худалдааг хөнгөвчлөх давуу талтай байна

Эдгээр бүх журам нь дотоодын үйлдвэрлэгч нарт тусгайлан давуу тал олгох, мөн эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэсэн их бага хэмжээгээр ижил төстэй зорилго өвөрлөсөн байдаг. Дотоодод боловсруулах горимын журам нь баталгаат бүсэд, эсхүл чөлөөт боомтод боловсруулалт хийх журамтай харьцуулбал нэг давуу талтай. Жишээлбэл, хяналт тавих болон хууль дүрэм зөрчих, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тал дээр баталгаат бүсийн хувьд өртөг зардал өндөртэй байдаг.

### Мексик

Мексик улс нь дотоодод болон гадаадад боловсруулах горимоос гадна түүнтэй адил зорилго бүхий, гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөх тал дээр худалдаа эрхлэгч нарт ашигтай өөр бусад хэд хэдэн журамтай байдаг:

- Бараа үйлдвэрлэх, өөрчлөлт оруулах, эсхүл засвар үйлчилгээ хийх зорилгоор түр хугацаагаар оруулах журам (*IMMEX*);
- Баталгаат агуулахын горимоор бараа үйлдвэрлэх, өөрчлөлт оруулах, эсхүл засвар үйлчилгээ хийх журам (*Recinto Fiscalizado Estrategico*);
- Баталгаат агуулахын горимоор автомашин угсралт, үйлдвэрлэх процессын журам (*Deposito Fiscal*).

## ii. Татвар буцаан олгох горим (Drawback procedure)

Татвар буцаан олгох горим нь дотоодод боловсруулах горимтой нягт холбоотой. Энэ горимд зааснаар барааг экспортлох тохиолдолд тухайн экспортын бараанд агуулагдаж буй, эсхүл түүнийг үйлдвэрлэхэд зарцуулагдсан

бараа, материалд төлсөн импортын гаалийн болон бусад татварыг (бүрэн, эсхүл хэсэгчлэн) буцаан олгодог. Ихэнх аж ахуйн нэгж дотоодод боловсруулах горимын дагуу түүхий эд оруулан, гаалийн болон бусад татвараас шууд чөлөөлөгдж, татвар буцаан олгох хүсэлт гаргахгүй байхыг илүүд үздэг. Нөгөө талаас төр засгийн хувьд татвар хойшлуулах схем нэвтрүүлэхээр татварын орлого алдагдах эрсдэл учирдаг учир татвар буцаан олгох горим нэвтрүүлснээр татварын орлогыг илүү сайн хянаж, татвар буцаан олгох процесст хяналт тавих боломж бүрддэг.

Судалгааны үр дүнгээс харахад хариулт өгсөн улсуудын 66 хувь нь татвар буцаан олгох системийг нэвтрүүлсэн байгаа бөгөөд эндээс үзэхэд ихэнх гишүүн орнууд дээр дурдсан хоёр горимын аль нэгийг сонгож ашиглах боломжийг бүрдүүлсэн байгаа нь илт байна.

### **Австрали**

Татвар буцаан олгох схем нь импортын барааг засч сайжруулсан, боловсруулсан, эсхүл экспортын бараа үйлдвэрлэхэд зарцуулсан, эсхүл анх оруулснаас хойш ашиглалгүйгээр экспортолсон бол тухайн импортын бараанд төлсөн гаалийн татвараа буцаан авах боломжийг экспортлогч нарт олгодог.

Энэхүү гарын авлагын III хавсралтад Татвар буцаан олгох схемийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан Австралийн цагаачлал, хил хамгаалах газрын вэб хуудасны линк байгаа.

### **iii. Татварын баталгаа (Guarantee)**

Зөвшөөрөл олгохын өмнө ихэвчлэн татварын баталгаа шаарддаг. Татварын баталгаа нь нэг удаагийн (тодорхой

нэг буюу хэд хэдэн бараанд хамаарахаар), эсхүл ерөнхий (бүх буюу ямар ч бараанд хамаарахаар) байж болно. Нэг удаагийн баталгааг гаалийн нэг мэдүүлгээр дотоодод, эсхүл гадаадад боловсруулах горимд байршуулах барааны хувьд шаарддаг бол ерөнхий баталгааг дотоодод, эсхүл гадаадад боловсруулах горимын дагуу нэгээс дээш тооны гаалийн мэдүүлэг үйлдсэн тохиолдолд шаарддаг байна.

Судалгаанаас харахад ихэнх гишүүн орнууд (78%) татварын баталгааг үндсэндээ дотоодод боловсруулах горимын хувьд шаардаж байна. Татварын баталгаа нь ерөнхийдөө банкны баталгаа, даатгалын баталгаа, байгууллагын (компанийн) баталгаа, эсхүл мөнгөн хадгаламж зэрэг хэлбэртэй байдаг байна.

Зарим гишүүн орнууд Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн статустай компаниудаас банкны баталгаа шаарддаггүй байна.

### **Камбож**

Тусгай зөвшөөрөлтэй худалдаа эрхлэгч болон тусгай зөвшөөрөлтэй гаалийн зуучлагч нарын дансан дахь хадгаламж нь дотоодод болон гадаадад боловсруулах горимд шаардагдах баталгаа болно.

### **Монгол**

Мэдүүлэгч (татвар төлөгч) гаалийн болон бусад татвар төлөх баталгааг дараах хэлбэрээр гаргаж болно:

- a) гаалийн хилээр нэвтрүүлж буй бараа, эсхүл мөнгөн хөрөнгө барьцаалах;
- b) банкны баталгаа гаргах;
- c) олон улсын гэрээнд заасан бусад хэлбэр.

#### iv. Зөвшөөрөл (Authorization)

Дотоодод болон гадаадад боловсруулах горимд бараа байршуулах зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авах ёстой бөгөөд түүнийг хүсэлт хүлээн авсанын хойш тодорхой хугацаанд олгоно. Эрх бүхий байгууллага гэдэг нь гаалийн байгууллага, эсхүл эдийн засгийн бодлогыг үндэслэж тийм зөвшөөрөл олгох эрх бүхий өөр байгууллага байж болно. Гэхдээ тухайн горимд заасан бүх болзол нөхцөл хангагдсан эсэхийг гаалийн байгууллага баталгаажуулна (Зөвшөөрлийн маягтын загваруудыг энэхүү гарын авлагын IV хавсралтад үзүүлэв.)

Зарим гишүүн оронд зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага нь тухайн аж ахуйн нэгж Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн статустай эсэхээс хамаарч өөр өөр байна. Хэрэв тухайн аж ахуйн нэгж нь итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж биш бол хууль дагаж мөрдөх нарийн дүрэм журамтай болохоо харуулах өөрийн үнэлгээний хуудас (асуултууд) бөглөх шаардлага гарч болно.

Дотоодод боловсруулах горимд бараа байршуулах зөвшөөрлийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь тухайн бүтээгдэхүүнээс хамааран өөр өөр байдаг. Боловсруулсан барааг экспортловол зохих ердийн хугацаа нь 1 жил байх боловч зарим төрлийн барааны хувьд арай урт хугацаа (өөрөөр хэлбэл, гурав, эсхүл дөрвөн жил) байж болно. Түүнчлэн аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сунгаж болно. Гэхдээ сунгалтыг дотоодод боловсруулах тухайн горим дуусгавар болохоос өмнө хийнэ.

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүнийн хувьд тусгай нөхцөл тавих тохиолдол олонтаа байдаг. Тэдгээрийг экспортлох хугацаа нь арай богино (өөрөөр хэлбэл, 6 сар) байдаг бөгөөд гол төлөв бүтээмжийн стандарт хувь хэмжээ хэрэглэдэг.

Дотоодод боловсруулах горимоор үйлдвэрлэл явуулсны үр дүнд эцсийн үндсэн бүтээгдэхүүн, өөрөөр хэлбэл, тухайн


горимыг батлах болсон гол бараа бий болно. Эцсийн үндсэн бүтээгдэхүүний зэрэгцээ бас дайвар бүтээгдэхүүн гарч болно. Энэ тохиолдолд тийм дайвар бүтээгдэхүүнийг холбогдох зөвшөөрөлд бас заах шаардлагатай болдог.

### **Серби**

Дайвар бүтээгдэхүүний хувьд гаалийн байгууллагаас баталсан бурдүүлэлтийн өөр бусад зарим горим, ашиглах нөхцөлийг тодорхойлон өгч болно. Тэдгээрийг буцаан гаргаж, чөлөөт эргэлтэд оруулж, эсхүл гаалийн хяналтын дор устгаж болно (хэрэв тэдгээрийг хаягдал гэж үзвэл Хог хаягдлын менежментийн тухай хуулийн дагуу ажиллах хэрэгтэй). Мэдүүлэгч нь уг дайвар бүтээгдэхүүнийг цааш нь хэрхэхээ (ямар горимоор бурдүүлэлт хийлгэхээ) өөрөө мэднэ. Гэвч уг бүтээгдэхүүний шинж байдалд хяналт тавих ёстой. Мөн бусад дүрэм журам (тухайлбал, байгаль орчныг хамгаалах журам)-д заасан хориг, хязгаарлалтыг дагаж мөрдөнө. Зөвшөөрөл эзэмшигч нь дайвар бүтээгдэхүүнийг гаалийн хяналтын дор устгах хүсэлт (өргөдөл) гаргасан бол Гаалийн агуулахад байгаа барааг устгах журмын тухай Гаалийн даргын 2012 оны б дугаар сарын 13-ны өдрийн 148-03-030-01-131/2012 тоот тушаалын дагуу арга хэмжээ авна. Уг тушаалд өөр олон арга хэмжээ заасны зэрэгцээ холбогдох байгууллагаас дээрх хаягдалд лабораторийн шинжилгээ хийлгэсэн баримт (Хаягдалд шинжилгээ хийсэн тайлан илтгэл болон Эрчим хүч, хөгжил, байгаль орчныг хамгааллын яамнаас уг хаягдлыг хэрхэх тухай санал дүгнэлт)-ыг дээрх өргөдлийн хамт ирүүлэхийг заасан байдаг. Гэвч зөвшөөрөл эзэмшигч нь дайвар бүтээгдэхүүнийг чөлөөт эргэлтэд оруулах эрхтэй байна. Энэ тохиолдолд бас дээрх бичиг баримтыг бурдүүлнэ.

ДГБ-ын судалгаанаас харахад ерөнхийдөө гаалийн байгууллагууд нь зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага болсон байна. Гэвч зарим тохиолдолд гаалийн байгууллагын зэрэгцээ Худалдааны яам, эсхүл Сангийн яам зөвшөөрөл олгож болохоор байна. Түүнээс гадна, барааны нэр төрлөөс хамаарч, Аж үйлдвэрийн яам, Хөрөнгө оруулалт, хөгжлийн яам, Хөдөө аж ахуйн яам, Эрчим хүч, уул уурхайн яам зэрэг салбарын яамд зөвшөөрөл олгож болохоор байна.

**Зураг 1.** Дотоодод болон гадаадад боловсруулах горимын зөвшөөрөл олгож буй эрх бүхий байгууллага



### Ерөнхий зөвшөөрөл (General authorization)

Дотоодод болон гадаадад боловсруулах горимоор байнгын үйл ажиллагаа явуулдаг худалдаа эрхлэгч нарт ерөнхий зөвшөөрөл олгох нь холбогдох худалдаа эрхлэгч болон гаалийн байгууллагын аль алиных нь ажлыг хөнгөвчилсөн арга хэмжээ болдог. Ийм худалдаа эрхлэгч нь ерөнхийдөө гаалийн хууль тогтоомж сайн мөрддөг гэсэн үнэлгээтэй байх учир гаалийн байгууллага түүний үйл ажиллагаанд байнгын

хяналт тавиад байх шаардлагагүй байдаг. Энэ нь гаалийн байгууллага нэг удаагийн зөвшөөрөл олон удаа олгож, тэр бүгдийг хянах хүн хүч, бичиг цаасны зардлыг хэмнэж өгдөг. Ерөнхий зөвшөөрөл олгоходо дотоодод боловсруулах горимд байршуулах барааг тодорхой тоо хэмжээгээр, мөн боловсруулалтын үйл ажиллагааг тодорхой цаг хугацаагаар хязгаарлах нөхцөл тавьж болно.

### **Хялбарчилсан зөвшөөрөл (Simplified authorization)**

Ихэнх гишүүн орон дотоодод болон гадаадад боловсруулах горимын зөвшөөрөл олгох хялбаршуулсан журамтай байдаг. Ерөнхийдөө дараах тохиолдолд уг журам үйлчилнэ:

- Дотоодод болон гадаадад боловсруулалх горимд бараа байршуулах импортын, эсхүл экспорттын зөвхөн нэг мэдүүлэг үйлдсэн бол тухайн мэдүүлэг нь өөрөө зөвшөөрөл болно;
- Хэрэв импортлогч/экспортлогч нь ерөнхий зөвшөөрөлтэй бол түүнийг үндэслэн дотоодод болон гадаадад боловсруулах горимд бараа байршуулж болно;
- Бага үнийн дүнтэй ачилтын хувьд;
- Зарим нэр төрлийн бараанд;
- Зарим төрлийн боловсруулах үйл ажиллагаанд;
- Аюул ослын үед итгэмлэн хүргэх барааны хувьд (систем ажиллахгүй тохиолдолд), г.м..

Дотоодод болон гадаадад боловсруулах горимд бараа байршуулах импорт/экспорттын мэдүүлгийг ерөнхийдөө хялбаршуулсан зөвшөөрөл гэж үзэж болох боловч жил жилээр тооны хязгаарлалт (өөрөөр хэлбэл, гурвуун нэг гэсэн хязгаарлалт) тавьсан байдаг бөгөөд үүнээс хэтэрвэл худалдаа эрхлэгч зохих ёсны зөвшөөрөл авах шаардлагатай болдог.

### **Финлянд (EX-ны бүх гишүүн оронд хамааралтай)**

Хялбарчилсан зөвшөөрөл олгох шалгуурыг үндсэндээ ЕХ-ны гаалийн тухай хууль (EU952/2013)-иар эрх олгосны дагуу гаргасан дагавар хууль (the delegated act EU2015/2446)-ийн 163 дугаар зүйлд заасан байдаг:

- хэрэв 71-02 дугаар хавсралт (эмзэг (хориглосон, хязгаарласан) барааны, гол төлөв хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний жагсаалт)-д заасан бараанаас бусад барааг дотоодод боловсруулах горимд байршуулах бол;
- хэрэв 71-02 дугаар хавсралт (эмзэг (хориглосон, хязгаарласан) барааны, гол төлөв хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний жагсаалт)-д заасан бараанаас бусад барааг гадаадад боловсруулах горимд байршуулах бол;
- хэрэв гадаадад боловсруулах горим ашиглах зөвшөөрөл олгосон бөгөөд тус зөвшөөрөлд заагаагүй сэлбэг хэрэгслийг сольж тавих стандарт систем ашиглаж чөлөөт эргэлтэд оруулах бол;
- хэрэв гадаадад боловсруулах горимоор боловсруулсан барааг чөлөөт эргэлтэд оруулах бөгөөд боловсруулалх ажиллагаа нь арилжааны бус бараанд хамааралтай бол.

Гэхдээ нь энэ нь дараах тохиолдолд хамаarahгүй:

- хялбарчилсан мэдүүлэг;
- төвлөрсөн бүрдүүлэлт;
- мэдүүлэгчийн бүртгэл тооцоонд байгаа мэдээлэл;
- нэгээс илүү гишүүн орноос түр хугацаагаар оруулах биш зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол;

- дээрх хуулийн 223-р зүйлийн дагуу адил бараа ашиглах хүсэлт гаргасан бол;
- дээрх хуулийн 211(6) дугаар зүйлийн дагуу эдийн засгийн болзол нөхцөлийг шалгах шаардлагатай гэж эрх бүхий гаалийн байгууллагаас мэдүүлэгчид мэдэгдсэн бол;
- дээрх хуулийн 167(1)(f) дүгээр зүйлд 71-02 дугаар хавсралт (эмзэг (хориглосон, хязгаарласан) барааны, гол төлөв хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний жагсаалт)-ыг мөрдөхөөр заасан бол;
- дээрх хуулийн 211(2) дугаар зүйлийн дагуу буцаж үйлчлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол, гэхдээ үүнд энэ зүйлийн 1(e), эсхүл (f) хэсэгт заасан тохиолдлууд хамаарахгүй).

## Швейцарь

Гаалийн газар нь дараах төрлийн бараа болон боловсруулалтын хувьд холбогдох мэдүүлгийг хүлээн зөвшөөрөх замаар хялбарчилсан зөвшөөрлийг ёс журмын ажиллагаа шаардалгүйгээр, мөн үнэ төлбөргүйгээр олгох эрхтэй байна:

- Хувийн хэрэглээний бүх төрлийн бараа (бүх төрлийн боловсруулалт)
- Засвар үйлчилгээ
- Нөхөн сэргээх ажил

Бүх төрлийн арилжааны бараа (хэвлэх, өнгөлөх зэрэг энгийн ажиллагаа, гэвч хялбарчилсан журмын дагуу эдгээр ажиллагаа нь хосолсон байж болохгүй).

## **Буцаж үйлчлэх зөвшөөрөл (Retrospective authorization)**

Тусгай хавсралт F-ийн 1 дүгээр бүлгийн практик зөвлөмж 10-т заасан зарчим нь өмнө нь дотоодын хэрэглээнд зориулан оруулсан барааг дотоодод боловсруулах горимд байршуулах зорилгоор буцаж үйлчлэх зөвшөөрөл авах боломжийг худалдаа эрхлэгч нарт олгож байгаа. Тус зөвшөөрлийн үндсэн давуу тал нь гэвэл гаалийн болон бусад татвараа татвар буцаан олгох горимоос илүү түргэн шуурхай байдлаар буцаан авах боломжийг худалдаа эрхлэгч нарт олгодог. Зарим тохиолдолд бусад горимын дагуу буцаан авах боломжгүй гаалийн болон бусад татварыг эргүүлэн авах боломжийг худалдаа эрхлэгч нарт бас олгодог. Гэвч худалдааг хөнгөвчлөх энэ арга хэмжээ нь тухайн аж ахуйн нэгж түүнийг хэдэн удаа ашиглаж болох вэ гэдэг дээр ихэвчлэн хязгаарлалт тогтоосон байдаг.

## **Бусад төрлийн зөвшөөрөл**

Зарим улс оронд тодорхой бараа (өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуйн бараа)-нд олгодог тусгай зөвшөөрөл зэрэг өөр төрлийн зөвшөөрөл байдаг. ЕХ-ны гишүүн орнуудын өөр нэг жишээ гэвэл нэг барааг нэгээс дээш тооны гишүүн оронд боловсруулсан тохиолдолд олгодог Хамтын нийгэмлэгийн нэгдсэн зөвшөөрөл (Single Community authorization)-ийг дурдаж болно. Бас цогц зөвшөөрөл (integrated authorizations) гэж байдаг. Энэ зөвшөөрлөөр гаалийн бусад горим (өөрөөр хэлбэл, гаалийн агуулахын горим, гадаадад боловсруулах горим, гм)-ыг хамруулан боловсруулалт хийж болдог

## v. Техникийн тодорхойлолтыг баталгаажуулах (Validation of Specifications)

Дотоодод болон гадаадад боловсруулах горимоор боловсруулах барааны зарим шаардлагатай техникийн тодорхойлолт, нормативыг баталгаажуулж шалгах нь гаалийн байгууллагын хувьд амаргүй даалгавар юм. ДГБ-ын судалгаагаар техникийн тодорхойлолтыг үндэслэж баталгаажуулах аргын талаар асуусан байгаа. Оролцогч гишүүн орнууд олон хариултаас сонголт хийх замаар хариулт өгсөн байгаа.

Тухайлбал, судалгаанд оролцсон гишүүдийн 70 хувь нь янз бүрийн бүтээгдэхүүнд зориулж тусгайлан боловсруулсан шалгуур болон техникийн ерөнхий тодорхойлолтыг үндэслэн үнэлж баталгаажуулдаг гэж хариулсан байна. Мөн 76% нь хэрэв гаалийн байгууллага үйлдвэрлэлийн процессын талаар тайлан илтгэл шаарддаг бол тухайн үйлдвэрлэгчээс, эсхүл зөвшөөрөл авах хүсэлт гаргасан талаас хүлээн авсан мэдээллийг үндэслэдэг гэж хариулжээ. Гаалийн байгууллага ихэнх тохиолдолд худалдаа эрхлэгчээс өгсөн мэдээллийн үнэн зөвийг шалгахын тулд боловсруулах гэж байгаа, эсхүл боловсруулсан бараанаас дээж авах, баримт бүртгэл шалгах, аргачлал хүсэх зэрэг аль шаардлагатай арга хэмжээ авах боломжтой байдаг. Техникийн тодорхойлолтыг бас салбар чиглэлийн нийгэмлэгүүдтэй зөвлөлдөх замаар баталгаажуулж болно.

Олон гишүүн оронд тухайн төрлийн бараа хариуцсан яамны, эсхүл хориг, хязгаарлалтын асуудал хариуцсан яамны заавар зөвлөмжийг үндэслэсэн баталгаажуулалт хийдэг байна. Зарим тохиолдолд гишүүн орнууд мэдээллийн үнэн зөвийг шалгахын тулд өөр бусад арга хэрэглэдгээс гадна нийгмийн санаа бодол (нийгмийн дунд түгсэн ойлголт, common knowledge)-ыг харгалзан үздэг гэж мэдэгдсэн байна.

## Швейцарь


Салбар чиглэлийн нийгэмлэгүүдийн заавар зөвлөмжийг үндэслэлдэг.

## Бүгд Найрамдах Киргиз Улс

Гаалийн байгууллага нь тухайн техникийн тодорхойлолтыг үнэлж баталгаажуулахдаа аль нэг боловсруулах горимын зөвшөөрөл авахаар мэдүүлэгчээс гаалийн байгууллагад гаргаж өгсөн өргөдөл, мөн технологийн холбогдох процессыг тодорхойлсон, түүний дотор дараах ажиллагаа явуулахаар заасан баримт бичгийг үндэслэлдэг байна:

1. Гадаадын барааны үзүүлэлт өөрчлөгдтөл барааг цэвэршүүлэх, эсхүл боловсруулах ажиллагаа;
2. Бараа үйлдвэрлэх, түүний дотор барааг сууринуулах, угсрах, задлах, эсхүл тохируулж тааруулах ажиллагаа;
3. Барааг засварлах, түүний дотор сэргээн зэсварлах, эд ангийг сольж тавих ажиллагаа;
4. Цэвэршүүлсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түүхий эд болгон ашиглах, эсхүл түүний үйлдвэрлэлийг хөнгөвчлөх ажиллагаа. Ийнхүү барааг дахин боловсруулах явцад холбогдох барааг ашиглаж, бүрэн, эсхүл хэсэгчлэн зарцуулсан байж болно. Энэ ажиллагаа нь энэ заалтын 1-3 дахь хэсэгт заасан аль нэг ажиллагаатай зэрэг явагдах ёстай.

**Зураг 2.** Техникийн тодорхойлолтыг үнэлж баталгаажуулах арга



**vi. Хяналт (мониторинг), аудит**

Дотоодод боловсруулах горимын заалтыг зөв мөрдөх, мөн хяналт шалгалтыг хөнгөвчлөхийн тулд гаалийн байгууллага нь бүртгэл тооцоог ерөнхийдөө тодорхой хэдэн жилээр хадгалахыг эрх авсан этгээдээс шаарддаг, эсхүл тийнхүү хадгалах нөхцөлийг бүрдүүлж өгдөг байна. Тус бүртгэл тооцоо нь холбогдох горимд байршуулсан барааны тоо хэмжээ болон гаргаж авсан (үйлдвэрлэсэн), мөн буцаан гаргасан/буцаан оруулсан орлох бүтээгдэхүүний тоо хэмжээ, түүний дотор тухайн процесст ашигласан гаалийн бүх мэдүүлэг, бараа худалдах, худалдан авах гэрээнүүдийг нотлох баримт зэрэг боловсруулалтын ажиллагаанд хяналт тавих, мөн түүнчлэн төлбөл зохих импортын гаалийн болон бусад татварын бодолт зөв эсэхэд хяналт тавихад шаардлагатай бүх мэдээ баримтыг агуулсан байх ёстой. Тус бүртгэл тооцоонд бас дотоодод болон гадаадад боловсруулах горимын барааг

орлох бүтээгдэхүүнээс ялган таних арга, мөн бүтээмжийн хувь хэмжээг тодорхойлох аргыг тусган харуулсан байх ёстай. “Бүртгэл тооцоо” гэдэг нэр томъёог холбогдох этгээдийн бүх данс, бүртгэл, тооцоо хамрагдахаар тайлбарлаж өгсөн байх ёстай.

Дотоодод боловсруулах горимыг уг горимыг ашиглах бүх нөхцөл хангагдсан, мөн боловсруулсан бүтээгдэхүүн, эсхүл өөрчлөлт оруулаагүй барааг: гаргасан, гаалийн өөр горимд шилжүүлсэн, өөр компанийд шилжүүлсэн, чөлөөт эргэлтэд оруулсан, гаалийн хяналтын дор устгасан бол дуусгавар болсон гэж үзнэ.

Худалдаа эрхлэгч нь дотоодод болон гадаадад боловсруулах горимд байршуулсан бүх барааг хариуцан ажиллах бөгөөд аудитыг ерөнхийдөө хэзээ ч хийж болно.

Аудитыг ерөнхийдөө гаалийн байгууллага (өөрөөр хэлбэл, бүрдүүлэлтийн дараах аудитын хэлтэс) хийдэг. Судалгаанаас харахад гаалийн байгууллагаас гадна Үндэсний аудитын газар, Гадаад худалдааны аудитын ерөнхий газар, Татварын газар зэрэг төрийн байгууллагууд, мөн Үндэсний технологийн лаборатори зэрэг бусад байгууллага аудит хийдэг байна.

### **Монтенегро**

#### **2.7. Горим дуусгавар болгоход шаардлагатай мэдээллийн жагсаалт**

Дотоодод боловсруулах горимын зөвшөөрөл олгосон гаалийн байгууллага нь дотоодод боловсруулах горимын хэрэгжилтэд хяналт тавих үүднээс уг горимоор оруулах импортын барааны тоо хэмжээ, боловсруулах бүтээгдэхүүний тоо хэмжээ, уг горимын хэрэгжилтэд хяналт тавихад шаардлагатай өөр бусад бүхий л мэдээ бүхий бүртгэл тооцоо

хөтлөхийг зөвшөөрөл эзэмшигчээс шаардаж болно.

Бас үүсч болзошгүй татварын өрийг зөв тооцохыг шаардаж болно.

Зөвшөөрөл эзэмшигч нь холбогдох горимыг зохих ёсоор ашиглаж буй эсэхэд хяналт тавих зорилгоор гаалийн байгууллага шаардсан бол дээрх бүртгэл мэдээг түүнд гаргаж үзүүлнэ.

Зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээлэл бүхий татварын тооцооны маятныг хяналт тавьж буй гаалийн байгууллагад хүргүүлэх үүрэг хүлээнэ:

- а) зөвшөөрлийг таньж тогтоох боломжтой мэдээлэл;
- б) импортын бүх төрлийн барааны тоо хэмжээ, мөн уг горимыг эхлүүлсэн гаалийн мэдүүлгийн талаарх мэдээлэл;
- с) импортын барааны гаалийн тарифын ангилал;
- д) импортын барааны гаалийн үнэ болон төлбөл зохих импортын татварын хувь хэмжээ;
- е) импортын барааны зарцуулалтын норм хэмжээ;
- ф) гаргаж авсан бүтээгдэхүүний шинж чанар, тоо хэмжээ, тухайн бүтээгдэхүүний зөвшөөрөгдсөн орцын талаарх мэдээлэл, эдгээрийн хамт холбогдох мэдүүлгийн талаарх мэдээлэл, ялангуяа зөвшөөрөл хүссэн өргөдлийн талаарх мэдээлэл;
- г) гаргаж авсан бүтээгдэхүүний үнэ, горим дуусгавар болгох үед ашигласан үнэлгээний арга;
- х) ... 251-р зүйлийн З дахь хэсэгт заасны дагуу чөлөөт эргэлтэд оруулсан импортын барааны тоо хэмжээнд төлөх импортын гаалийн татварын хувь хэмжээ.

Зөвшөөрөл эзэмшигч нь ерөнхий маягт бөглөн дотоодод боловсруулах горим дуусгавар болох өдрөөс хойш гуч хоногийн дотор гаалийн байгууллагад илгээнэ.

## b. Мэдээллийн технологийн тус дэм


### i. Гаалийн байгууллага

Үйлдвэрлэгч нь хэд хэдэн орноос хэд хэдэн төрлийн түүхий эд оруулж, дараа нь эцсийн бүтээгдэххүнийг өөр өөр улс руу хэд хэдэн ачилтаар экспортлох зорилгоор дотоодод боловсруулах горим ашиглаж болно. Уг процессын зарим нэг дамжлагаас үүдэн холбогдох барааны хөдөлгөөнд хяналт тавихад бэрхшээл үүсдэг. Энэ асуудал гадаадад боловсруулах горимын хувьд ч мөн адил байна. Тиймээс үр ашигтай автоматжуулсан систем нэвтрүүлснээр зардлыг буруулж, үйлчилгээний хүргэлтийг үлэмж сайжруулж, илүү олон хэрэглэгчийг эдийн засгийн үр нөлөө бүхий горим руу татан оролцуулна. Уг систем нь эдгээр горимд зохих ёсоор хяналт тавих, мөн татварын орлого алдагдахаас сэргийлэхэд бас хэрэгтэй.

Гаалийн байгууллагууд импортын барааг буцаан гаргаж буй байдлыг хянах зорилгоор мэдээллийн технологийн янз бүрийн шийдэл болон арга ашигладаг. Судалгааны үр дүнгээс үзэхэд дотоодод болон гадаадад боловсруулах горимын хувьд мэдээллийн технологи ашиглах явцад зарим нэг саад бэрхшээл байгаа бөгөөд дотоодод болон гадаадад боловсруулах горимыг бүрэн автоматжуулаагүй, эсхүл мэдээллийн технологи ашиглан эдгээр горимд бүрэн хяналт тавьж чадахгүй байгаа байдал харагдаж байна. Ингэхээр бид ерөнхийдөө автомат хяналтын процессыг цаг хугацаа, өртөг зардал их шаардсан гар ажиллагаатай хослуулж байгаа байдлыг харж байна.

Зарим тохиолдолд мэдээллийн технологийг зөвхөн дотоодод (гадаадад биш) боловсруулах горимын хувьд ашиглаж байна. Мөн мэдээллийн технологийн системийг өргөдөл илгээх, зөвшөөрөл олгох, эсхүл олгосон зөвшөөрлийн мэдээллийн санг хөтлөхөд ашиглаж байна.

**Зураг 3.** Импорт/экспортын барааг буцаан гаргах/оруулах явдлыг автоматаар хянахад мэдээлэл, холбооны технологийн систем ашиглаж буй байдал



Энэ асуултад хариулсан 70 гишүүн орноос 37 нь дотоодод болон гадаадад боловсруулах горимд байршуулсан барааг буцаан гаргах/оруулах явдлыг мэдээллийн технологийн систем ашиглан автоматаар хянаж байгаа гэсэн бол 10 нь бүрэн бус байдаар, жишээлбэл, зөвхөн дотоодод боловсруулах горимыг хянаж байгаа гэжээ. Барааг хилээр буцаан нэвтрүүлэх хугацааг автоматаар удирдан зохицуулж байгаа жишээ байгаа боловч уг горимуудын хэрэгжилтэд хяналт тавьж буй гаалийн газар холбогдох горимыг зохих ёсоор дуусгавар болгох ажиллагааг гар аргаар хянах шаардлагатай болдог байна.

Системдээ техникийн тодорхойлолтыг тусгадаг эсэх асуудлыг авч үзвэл судалгаанд оролцогчдын тал хувь нь тусгадаг гэсэн бол нөгөө тал нь тусгадаггүй гэжээ.

## Хятад

Хятадын гаалийн байгууллагаас (гаалийн) баталгаат горимын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэд хэдэн үе шаттайгаар явуулдаг байна. Хяналтын зорилгоор эхлээд цаасан хэлбэрийн бүртгэл тооцооны дэвтэр хөтөлж байсан байна. Харин одоо боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны баталгаат горимын бараанд хяналт тавихдаа улс даяараа "Н2010" гэсэн мэдээллийн систем ашиглаж байна. Аливаа нэг үйлдвэрийн газар нь боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны бизнес эрхэлж эхлэхээс өмнө гаалийн байгууллага дээр худалдааны барааг боловсруулах бүртгэл тооцооны хуудас (буюу данс бүртгэлийн дэвтэр) нээлгэх ёстай; тухайн үйлдвэрийн газар нь импортын материалын, мөн түүнчлэн буцаан гаргасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг бүртгэж байхын зэрэгцээ бас оруулсан материал болон гаргасан бүтээгдэхүүн хоорондын тоон хамаарлыг нэгж зарцуулалтын зарим төрлийн стандартын дагуу тооцож, бүртгэл тооцооны хуудас (буюу данс бүртгэлийн дэвтэр)-ны хаалтыг тогтмол хийж байх ёстай байна. Үүнтэй холбогдуулан 2 төрлийн загвар (модуль), тухайлбал бүртгэл тооцооны цахим хуудасны загвар болон данс бүртгэлийн цахим дэвтрийн загварыг боловсруулсан байна. Бүртгэл тооцооны цахим хуудасны загварын хувьд менежментийг гэрээ тус бүрээр явуулна, өөрөөр хэлбэл, цахим дансанд анх тусгагдсаны дагуу гэрээ тус бүрээр нэг бүртгэл тооцооны хуудас хөтөлж, тооцоог нэг бүрчлэн хийнэ. Данс бүртгэлийн цахим дэвтрийн загварын хувьд менежментийг үйлдвэрийн газар тус бүрээр явуулна, өөрөөр хэлбэл, холбогдох нэг үйлдвэрийн газрын бүх гэрээнд данс бүртгэлийн зөвхөн нэг цахим дэвтэр хөтөлнө. Данс бүртгэлийн цахим дэвтрийн загвар нь гаалийн хяналтын тусгай бүсэд ажилладаг үйлдвэрийн газруудад, мөн эдгээр бүсийн гадна ажилладаг хэдий ч том бөгөөд нэр хүнд өндөртэй зарим үйлдвэрийн газарт хамаарлтай.

### **Канад**

Дотоодод боловсруулах горимын хувьд эрх бүхий оролцогч нарт үл давтагдах дугаар бүхий гэрчилгээ олгодог. Энэ дугаарыг хожим нь экспортлох барааг импортлох үед гаалийн татвараас чөлөөлөхөд ашигладаг.

Гадаадад боловсруулах горимын хувьд эрх бүхий оролцогч нар нь холбогдох барааг боловсруулсны дараа импортлох үед гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх зорилгоор ердийн дугаар бүхий зөвшөөрөл болон нягтлан бодохын бүртгэл тооцоог ашигладаг.

## **ii. Аж ахуйн нэгж**

“Хяналт (мониторинг), аудит” гэсэн хэсэгт дурдсанчлан, худалдаа эрхлэгч нь дотоодод болон гадаадад боловсруулах горимд байршуулсан бүх барааг хариуцан ажиллах бөгөөд аудитыг ерөнхийдөө хэзээ ч хийж болно. Мэдээллийн технологийн зах зээл нь худалдаа эрхлэгч нар дотоодод болон гадаадад боловсруулах горимын дагуу хөтлөх бүртгэлийг янз бүрийн аргаар шийдэх тус дэмтэй санаа өгдөг. Тэр нь материалын нөөцийг үйлдвэрлэлд нарийн төвөгтэй байдлаар, олон шат дамжлагтайгаар зарцуулах данс бүртгэлийн янз бүрийн арга (шийдэл) ашиглах боломж олгож байгаа. Эдгээр арга шийдэл нь бүх үйл ажиллагааг найдвартай, ил тод байдлаар явуулах нөхцөлийг хангасан, түүний дотор үнэлгээ хийх, бүртгэл тооцоо хөтлөх, бараа материалын нэгдсэн бүртгэл хөтлөх зэрэг олон төрлийн апплейкшн (хэрэглээний програм)-тэй байж болно. Мэдээллийн технологийн зарим шийдэл нь гаалийн агуулахын горим, дотоодод болон гадаадад боловсруулах горим зэрэг гаалийн олон янзын горимд бараа байршуулах, тэдгээрээс гаргах, барааг нэг горимоос нөгөөд шилжүүлэх явцад компаниуд

янз бүрийн бүртгэл тооцоо хөтлөх боломжийг бүрдүүлдэг. Заримыг нь дотоодод боловсруулах горимоор татвараас чөлөөлөх модуль (IPR (inward processing relief) modules) гэдэг бөгөөд эдгээр нь барааг боловсруулах явцад хяналт тавих шаардлагатай бүх функцуудыг агуулсан байдаг. Эдгээр нь бас холбогдох барааг гуравдагч улс орон руу гаргасан мэдээлэл, мөн өөр бусад шаардлагатай мэдээллийг гаалийн байгууллагад гаргаж өгөх боломж олгодог.


### **с. Удирдлага (Governance)**

Гаалийн бусад горимуудтай харьцуулбал дотоодод болон гадаадад боловсруулах горимууд нь илүү нарийн төвөгтэй бөгөөд гаалийн байгууллага болон холбогдох аж ахуйн нэгж тэдгээрийн ашиг тусыг бүрэн гүйцэд хүртэхийн тулд дээд түвшний оролцоо чухал байдаг. Гаалийн байцаагч нарын болон аж ахуйн нэгжүүдийн, ялангуяа ЖДҮ-ийн газруудын эдгээр горимын талаарх ерөнхий ойлголтыг дээшлүүлэх, тэдэнд зориулсан байнгын сургалт явуулах, мөн түүнчлэн хяналт, шалгалт (monitoring and control)-ыг зохих ёсоор явуулахад тус дэм болох мэдээллийн технологийг хөгжүүлэх үүрэг амлалтыг дээд түвшинд авсан байхыг шаарддаг.

### **і. ДГБ-ын гишүүн орнуудад дотоодод/гадаадад боловсруулах горим ашиглаж буй байдал**

Аж ахуйн нэгжүүд дотоодод/гадаадад боловсруулах горимыг ямар түвшинд ашиглаж байгааг тогтоох зорилгоор тухайн улсын түвшинд дотоодод/гадаадад боловсруулах горим ашиглаж байгаа худалдаа эрхлэгч нарын тоо, эдгээр горимын дагуу бүртгэгдсэн мэдүүлгийн тооны талаар судалгаа явуулж, өөр бусад зүйлийн зэрэгцээ тухайн улсын эдийн засгийн болзол нөхцөлийг харуулсан тооцоо судалгааг гаргаж ирсэн. Доорх графикуудаар судалгааны үр дүнг харуулав.

**Зураг 4.** 2015 онд дотоодд, гадаадад боловсруулах горим ашигласан аж ахуйн нэгжийн тоо



Дээрх судалгаагаар бас эдгээр горимыг бага ашиглаж байгаагийн шалтгааныг судалж, хэд хэдэн хүчин зүйлсийг тодруулсан байдаг. Үүнд: ойлголт хангалтгүй (9 гишүүн оронд); аж ахуйн нэгжүүдтэй зөвлөлдэж ойлголцох ажил дутмаг (5); эдгээр горим нь нарийн төвөгтэй (2); гаалийн байгууллагаас өндөр шаардлага тавьдаг (1). Бас гадаадад боловсруулах горим ашиглах салбар дутмаг, эсхүл үндэсний хэмжээнд эдийн засгийн идэвхжил сүл зэрэг өөр шалтгаан байгааг тодруулсан байна.

### **Мавритиус**

Тарифын жагсаалтын 90 гаруй хувьд нь тарифын хувь хэмжээ заагаагүй, мөн НӨАТ-ын бүртгэлд бүртгүүлсэн импортлогч нар нь бараа оруулах үедээ НӨАТ төлж, буцаан гаргасан тохиолдолд НӨАТ-аа буцаан авах боломжтой байна. Энэ нь дотоодод боловсруулах горим ашиглах сонирхлыг дэмжсэн алхам болж чадахгүй байна.

## **ii. Мэдээлэл хүргэж буй байдал**

Дотоодод/гадаадад боловсруулах горим нь нарийн төвөгтэй учир холбогдох мэдээллийг аж ахуйн нэгжүүд хялбархан олж авах боломжтой байх нь чухал юм. Эдийн засгийн үр нөлөө бүхий эдгээр горимыг ашиглах этгээдэд зориулсан заавар, жишээ нь олж авахад төвөггүй, уншиж танилцахад амар хялбар байх шаардлагатай. Ийм мэдээллийг англи, эсхүл франц хэл дээр гаргавал бас нэг давуу тал нэмэгдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг илүү сайн татах боломжтой болно.

Судалгаанаас хараход дээрх мэдээллийг гол төлөв гаалийн байгууллагын вэбсайт дээр, түүний дотор аж ахуйн нэгжүүдэд тусгайлан зориулсан вэб хуудсууд дээр нийтэлдэг байна. (Өмнө дурдсанчилан, гишүүн орнуудын вэбсайтуудын

хаяг (холбоос, линк)-ийг энэхүү гарын авлагын III хавсралтад оруулсан байгаа.) Гэвч гаалийн байгууллагууд бас эдгэр горим болон тэдгээрийн ашиг тусын талаар түгээмэл тавьдаг асуулт, хариулт бэлдэн нийтэлж, үйлдвэрлэлийн салбарт холбогдох заавар хүргүүлж, хурал уулзалт, сургалт зохион байгуулж, телевизийн хөтөлбөр бэлдэн явуулдаг байна.

### Зураг 5. Мэдээлэл хүргэж буй байдал



### iii. Сургалт

Дээрх судалгаагаар сургалт явуулж буй байдлыг судалсан бөгөөд ихэнх гаалийн байгууллага (47) анхан шатны мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд дотоодод болон гадаадад боловсруулах горимын сургалт явуулдаг бол цөөн тооны гаалийн байгууллага зөвшөөрөл олгодог хүмүүст зориулан (41), эсхүл аудит хийдэг хүмүүст зориулан (38) тусгай сургалт явуулдаг болох нь тогтоогдоо. Бас зарим нэг гишүүн улс (19)-д менторингийн арга (дагалдуулан сургах арга)-ыг гол төлөв сургалтын хажуугаар ашигладаг байна.

Дотоодод болон гадаадад боловсруулах горимууд нь эдийн засгийн хувьд үр ашигтай ч гэсэн ихэнх тохиолдолд нэлээд ярвигтай, төвөгтэй байдаг учир тэдгээрийг ашиглах этгээдээс нарийн мэдлэг боловсрол шаарддаг байна. Гаалийн байгууллага болон хувийн хэвшлийн аль аль нь аж ахуйн

нэгжид зориулсан сургалт курс зохион байгуулж, дотоодод болон гадаадад боловсруулах горим ашиглах этгээдэд хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтыг ойлгуулж мэдүүлэх, эдгээр горимтой холбоотой мэргэжлийн уг хэллэг, нэр томъёог зааж сургах, өргөдөл гаргах журмыг танилцуулах, татварын баталгаа гаргах шаардлагатай болохыг ойлгуулах, дотоодод/гадаадад боловсруулах горимд хамааралтай захиргааны процессыг танилцуулах, дотоодод/гадаадад боловсруулах горим ашиглаж буй бусад худалдаа эрхлэгч нартай харьцах харилцааг эзэмшүүлэх зэрэг арга хэмжээ авч байна. Сургалтаар ихэвчлэн ямар дотоод процесс шаардлагатай болох талаар (өөрөөр хэлбэл, компани дотроо юу хийх, ямар юм бүрдүүлэх шаардлагатай талаар), дотоодод боловсрууях горим ашиглах компани өөрийн бичиг баримтын загварыг хянуулахаар авчирч өгөх боломжтой эсэх талаар, мөн тухайлбал дотоодод болон гадаадад боловсруулах горимын аудит болон итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн эрх авахад тавигдах шаардлага хоёрын уялдаа холбооны талаар мэдээлэл өгдөг байна. Хэрэв шаардлагатай бол сургалтын хөтөлбөрт өргөдлийн маят бөглөх, мөн гаалийн байгууллагад илгээх тайлан боловсруулах дадлагын хичээл оруулж өгдөг байна. Түүнээс гадна эдийн засгийн үр нөлөө бүхий өөр бусад горимтой ямар холбоотой болох, мөн тухайн компанийн хувьд аль горим хамгийн ашигтай болох талаар зааж сургавал сайн юм.

Нөгөө талаас, дотоодод/гадаадад боловсруулах горимын барааны техникийн тодорхойлолтыг баталгаажуулах үүрэгтэй гаалийн байцаагч, зөвшөөрөл олгодог гаалийн байцаагч, ялангуяа аудит хийдэг гаалийн байцаагч нар дотоодод/гадаадад боловсруулах горимын талаар, ялангуяа ямар бичиг баримт бүрдүүлдэг талаар, барааны техникийн тодорхойлолт буюу үйлдвэрлэлийн норматив бодитой эсэх талаар, хяналт тавих арга барилын талаар өндөр мэдлэгтэй байх хэрэгтэй.

## ХАВСРАЛТУУД

**Хавсралт 1.** Дотоодод болон гадаадад боловсруулах горимын талаар ДГБ-аас явуулсан судалгааны хүрээнд гишүүн орнуудын гаалийн байгууллагаас ирүүлсэн хариултын нэгтгэл (2016 оны 12 дугаар сар)

### I. ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ

**1. Танай гаалийн хууль тогтоомжид дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай заалт байдаг уу?**

- |  |
|--|
| <input type="checkbox"/> Тийм <b>77</b>  |
| <input type="checkbox"/> Үгүй <b>1</b> <ul style="list-style-type: none"><li>Хэрэв үгүй бол яагаад гэдгийг тайлбарла: Нэвтрүүлэх шатанд яваа</li></ul> |

**2. Танай гаалийн байгууллагад гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх боломжийг худалдаа эрхлэгч нарт олгосон бөгөөд дээрхийн адил зорилготой өөр горим бий юу? (холбогдох бүх нүдийг чагтлах)**

- |  |
|--|
| <input type="checkbox"/> Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах горим <b>46</b> |
| <input type="checkbox"/> Чөлөөт бүсэд боловсруулах горим <b>54</b>                                   |

**3. Экспортын бараанд агуулагдаж буй, эсхүл түүнийг үйлвэрлэх явцад зарцуулагдсан бараа, материалд төлсөн импортын гаалийн болон бусад татвараа (бүрэн, эсхүл хэсэгчлэн) буцаан авах боломж олгодог татвар буцаан олгох горимын талаар танай хууль тогтоомжид заасан байдаг уу?**

- |  |
|--|
| <input type="checkbox"/> Тийм <b>51</b>                      |
| <input type="checkbox"/> Үгүй <b>24</b>                      |
| <input type="checkbox"/> Бусад (тодорхой бичнэ үү): <b>2</b> |

#### 4. Дотоодод/гадаадад боловсруулах горимын хувьд татварын баталгаа шаарддаг уу?

- Тийм **61**

Хэрэв тийм бол энэ нь санхүүгийн (банкны/даатгалын) баталгаа мөн эсэхийг заана уу: (банкны баталгаа, даатгалын баталгаа, байгууллагын (компанийн) баталгаа, мөнгөн хадгаламж гм.)

- Үгүй **24**

#### 5. Дотоодод/гадаадад боловсруулах горимд бараа байршуулах зөвшөөрлийг ямар байгууллага олгодог вэ?

- Гаалийн байгууллага **68**

- Худалдааны яам **10**

- Сангийн яам **6**

- Бусад (тодорхой бичнэ үү): **9** (Үйлдвэрлэлийн яам, Хөгжлийн зөвлөл, Хөрөнгө оруулалт, хөгжлийн яам, Хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам, Аж үйлдвэр, уул уурхайн яам, Технологийн лаборатори, гм.)

Дотоодод болон гадаадад боловсруулах горимын зөвшөөрөл олгож буй эрх бүхий байгууллага




## 6. Холбогдох байгууллага дотоодод боловсруулах горимын зөвшөөрөл авахад хамаарах техникийн тодорхойлолтыг хэрхэн үнэлж баталгаажуулдаг вэ? (холбогдох бүх нүдийг чагтална уу)

- Төрөл бүрийн бүтээгдэхүүнд зориулж боловсруулсан тусгай шалгур болон техникийн ерөнхий тодорхойлолтыг үндэслэдэг **55**
- Үйлдвэрлэгчээс, эсхүл зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан талаас хүлээн авсан мэдээллийг үндэслэдэг **60**
- Төрийн өөр байгууллагын заавар зөвлөмжийг үндэслэдэг (тодорхой заана уу): **17**

(зарим бараанд хамаарах тусгай зохицуулалт, Хөдөө аж ахуй яам болон Худалдааны яам эдийн засгийн болзол нөхцөлийг харгалzan үзэж зөвшөөрөл олгодог, Эдийн засгийн аль нэг холбооны гишүүн хэд хэдэн улсын хооронд байгуулсан тусгай хэллэлцээр, холбогдох бараа нь хориглосон, хязгаарласан бараа (эмзэг бараа) эсэхээс хамаарах горим журам, г.м.)

- Нийгмийн дунд түгсэн ойлголтод тулгуурладаг **8**
- Бусад (тодорхой заана уу): **6** (эрсдэлийн менежментийг үндэслэдэг, нягтлан шалгах үүднээс, хувийн хэвшилтэй зөвшилцөх замаар, г.м.)

Техникийн тодорхойлолтыг үнэлж баталгаажуулах арга



**7. Танай байгууллагаас дотоодод/гадаадад боловсруулах  
горимын зөвшөөрлийг хялбарчилсан байдлаар олгодог уу?**

- Тийм: **52**
- Хэрэв тийм бол шалгуурыг нь заана уу: (цаасгүй бүрдүүлэлт, тусгай мэдүүлэг шаарддаггүй, цахим баримт бичиг ашиглах, г.м.)
- Үгүй **23**

**8. Дотоодод боловсруулах горимд аудит хийх үүрэг бүхий  
ямар байгууллага байdag вэ?**


- Гаалийн байгууллага **73**
- Бусад (тодорхой заана уу): **7** (Эдийн засаг, сангийн яамны харьяа үндэсний аудитын газар, Promoter de Comercio Exterior, Европын комисс, Гадаад худалдааны аудитын ерөнхий газар, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, Технологийн лаборатори, г.м.)

## II. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЛААС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

### 9. Танай гаалийн байгууллагын МТ-ийн систем нь дотоодод/ гадаадад боловсруулах горимыг дэмжин ажилладаг уу?

- Тийм **63**
- Үгүй **3**
- Зарим талаар (тодорхой заана уу): **12** (Зөвхөн гаалийн бүрдүүлэлтийн хувьд, зөвшөөрөл олгоход, мэдүүлэг гаргаж өгөх, боловсруулахад, мэдээллийн сан хөтлөхөд, зарим оронд дотоодод, эсхүл гадаадад боловсруулах горимын аль алиных нь хувьд мэдээлэл, харилцааны технологи ашигладаг)


Дотоодод/гадаадад боловсруулах горимыг хэрэгжүүлэхэд  
мэдээлэл, харилцааны технологийн систем ашиглагддаг эсэх



**10. Хэрэв тийм бол МТ-ийн систем нь дотоодод/гадаадад боловсруулах горимд байршуулсан импорт/экспортын барааг буцаан гаргах/оруулах явдлыг автоматаар хянадаг уу?**

- Тийм **37**
- Үгүй **23**
- Зарим талаар (заана уу): **10** (зарим тохиолдолд зөвшөөрөлд заасан үнэ, тоо хэмжээг хянадаггүй, заримдаа МХТ нь зөвхөн эцсийн бүтээгдэхүүнийг гаргах явдлыг хянах боломжтой, цөөн тооны гаалийн байгууллагын хувьд МХТ-ийн систем нь дотоодод, эсхүл гадаадад боловсруулах горимын аль алиныг нь хянадаг)


Импорт/экспортын барааг буцаан гаргах/оруулах явдлыг автоматаар хянахад мэдээлэл, холбооны технологийн систем ашиглаж буй байдал



## 11. Эцсийн бүтээгдэхүүнд зориулсан техникийн тодорхойлолтыг МТ-ийн системд оруулдаг уу?

- Тийм **33**
- Үгүй **37**
- Зарим тохиолдолд (тодорхой заана уу): **3** (эцсийн бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтын хувьд зөвшөөрөл авна, г.м.)

Эцсийн бүтээгдэхүүнд зориулсан техникийн тодорхойлолтыг  
Мэдээллийн технологийн системд оруулдаг уу



## 12. Хэрэв тийм бол Мэдээллийн технологийн систем нь холбогдох зөвшөөрөл/техникийн тодорхойлолтыг автоматаар хянадаг уу?

- Тийм **23**
- Үгүй **29**
- Зарим талаар (тодорхой заана уу): **4** (зөвхөн холбогдох барааны тоо хэмжээ, ангиллын хувьд, эцсийн бүтээгдэхүүний техникийн тодорхойлолтыг хоорондоо холбоогүй хоёр өөр системд оруулдаг)


### III. УДИРДЛАГА (Governance)

#### 13. 2015 оны дотоодод/гадаадад боловсруулах горимыг хичнээн аж ахуйн нэгж ашигласан бэ?

Дотоодод боловсруулах горим

- 0-10 **13**
- 10-100 **19**
- 100 ба түүнээс их **43**


Дотоод боловсруулах горимыг 2015 онд ашигласан аж ахуйн нэгжийн тоо



Гадаадад боловсруулах горим

- 0-10 **15**
- 10-100 **19**
- 100 ба түүнээс дээш **35**

Гадаадад боловсруулах горимыг 2015 онд ашигласан аж ахуйн нэгжийн тоо




**14. 2015 онд холбогдох эрх бүхий байгууллагаас дотоодод/  
гадаадад боловсруулах горимын хичнээн зөвшөөрөл олгосон  
вэ?**

Дотоодод боловсруулах горим

- 0-10 **14**
- 10-100 **15**
- 100 ба түүнээс дээш **43**


2015 онд олгосон дотоодод боловсруулах горимын зөвшөөрлийн тоо



Гадаадад боловсруулах горим

- 0-10 **13**
- 10-100 **18**
- 100 ба түүнээс дээш **34**

2015 онд олгосон гадаадад боловсруулах горимын зөвшөөрлийн  
тоо




**15. 2015 онд дотоодод/ гадаадад боловсруулах горимтой холбоотой хэчнээн мэдүүлэг боловсруулсан вэ?**

Дотоодод боловсруулах горим

- 0-100 **8**
- 100-1000 **12**
- 1000-10000 **15**
- 10000 ба түүнээс дээш **37**


2015 онд дотоодод боловсруулах горимд байршуулсан барааны мэдүүлгийн тоо



Гадаадад боловсруулах горим

- 0-100 **11**
- 100-1000 **16**
- 1000-10000 **23**
- 10000 ба түүнээс их **19**


2015 онд гадаадад боловсруулах горимд байршуулсан барааны мэдүүлгийн тоо



**16. Дээрх гурван асуултад та ихэвчлэн доогуур түвшинд хариулсан бол үүний шалтгаан нь юу вэ? (холбогдох бүх нүдийг чагтална уу)**

- Үр ашгийн талаар худалдаа эрхлэгч нар дутуу ойлголтой байдаг **11**
- Энэ төрлийн үйл ажиллагааны талаар зөвлөлдөх явдал дутмаг байсан **5**
- Зөвшөөрөл олгоход тавигдсан шаардлага өндөр, түүнийг олгох явдал удаашралтай **1**
- Горим, журам нь нарийн төвөгтэй **3**
- Бусад (тодорхой заана уу): **16** (тэдгээрийг сонирхсон аж ахуйн нэгж байгаагүй, газарзүйн болон хүн амзүйн шалтгаан, эрэлт хэрэгцээ бага, эдийн засгийн хэмжээ, олон шалтгаан хосолсон, брокеруудын мэдлэг хангалтгүй, дотоодод/гадаадад боловсруулах одоогийн горимыг ашиглах боломжийг худалдаа эрхлэгч нар үл хайхарсан)

**2015 онд дотоодод болон гадаадад боловсруулах горимын ач холбогдлыг үл хайхарсан шалтгаан**




- Худалдаа эрхлэгч нар ойлголт багатай (11)
- Эдгээр үйл ажиллагааны талаар зөвлөлдөх явдал дутмаг (5)
- Зөвшөөрөл олгох шаардлага өндөр, түүнийг олгох явдал удаашралтай (1)
- Горим, журам нь нарийн төвөгтэй (3)
- Бусад (16)

**17. Дотоодод/гадаадад боловсруулах горимын талаарх мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэж байна вэ? (холбогдох бүх нүдийг чагтална уу)**

- Албан ёсны сэтгүүлд нийтлэх замаар **38**
- Гааль, татварын байгууллагын вэбсайтад “хууль тогтоомж, горим журам” гэсэн сэдвийн дор тавих замаар **69**
- Худалдаа эрхлэгч нарт тусгайлсан вэб хуудсаар **17**
- Түгээмэл тавьдаг асуулт, хариулт бэлдэн нийтлэх замаар Бусад хэлбэрээр (тодорхой заана уу): **8**
- Холбогдох мэдээллийг интернет дээр тавьсан линкийг өгнө үү: (Хууль тогтоомж, дүрэм журам, заавар, зөвшөөрөл, өргөдөл, г.м-ийг харж болно)


Мэдээлэл хүргэж буй байдал



**18. Дотоодод/гадаадад боловсруулах горимын талаар  
гаалийн байцаагч наарт зориулсан сургалт явуулдаг уу?  
(холбогдох бүх нүдийг чагтална уу)**

- Анхан шатны мэргэшүүлэх сургалтын үеэр бүх байцаагч наарт **57**
- Зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд шууд оролцдог байцаагч наарт **46**
- Аудит хийх үйл ажиллагаанд шууд оролцдог байцаагч наарт **43**
- Илүү туршлагатай ажилтныг дагалдуулан сургах менторингийн арга ашигладаг **25**
- Бусад (тодорхой заанаа уу): **5** (үйл ажиллагааны зааврыг дотроос болон гаднаас олж авах боломжтой, нэг өдрийн сургалт зохион байгуулдаг, ГМ.

Мэдээлэл хүргэж буй байдал



#### IV. БУСАД

**19. Англи, эсхүл Франц хэл дээр нийтлэх боломжтой бөгөөд тийнхүү нийтэлдэг бол дараах мэдээллийг өгнө үү:**

- Хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтын хуулбар
- Зөвшөөрлийн маягтын хуулбар
- Дотоодод/гадаадад боловсруулах горимын талаар гаалийн байцаагч нарт болон/эсхүл худалдаа эрхлэгч нарт зориулан боловсруулсан зааврын хуулбар

**20. Танай гаалийн байгууллага дээр дурдсан мэдээлэл, баримт бичгийг ДГБ-ын бусад гишүүдтэй хуваалцах гэрээтэй юу?**

- Тийм **56**
- Үгүй **6**
- Зарим тохиолдолд (тодорхой заана уу): **3**

Тайлбар: Энэ асуултад 10 гаалийн байгууллага хариулаагүй.

**Хавсралт 2. Шинэчлэн найруулсан Киотогийн  
конвенцын заалтууд: Тусгай хавсралт F,  
Дотоодод болон гадаадад боловсруулах  
горимын тухай, мөн татвар буцаан олгох  
тухай 1, 2 болон 3 дугаар бүлэг**

### **Тусгай хавсралт F**

#### **1 дүгээр бүлэг**

#### **Дотоодод боловсруулах горим**

#### **Тодорхойлолт**

Энэ бүлгийн зорилгоор:

**“орлох бүтээгдэхүүн”** гэж дотоодод боловсруулах горим ашиглахыг зөвшөөрсөн барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг;

**“адил бараа”** гэж тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд дотоодод боловсруулахаар оруулсан бараатай ижил бөгөөд түүнийг орлох дотоодын буюу импортын барааг;

**“дотоодод боловсруулах”** гэж тодорхой барааг үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварт оруулж, дараа нь экспортлох үндсэн дээр тухайн барааг импортын гаалийн болон бусад татвараас болзолжойгоор чөлөөлөн гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн горимыг тус тус хэлнэ.

#### **Зарчим**

#### **1. Стандарт**

Дотоодод боловсруулах нь энэ бүлгийн заалтаар, мөн холбогдолтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулагдана.

## Үйлчлэх хүрээ

### 2. Стандарт

Дотоодод боловсруулахаар оруулсан барааг импортын гаалийн болон бусад татвараас болзолтойгоор бүрэн чөлөөлнө. Гэвч, дотоодод боловсруулахаар оруулсан барааны үйлдвэрлэл буюу боловсруулалтаас гарсан хаягдал зэрэг аливаа бүтээгдэхүүнийг экспортлоогүй, эсхүл түүнийг арилжааны үнэ цэнэгүй болсонд тооцоогүй бол түүнээс импортын гаалийн болон бусад татварыг хураан авч болно.

### 3. Стандарт

Дотоодод боловсруулахыг зөвхөн гадаадаас шууд оруулсан бараагаар хязгаарлахгүй, бас гаалийн өөр горимд байгаа бараанд зөвшөөрч болно.

### 4. Практик зөвлөмж

Зөвхөн тухайн барааны гарал үүслийн улс, илгээсэн буюу хүлээн авах улсаар ялгаварлан дотоодод боловсруулахыг зөвшөөрөхгүй байж болохгүй.

### 5. Стандарт

Дотоодод боловсруулахаар бараа оруулах эрх нь тухайн импортын барааны эznээр хязгаарлагдахгүй.

### 6. Практик зөвлөмж

Хэрэв гадаадад үүсэн байгуулагдсан аливаа этгээдтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийн явцад ашиглах барааг тухайн этгээд нийлүүлж байгаа бол тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд түүнтэй ижил бараа импортлогч улсын гаалийн нутаг дэвсгэрт бий гэдэг үндэслэлээр дотоодод боловсруулахыг зөвшөөрөхгүй байж болохгүй.

## 7. Практик зөвлөмж

Тухайн импортын бараа холбогдох орлох бүтээгдэхүүнд шингэсэн эсэхийг тодорхойлох явдлыг дараах тохиолдолд дотоодод боловсруулах горимын зайлшгүй нөхцөл шаардлага болгон тавихгүй:

**(а)** тухайн барааг дараах замаар ялган таньж болох:

- орлох бүтээгдэхүүний орц, үйлдвэрлэлийн шат дамжлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах; эсхүл
- үйлдвэрлэлийн явцад гаалийн хяналт тавих; эсхүл

**(б)** тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд дотоодод боловсруулах горимд байршуулсан бараатай ижил бараа ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүнийг экспортолсноор уг горим дуусгавар болсон.

## Барааг дотоодод боловсруулах горимд байршуулах

(а) Дотоодод боловсруулах зөвшөөрөл

### 8. Стандарт

Дотоодод боловсруулахад шаардагдах урьдчилсан зөвшөөрөл олгох тохиолдлууд болон тийм зөвшөөрөл олгох байгууллагыг үндэсний хууль тогтоомжид заасан байна.

### 9. Стандарт

Дотоодод боловсруулах зөвшөөрөлд дотоодод боловсруулахад зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг хэрхэн явуулах хэлбэрийг зааж өгнө.

## 10. Практик зөвлөмж

Хэрэв барааг импортолсны дараа дотоодод боловсруулах

хүсэлт гаргасан бөгөөд тэр нь зөвшөөрөл олгох шаардлагыг хангаж байвал уг зөвшөөрлийг нөхөн олгоно.

## **11. Практик зөвлөмж**

Дотоодод боловсруулах байнгын үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд, түүний хүсэлтийг үндэслэн, тийм үйл ажиллагааг хамарсан ерөнхий зөвшөөрөл олгоно.

## **12. Стандарт**

Хэрэв дотоодод боловсруулах горимд байршуулсан барааг үйлдвэрлэл буюу боловсруулалтад оруулах бол эрх бүхий байгууллага тухайн үйлдвэрлэл явуулах буюу боловсруулалт хийх бодит нөхцөл байдалд тулгуурлан холбогдох үйл ажиллагааны бүтээмжийн хувь хэмжээг тогтоох буюу тохиролцоно. Янз бүрийн төрлийн орлох бүтээгдэхүүний тодорхойлолт, чанар, тоо хэмжээг уг хувь хэмжээг тогтоохдоо, эсхүл тохиролцохдоо зааж өгсөн байна.

## **13. Практик зөвлөмж**

Хэрэв дотоодод боловсруулах үйл ажиллагаа нь дараах нөхцөлийг хангаж байвал эрх бүхий байгууллага тухайн үйл ажиллагаанд хамааралтай стандарт хувь хэмжээ тогтооно:

- шинж байдал нь бараг өөрчлөгдөхгүй бараанд хамааралтай;
- уламжлал ёсоор тодорхой тогтоосон техникийн нөхцөлийн дагуу явагдаж байгаа; мөн
- тогтмол нэг чанарын орлох бүтээгдэхүүн гаргадаг.

b) Ялган таних арга хэмжээ

## **14. Стандарт**

Дотоодод боловсруулах барааг ялган танихтай холбогдсон шаардлагыг гаалийн байгууллага тогтооно. Тийм шаардлага

тавихдаа уг барааны мөн чанар, тухайн үйл ажиллагааны онцлог, мөн холбогдох ашиг сонирхолын ач холбогдлыг зохих ёсоор анхаарна.

## **Бараа гаалийн нутаг дэвсгэрт байх**

### **15. Стандарт**

Гаалийн байгууллага дотоодод боловсруулах хугацааг тохиолдол бүрээр тогтооно.

### **16. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн үндэслэлтэй гэж үзсэн бол анх тогтоосон аливаа хугацаагаа сунгана.

### **17. Практик зөвлөмж**

Тухайн импортын бараа болон холбогдох орлох бүтээгдэхүүнийг өмчлөх эрх гуравдагч этгээдэд шилжих тохиолдолд, зөвшөөрөл авсан этгээдийн хүлээх хариуцлагыг уг этгээдэд ногдуулах нөхцөлөөр дотоодод боловсруулах ажиллагааг үргэлжлүүлэх тухай заалт байвал зохино.

### **18. Практик зөвлөмж**

Эрх бүхий байгууллага дотоодод боловсруулах эрх авсан этгээдээс өөр аль нэг этгээд боловсруулалтын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө. Дотоодод боловсруулах эрх авсан этгээд тухайн үйл ажиллагааны бүхий л хугацааны турш холбогдох зөвшөөрөлд заасан нөхцөлийг ханган биелүүлэх талаар гаалийн байгууллагын өмнө үүрэг хүлээсэн бол дотоодод боловсруулахыг зөвшөөрсөн барааны өмчлөх эрхийг шилжүүлэх шаардлагагүй.

## **19. Стандарт**

Дотоодод боловсруулах горимд байршуулсан барааг оруулснаас өөр гаалийн газраар орлох бүтээгдэхүүн гаргахыг зөвшөөрсөн заалт байвал зохино.

### **Дотоодод боловсруулах ажиллагаа дуусгавар болох**

(а) Экспортлох

## **20. Стандарт**

Орлох бүтээгдэхүүнийг нэг буюу хэд хэдэн удаагийн ачилтаар экспортолсноор дотоодод боловсруулах горимыг дуусгавар болгохыг зөвшөөрсөн заалт байвал зохино.

## **21. Стандарт**

Эрх бүхий байгууллага дотоодод боловсруулах горимыг холбогдох этгээдийн хүсэлтээр дуусгавар болгож, холбогдох барааг импортолсон байдлаар нь буцаан гаргахыг зөвшөөрнө.

(б) Захиран зарцуулах бусад аргууд

## **22. Практик зөвлөмж**

Тухайн импортын бараа болон холбогдох орлох бүтээгдэхүүнийг тухайн тохиолдол бүрд хамаарах нөхцөл шаардлага болон ёс журмын ажиллагааны дагуу гаалийн өөр горимд шилжүүлэх замаар дотоодод боловсруулах горимыг хойшлуулах, эсхүл дуусгавар болгох тухай заалт байвал зохино.

## **23. Практик зөвлөмж**

Орлох бүтээгдэхүүнийг экспортлоогүй тохиолдолд хамаарах импортын гаалийн болон бусад татварын хэмжээ нь дотоодод боловсруулах горимд оруулсан холбогдох импортын бараанд

хамаарах импортын болон бусад татварын хэмжээнээс илүүгүй байна гэдгийг үндэсний хууль тогтоомжид заана.

## **24. Стандарт**

Холбогдох барааны мөн чанарын улмаас ашиглагдаж үгүй болсон барааны хувьд, тийнхүү үгүй болсныг гаалийн байгууллага зохих ёсоор тогтоосон бол орлох бүтээгдэхүүнийг экспортлох бүрд дотоодод боловсруулах горимыг дуусгавар болгох тухай заалт байвал зохино.

## **25. Практик зөвлөмж**

Адил бараа ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүнийг энэ бүлгийн зорилгоор орлох бүтээгдэхүүн гэж үзнэ (адил бараагаар дүйцүүлэх).

## **26. Практик зөвлөмж**

Хэрэв адил бараагаар дүйцүүлэхийг зөвшөөрсөн бол дотоодод боловсруулах горимд байршуулах барааг оруулахаас өмнө орлох бүтээгдэхүүн гаргахыг гаалийн байгууллага зөвшөөрөх ёстой.

X X X

**Тусгай хавсралт F  
2 дугаар бүлэг  
Гадаадад боловсруулах горим**

**Тодорхойлолт**

Энэ бүлгийн зорилгоор:

**“орлох бүтээгдэхүүн”** гэж гадаадад гаргаж авсан бөгөөд гадаадад боловсруулах горим ашиглахыг зөвшөөрсөн барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг;

**“гадаадад боловсруулах”** гэж гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа барааг гадаадад үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварт оруулахаар түр хугацаагаар гаргаж, дараа нь импортын гаалийн болон бусад татвараас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж буцаан оруулах гаалийн горимыг тус тус хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Гадаадад боловсруулах нь энэ бүлгийн заалтаар, мөн холбогдолтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулагдана.

**Үйлчлэх хүрээ**

**2. Практик зөвлөмж**

Гадаадад боловсруулахыг тухайн барааг зөвхөн тухайлсан нэг улсад үйлдвэрлэх, боловсруулах, засварлах ёстой гэдэг үндэслэлээр зөвшөөрөхгүй байж болохгүй.

### **3. Стандарт**

Гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргахыг тухайн барааны эзнээр хязгаарлахгүй.

#### **Барааг гадаадад боловсруулах горимд байршуулах**

(a) Барааг түр хугацаагаар гаргахаас өмнөх ёс журмын ажиллагаа

### **4. Стандарт**

Гадаадад боловсруулахад шаардагдах урьдчилсан зөвшөөрөл олгох тохиолдлууд болон тийм зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагыг үндэсний хууль тогтоомжид заасан байна. Ийм тохиолдол аль болохоор цөөн байвал зохино.

### **5. Практик зөвлөмж**

Гадаадад боловсруулах байнгын үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд, түүний хүсэлтийг үндэслэн, тийм үйл ажиллагааг хамарсан ерөнхий зөвшөөрөл олгоно.

### **6. Практик зөвлөмж**

Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл, эсхүл тухайн үйл ажиллагааг хөнгөвчилнө гэж үзвэл, гадаадад боловсруулах үйл ажиллагааны бүтээмжийн хувь хэмжээг тогтооно. Янз бүрийн төрлийн орлох бүтээгдэхүүний тодорхойлолт, чанар, тоо хэмжээг уг хувь хэмжээг тогтоохдоо зааж өгсөн байна.

(b) Тусгайлан таних арга хэмжээ

### **7. Стандарт**

Гадаадад боловсруулах барааг ялган танихтай холбогдсон шаардлагыг гаалийн байгууллага тогтооно. Тийм шаардлага

тавихдаа уг барааны мөн чанар, тухайн үйл ажиллагааны онцлог, мөн холбогдох ашиг сонирхолын ач холбогдлыг зохих ёсоор анхаарна.

## **Бараа гаалийн нутаг дэвсгэрийн гадна байх**

### **8. Стандарт**

Гаалийн байгууллага гадаадад боловсруулах хугацааг тохиолдол бүрээр тогтооно.

### **9. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн үндэслэлтэй гэж үзсэн бол анх тогтоосон аливаа хугацаагаа сунгана.

## **Орлох бүтээгдэхүүнийг оруулах**

### **10. Стандарт**

Тухайн барааг гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргаснаас өөр гаалийн газраар орлох бүтээгдэхүүн оруулахыг зөвшөөрсөн заалт байвал зохино.

### **11. Стандарт**

Орлох бүтээгдэхүүнийг нэг буюу хэд хэдэн удаагийн ачилтаар оруулахыг зөвшөөрсөн заалт байвал зохино.

### **12. Стандарт**

Холбогдох этгээдийн хүсэлтээр гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргасан бараа хэрэв өөрчлөлт оруулаагүй буцаж ирсэн бол импортын гаалийн болон бусад татвараас

чөлөөлж буцаан оруулахыг эрх бүхий байгууллага зөвшөөрнө. Ийнхүү татвараас чөлөөлөх нь тухайн барааг гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргахтай холбогдуулан буцаан өгсөн, эсхүл хороодуулан тооцсон импортын гаалийн болон бусад татварт хамаarahгүй.

### **13. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргасан барааг буцаан оруулахыг шаардаагүй бол тухайн тохиолдолд хамаарах болзول нөхцөл, ёс журмын ажиллагааг мөрдөж, барааг бүрмөсөн гаргахаар мэдүүлэх замаар гадаадад боловсруулах горимыг дуусгавар болгох тухай заалт байвал зохино.

### **Орлох бүтээгдэхүүнд холбогдох импортын гаалийн болон бусад татвар**

### **14. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид орлох бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахад импортын гаалийн болон бусад татвараас ямар хэмжээнд чөлөөлөх, мөн тухайн чөлөөлөлтийг хэрхэн тооцох аргыг заасан байна.

### **15. Стандарт**

Орлох бүтээгдэхүүнд хамаарах импортын гаалийн болон бусад татварын чөлөөлөлт нь холбогдо барааг гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргахтай холбогдуулан буцаан өгсөн, эсхүл хороодуулан тооцсон гаалийн болон бусад татварт хамаarahгүй.

### **16. Практик зөвлөмж**

Хэрэв гадаадад боловсруулахаар түр хугацаагаар гаргасан бараанд гадаадад үнэ төлбөргүй засвар хийсэн бол үндэсний

хууль тогтоомжид заасан нөхцөлийн дагуу холбогдох барааг импортын гаалийн болон бусад татвараас бүрэн чөлөөлж, буцаан оруулах тухай заалт байвал зохино.

## **17. ПРАКТИК ЗӨВЛӨМЖ**

Хэрэв орлох бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар мэдүүлэхээс өмнө гаалийн өөр горимд байршуулсан байсан бол импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

## **18. ПРАКТИК ЗӨВЛӨМЖ**

Хэрэв орлох бүтээгдэхүүний өмчлөх эрх түүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаас өмнө шилжсэн бол импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

**Тусгай хавсралт F  
З дугаар бүлэг  
Татвар буцаан олгох горим**

**Тодорхойлолт**

Энэ бүлгийн зорилгоор:

**“буцаан олгох татвар”** гэж импортын гаалийн болон бусад татварыг татвар буцаан олгох горимын дагуу буцаан өгсөн мөнгөн дүнг;

**“татвар буцаан олгох горим”** гэж барааг гаргасан тохиолдолд тухайн бараанд, эсхүл түүнийг бүрдүүлж байгаа буюу түүнийг үйлдвэрлэхэд ашиглаж үгүй болсон материалд төлсөн импортын гаалийн болон бусад татварыг (бүхэлд нь, эсхүл түүний хэсгийг) буцаан өгөх гаалийн горимыг;

**“адил бараа”** гэж тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд татвар буцаан олгох горимд байгаа бараатай ижил бөгөөд түүнийг орлох дотоодын, эсхүл импортын барааг тус тус хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Татвар буцаан олгох горим нь энэ бүлгийн заалтаар, мөн холбогдолтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулагдана.

**Үйлчлэх хүрээ**

**2. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид буцаан олгох татвар нэхэмжилж болох тохиолдуудыг заасан байна.

**3. Практик зөвлөмж**

Экспортын бараа үйлдвэрлэхэд импортын гаалийн болон бусад татвар төлсөн барааны оронд адил бараа ашигласан

тохиолдолд татвар буцаан олгох горимыг хэрэглэх тухай заалтыг үндэсний хууль тогтоомжид тусгана.

## **Бүрдүүлэх нөхцөл**

### **4. Стандарт**

Импортлогч барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах үедээ түүнийг гаргах тохиолдолд буцаан олгох татвар нэхэмжлэх зорилготой байснаа мэдэгдээгүй гэдэг ганц үндэслэлээр гаалийн байгууллага буцаан олгох татварыг өгөхөөс татгалзаж болохгүй. Үүний нэгэн адил, тийм мэдэгдлийг бараа оруулах үед хийсэн бол тухайн барааг заавал гаргах албагүй.

### **Бараа гаалийн нутаг дэвсгэрт байх хугацаа**

### **5. Практик зөвлөмж**

Барааг гаргах хугацааг заасан бөгөөд уг хугацаа өнгөрөхөд тухайн бараа татвар буцаан олгох горимд хамрагдахааргүй болох тохиолдолд холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллага үндэслэлтэй гэж үзсэн бол уг хугацааг сунгана.

### **6. Практик зөвлөмж**

Буцаан олгох татвар нэхэмжлэх хугацааг заасан бөгөөд уг хугацаа өнгөрөхөд тийм нэхэмжлэл хүлээн авахааргүй болох тохиолдолд гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн худалдааны буюу бусад шалтгаанаар уг хугацааг сунгах тухай заалт байвал зохино.

## Татварыг буцаан төлөх

### 7. Стандарт

Буцаан олгох татварыг холбогдох нэхэмжлэлийг нягтлан шалгасан даруй өгнө.

### 8. Практик зөвлөмж

Үндэсний хууль тогтоомжид буцаан олгох татварыг цахим гүйвуулга ашиглан шилжүүлэх талаар заасан байна.

### 9. Практик зөвлөмж

Буцаан олгох татварыг бас тухайн барааг дараа нь экспортлох нөхцөлөөр гаалийн аль нэг агуулахад хадгалах, эсхүл түүнийг аль нэг чөлөөт бүсэд оруулсан тохиолдолд өгнө.

### 10. Практик зөвлөмж

Гаалийн байгууллага тодорхой хугацааны турш экспортлох бараанд буцаан олгох татварыг хэрэв тийнхүү хүсэлт тавьсан бол тогтмол хугацаагаар өгнө.

**Хавсралт 3. Барааг дотоодод болон гадаадад  
боловсруулахтай холбогдсон хууль  
тогтоомж, заавар, дүрэм журам,  
өргөдлийн маягт зэргийг агуулсан гишүүн  
орнуудын вэб сайтуудын хаяг**

(2017 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар)

**Австрали**

1901 оны Гаалийн тухай хууль:

<https://www.legislation.gov.au/>

1995 оны Гаалийн тарифын тухай хуулийн Жагсаалт 4:

<http://www.border.gov.au/Busi/cargo-support-trade-and-goods/importing-goods/tariff-classification-of-goods/current-tariff-classification/schedule-4>

Татварын баталгаа:

<http://www.border.gov.au/Busi/cargo-support-trade-and-goods/importing-goods/temporary-importations>

Худалдааг хөнгөвчлөх болон татварын хөнгөлөлтийн схем:

<http://www.border.gov.au/Busi/cargo-support-trade-and-goods/importing-goods/concession-schemes>

Гаалийн татварыг буцаан олгох схем:

<http://www.border.gov.au/Busi/cargo-support-trade-and-goods/exporting-goods/duty-drawback-scheme>

Цагаачлал, хил хамгаалах газар (Ачааны нэгдсэн систем)-тай харилцах:

<http://www.border.gov.au/Busi/cargo-support-trade-and-goods/cargo-support/communication-with-the-department>

Нөөц:

<http://www.border.gov.au/Busi/cargo-support-trade-and-goods/cargo-support/resources>

**Ботсван**

Гаалийн тухай болон гаалийн татварын тухай хууль:

<http://www.burs.org.bw/index.php/customsexcisemain/customs-and-exercise-downloads>

## **Камбож**

Гаалийн баталгаат агуулахтай холбоотой журмууд:  
<http://www.customs.gov.kh/businesstraders-3/customs-bonded-warehouse-2/>

## **Канад**

Гаалийн хууль тогтоомж:  
Гаалийн тариф, ялангуяа хэсэг 89-108

Худалдааг хөхүүлэн дэмжих хөтөлбөрүүд:  
<http://www.cbsa-asfc.gc.ca/trade-commerce/tip-pec-eng.html>

Канадын хилийн албаны санамж:

D7-4-1, Duties Relief Program;

D7-4-2, Duty Drawback Program;

D7-4-3, NAFTA Requirements for the Duty Drawback and the Duties Relief Programs;

D7-4-4, Customs Bonded Warehouses;

D8-2-1, Canadian Goods Abroad Program;

D8-2-6, The Outward Processing Remission Order (Textiles and Apparel) Program;

D8-2-11, Goods Returning to Canada After Being Altered or Worked on Outside Canada;

D8-2-25, Canadian Vessels Repaired or Altered in the United States, Mexico, Chile, Israel or Another CIFTA Beneficiary, Colombia, Costa Rica, Peru, Jordan, Panama, Iceland, Liechtenstein, Switzerland or Norway;

D8-2-26, Goods Returned After Repair or Alteration in the United States, Mexico, Chile, Israel or Another CIFTA Beneficiary, Colombia, Costa Rica, Peru, Jordan or Panama

## **Хятад**

БНХАУ-ын гаалийн тухай хууль:  
<http://english.customs.gov.cn/Statics/644dcaee-ca91-483a-86f4-bdc23695e3c3.html>

## **Фиджи**

1986 оны Гаалийн тухай хууль:  
[http://www.frca.org.fj/wp-content/uploads/2012/10/Customs\\_Act\\_Revised-2nd-March-2016.pdf](http://www.frca.org.fj/wp-content/uploads/2012/10/Customs_Act_Revised-2nd-March-2016.pdf)

## **Финлянд (ЕХ-ны бүх гишүүн оронд хамааралтай)**

Европын Холбооны Гаалийн тухай хууль:

[http://eur-lex.europa.eu/search.html?DTN=0952&DTA=2013&qid=1482928906241&DTS\\_DOM=EU\\_LAW&type=advanced&lang=en&SUBDOM\\_INIT=CONSLEG&DTS\\_SUBDOM=CONSLEG](http://eur-lex.europa.eu/search.html?DTN=0952&DTA=2013&qid=1482928906241&DTS_DOM=EU_LAW&type=advanced&lang=en&SUBDOM_INIT=CONSLEG&DTS_SUBDOM=CONSLEG)

ЕХ-ны дагавар журмууд (DA – Delegated Act (Дагавар хууль)):

[http://eur-lex.europa.eu/search.html?DTN=2446&DTA=2015&qid=148292895384&DTS\\_DOM=EU\\_LAW&type=advanced&lang=en&SUBDOM\\_INIT=LEGISLATION&DTS\\_SUBDOM=LEGISLATION](http://eur-lex.europa.eu/search.html?DTN=2446&DTA=2015&qid=148292895384&DTS_DOM=EU_LAW&type=advanced&lang=en&SUBDOM_INIT=LEGISLATION&DTS_SUBDOM=LEGISLATION)

ЕХ-ны хэрэгжүүлэгч журам (IA - Implementing Act (Хэрэгжүүлэгч хууль)):

[http://eur-lex.europa.eu/search.html?DTN=2447&DTA=2015&qid=1482929028642&DTS\\_DOM=EU\\_LAW&type=advanced&lang=en&SUBDOM\\_INIT=LEGISLATION&DTS\\_SUBDOM=LEGISLATION](http://eur-lex.europa.eu/search.html?DTN=2447&DTA=2015&qid=1482929028642&DTS_DOM=EU_LAW&type=advanced&lang=en&SUBDOM_INIT=LEGISLATION&DTS_SUBDOM=LEGISLATION)

ЕХ-ны шилжилтийн дүрмийн тухай дагавар журам (TDA - Delegated Regulation on Transitional Rules):

[http://eurlex.europa.eu/search.html?DTN=0341&DTA=2016&qid=1482929076832&DTS\\_DOM=EU\\_LAW&type=advanced&lang=en&SUBDOM\\_INIT=LEGISLATION&DTS\\_SUBDOM=LEGISLATION](http://eurlex.europa.eu/search.html?DTN=0341&DTA=2016&qid=1482929076832&DTS_DOM=EU_LAW&type=advanced&lang=en&SUBDOM_INIT=LEGISLATION&DTS_SUBDOM=LEGISLATION)

ЕХ-ны комиссын вэбсайтад тавьсан дамжин өнгөрөхөөс бусад тусгай горимын зааврын хамгийн сүүлийн хувилбар:

[https://ec.europa.eu/taxation\\_customs/business/union-customs-code\\_en](https://ec.europa.eu/taxation_customs/business/union-customs-code_en)

## **Энэтхэг**

1962 оны Гаалийн тухай хууль:

<http://www.cbec.gov.in/htdocs-cbec/customs/cs-acts-botm#>

## **Ирланд**

Дотоодод боловсруулах горимын заавар:

<http://www.revenue.ie/en/customs/businesses/economic/inward-processing.html>

Өргөдлийн маягт, зөвшөөрлийн маягт болон худалдаа эрхлэгч нарт зориулсан хөтөч:

<http://www.revenue.ie/en/customs/businesses/economic/outward-processing.html> <http://www.revenue.ie/en/customs/businesses/economic/inward-processing.html>

Гаалийн ажилтнуудын гарын авлагын холбоос:

<http://www.revenue.ie/en/about/foi/s16/customs/economic-procedures/inward-processing.pdf>; <http://www.revenue.ie/en/about/foi/s16/customs/economic-procedures/outward-processing.pdf>

### **Нигери**

Заавар, журмууд:

[https://www.customs.gov.ng/Guidelines/Destination\\_Inspection/index.php](https://www.customs.gov.ng/Guidelines/Destination_Inspection/index.php)

### **Серби**

Дотоодод боловсруулах горим:

<http://www.carina.rs/en/Zakoni%20engleski/INWARD%20PROCEDURES.pdf>

Дотоодод боловсруулах горимын холбогдолтой нэмэлт мэдээлэл:

<http://www.carina.rs/en/Zakoni%20engleski/ADDITIONAL%20EXPLANATION%20REG ARDING%20THE%20INWARD%20PROCESSING%20PROCEDURE.pdf>

Гаалийн албаны мэдээллийн систем (гаалийн мэдээллийн технологийн систем) дэх эдийн засгийн үр нөлөө бухий гаалийн горимын зөвшөөрөл олгосон бичлэг, гаалийн мэдүүлэг бөглөх загвар:  
<http://www.carina.rs/en/Zakoni%20engleski/SUBJECT%20Records%20ISCS%20%20F OR%20INWORD%20PROCEDURES.pdf>

### **Өмнөд Африк**

Хууль тогтоомжийн холбогдох зүйл заалтуудын хуулбар:

[http://www.itac.org.za/upload/Guidelines%20470%2003%20new%20Feb%202006\(1\).doc](http://www.itac.org.za/upload/Guidelines%20470%2003%20new%20Feb%202006(1).doc) мөн <http://www.itac.org.za/upload/Guidelines%20and%20questionnaire%20for%20rebate%20item%20409%2007%20Outward%20processing.doc>

Дотоодод боловсруулах горим – импортын гаалийн болон бусад татварыг буцаан олгох заалт: 470.02; 470.03; 498.01; 498.02:

<http://www.sars.gov.za/AllDocs/LegalDoclib/SCEA1964/LAPD-LPrim-Tariff-2012-17%20-%20Schedule%20No%204.pdf>

Гадаадад боловсруулах горим – гадаадад боловсруулсан барааг буцаан оруулахад импортын гаалийн болон бусад татварыг хөнгөлөх заалт: 409.07

<http://www.sars.gov.za/AllDocs/LegalDoclib/SCEA1964/LAPD-LPrim-Tariff-2012-17%20-%20Schedule%20No%204.pdf>

Гаалийн ажилтнууд болон/эсчүл худалдаа эрхлэгч нарт зориулсан дотоодод болон гадаадад боловсруулах горимын заавар – Дотоодод боловсруулах горим:

<http://www.sars.gov.za/AllDocs/OpsDocs/Guides/SC-PR-01-02%20-%20Rebate%20Item%20470%2003%20-%20External%20Guide.pdf>

## **Швейцарь**

Дотоодод боловсруулах горим:

<https://www.ezv.admin.ch/ezv/fr/home/infos-pour-entreprises/exonerations--allegements--preferences-tarifaires-et-contributio/importation-en-suisse/trafic-de-perfectionnement-actif.html>

Гадаадад боловсруулах горим:

<https://www.ezv.admin.ch/ezv/fr/home/infos-pour-entreprises/exonerations--allegements--preferences-tarifaires-et-contributio/exportation-de-suisse/trafic-de-perfectionnement-passif.html>

## Хавсралт 4. Зөвшөөрлийн маягтын загварууд

### ТУСГАЙ ГОРИМЫН ӨРГӨДӨЛ

Үнэн зөв бөглөсөн өргөдлийн маягт болон/эсхүл одоо эзэмшиж буй зөвшөөрөлт өөрчлөлт оруулах хүсэлтийг Холбооны Гаалийн хуульд заасан холбогдох дагалдах бичиг баримт/мэдээллийн хамт дараах хаягаар илгээнэ:

**Эдийн засгийн горимын хэсэг**

**Татвар орлогын газар**

**Гаалийн хэлтэс**

**Төрийн байгууллагуудын газар**

**Нина хот, Типперэри гүнгийн харьяат нутаг, Манстер муж, Ирланд  
Улс**

Утас: **(067) 63237/63204/63176** Хотын дугаар: **1890 66 63 33**

Факс: **(067) 32373**

Имэйл: **revcep@revenue.ie**

Татвар орлогын газрын вэбсайт: **www.revenue.ie**

Тайлбар: Хэрэв өргөдлийг имэйлээр илгээсэн бол гарын үсэг зурсан өргөдлийг бас хургуулэх ёстай.

Хэрэв шаардлагатай мэдээлэл/бичиг баримт дутуу бол Татвар орлогын газар нь дутуу мэдээллийг гүцээн авах зорилгоор өргөдөл гаргагч холбогдох этгээтдэй холбогдоно. Гэвч шаардлагатай мэдээллийг ийнхүү холбогдоноос хойш гуч хоногийн дотор хүлээн аваагүй бол тухайн өргөдөл/хүсэлтийг хангахаас татгалзаж, өргөдөл гаргагч руу буцаан хургуулнэ. Энэ тохиолдолд бүх мэдээлэл/бичиг баримт бэлэн болмогц өргөдлийг шинээр гаргаж илгээнэ. Тийм өргөдлийн хүчин төгөлдөр болох хугацаа нь шаардлагтай бүх мэдээлэл/бичиг баримт агуулсан, бүрэн бөглөсөн шинэ өргөдлийг хүлээн авсан өдөр байна.

**Та энэхүү өргөдлийг бөглөхдөө уг өргөдлийн маягтын ард байгаа тайлбар бичгийг сайтар уншиж танилцана уу.**



## 1. Өргөдөл гаргагч

Нэр, эсхүл аж ахуйн нэгж/байгууллагын нэр, хаяг:

---

---

---

---

---

---

---

---

НӨАТ-ын дугаар: \_\_\_\_\_ Европын холбооны (ААН-ийн) бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_

Худалдаа эрхлэгчийн татварын дансны дугаар (TAN): \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Холбоо барих этгээдийн имэйл хаяг: \_\_\_\_\_

**Төлөөлөгч:** (Хэрэв та төлөөлөгчөөрөө дамжуулан харьцах бол дараах хэсгийг бөглөнө үү).

Нэр \_\_\_\_\_

Утасны дугаар \_\_\_\_\_

Имэйл хаяг \_\_\_\_\_

## 2. Гаалийн горим

(Аль нэгийг нь чагтална уу)

Дотоодод боловсруулах горим

- Гадаадад боловсруулах горим
- Дотоодын хэрэглээнд оруулахаар боловсруулах горим
- Агуулахад боловсруулах горим

### 3. Өргөдлийн төрөл

(Доорх жагсаалтаас тохигоуулж оруулж)

1. Анхны өргөдөл
2. Одоо эзэмшиж байгаа зөвшөөрөлд өөрчлөлт оруулах/  
түүнийг шинэчлэх \_\_\_\_\_ (Холбогдох  
зөвшөөрлийн дугаарыг бичнэ үү)
3. Нэгээс дээш тооны гишүүн оронд хамаарах  
зөвшөөрлийн өргөдөл.
4. Дараагийн зөвшөөрөл авах өргөдөл (Дотоодод  
боловсруулах гарим)

### 4. Нэмэлт (үргэлжлэл) маягтууд

5. Данс/бүртгэлийн байршил, төрөл \_\_\_\_\_

-----  
-----

### 6. Зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаа

Эхлэх:	Дуусах:
--------	---------

### 7. Тухайн гаалийн горимд байршуулах бараа

(Хавсралт 1-ийг бөглөнө үү)

TARIC (тарифын ангиллын)-ийн код	Тодорхойлолт (бичиглэл)	Тоо хэмжээ	Үнэ

## 8. Боловсруулсан бүтээгдэхүүн

(Хавсралт 2-ыг бөглөнө үү)

Нэгдсэн жагсаалт (Combined Nomenclature)-ын код	Тодорхойлолт (бичиглэл)	Бүтээмжийн хувь хэмжээ

## 9. Төлөвлөсөн үйл ажиллагааны дэлгэрэнгүй

(Боловсруулалт хийх газар болон боловсруулалтын төрлийн дэлгэрэнгүй мэдээлэл)

---

---

---

---

Аж ахуйн нэгжийн мэдээлэл:

Нэр, хаяг: _____	Нэр, хаяг: _____
НӨАТ-ын дугаар: _____	НӨАТ-ын дугаар: _____
Татварын дансны дугаар: _____	Татварын дансны дугаар: _____

## 10. Эдийн засгийн болзол нөхцөл

(Зүүлт I-ийг үз)

## 11. Гаалийн газар

(а) Тухайн горимын барааг (хилээр) оруулах гаалийн газар: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

(б) Холбогдох барааг буцаан гаргах/оруулах гаалийн газар: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

(с) Хяналт тавих гаалийн газар: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 12. Барааг ялган таних арга

(Дараах жагсаалтаас тохирох кодыг оруулж)

(ТАЙЛБАР: Үүнтэй адилтгах өөр зүйл бөглөсөн бол энэ нүдийг бөглөх шаардлагагүй)

1. Серийн дугаар/Үйлдвэрлэгчийн дугаар
2. Тугалга, ломбо, хавчаар, эсхүл ялгарч харагдах өөр бусад тэмдэг тавих
3. Тэмдэглэлийн (мэдээллийн) хуудас болох маягт INF бөглөх
4. Дээж (сорьц, загвар), дүрс зураг, эсхүл техникийн тодорхойлолт авах
5. Шинжилгээ хийх
6. Хавсралт 104-т заасан мэдээллийн багц бичиг баримт бөглөх (зөвхөн гадаадад боловсруулах горимын хувьд)
7. Ялган таних өөр бусад арга (16-р нүдэнд тайлбарлах)

## 13. Холбогдох барааг буцаан гаргах/оруулах хугацаа (сараар)

## 14. Хялбарчилсан бүрдүүлэлт

a)

b)

(Дараах жагсаалтаас тохирох кодыг оруул)

1. Импортын бүрэн бус мэдүүлэг бөглөх
2. Экспортын бүрэн бус мэдүүлэг бөглөх
3. Импортын хялбарчилсан мэдүүлэг бөглөх
4. Экспортын хялбарчилсан мэдүүлэг бөглөх
5. Импортын бүрдүүлэлтийн орон нутгийн журам мөрдөх
6. Экспортын бүрдүүлэлтийн орон нутгийн журам мөрдөх
7. Хялбарчилсан бүрдүүлэлт хийдэггүй

## 15. Шилжүүлэх

(Дараах жагсаалтаас тохирох кодыг оруул)

1. Зөвшөөрөлд заасан газруудын хооронд гаалийн ёс журмын ажиллагаа шаардахгүйгээр шилжүүлэх.
2. Барааг (хилээр) оруулах гаалийн газраас өргөдөл гаргаг этгээдийн, эсхүл аж ахуйн нэгжийн байр агуулах руу, эсхүл гаалийн тухайн горимд байршуулахаар оруулах мэдүүлэгт заасны дагуу ашиглах газар нь хүртэл шилжүүлэх.
3. Гаалийн тухайн горимын дагуу буцаан гаргахаар (хилээр) гаргах гаалийн газар хүртэл шилжүүлэх.
4. Нэг эзэмшигчээс нөгөө эзэмшигчид шилжүүлэх.
5. Аливаа эрх, үүргээ гуравдагч талд шилжүүлэх.

**16. Нэмэлт мэдээлэл**

**17. Гарын үсэг..... Огноо .....**  
**Нэр .....**

(БҮХ ҮСГИЙГ ТОМООР БИЧИХ)

**Нэмэлт (үргэлжлэл) маягт - Дотоодод  
боловсруулах горим**

(Адил барааны талаар IV хавсралтыг үз)

18. Адил бараа:

(Хэрэв олон код бичихээр бол хавсралт З-ыг ашиглаж болно)

Нэгдсэн жагсаалтын код

Тодорхойлолт (бичиглэл)

19. Эцсийн бүтээгдэхүүнийг урьдчилж гаргах уу (Prior exportation)?

(Хэрэв тийм бол гадаадын/импортын (Европын холбооны бус) барааг уг зорилгоор мэдүүлэхээр төлөвлөсөн хугацааг бичих)

20. Гаалийн мэдүүлэг бичиж чөлөөт эргэлтэд оруулах уу?

21. Нэмэлт мэдээлэл

22. Гарын үсэг..... Огноо

Нэр.....

**Нэмэлт (үргэлжлэл) маягт – Гадаадад  
боловсруулах горим**

18. Систем	
19. Сольж тавих бараа	
Нэгдсэн жагсаалтын код	Тодорхойлолт (бичиглэл)
20. [Хамааралгүй]	
21. [Хамааралгүй]	
22. Гарын үсэг.....	Огноо
Нэр.....	

## Нэмэлт (үргэлжлэл) маягт – Гаалийн агуулах

(Барааг арчлан хамгаалах ердийн үйл ажиллагааны  
талаар Зүүлт III-ыг үз)

18. Агуулахын төрөл	
19. Агуулах буюу хадгалах байгууламж	
20. Барааны жагсаалт гаргаж өгөх эцсийн хугцаа	
21. Алдагдлын хувь хэмжээ	
22. Гаалийн агуулахын горимд байршуулаагүй бараа хадгалж буй байдал	
Нэгдсэн жагсаалтын код Категори/Гаалийн горим	Тодорхойлолт (бичиглэл)
23. Барааг арчлан хамгаалах ердийн үйл ажиллагаа	
24. Барааг агуулахаас түр гаргах. Зорилго	
25. Нэмэлт мэдээлэл	
26. Гарын үсэг..... Огноо	
Нэр.....	

## ТАЙЛБАР БИЧИГ

### БҮЛЭГ I

#### Өргөдлийн маягт бөглөх заавар

##### 1. Өргөдөл гаргагч

Өргөдөл гаргагч этгээдийн бүтэн нэр, хаягийг оруулна. Өргөдөл гаргагч этгээд гэдэг нь холбогдох зөвшөөрөлд дурдагдах этгээд байна. Энэхүү өргөдлийг хариуцсан этгээдийн имэйл хаягийг оруулна.

Өргөдөл гаргагч этгээд нь Худалдаа эрхлэгчийн татварын дансны дугаар (TAN)-тай байх ёстой бөгөөд түүнийг дараах хаягаар авах боломжтой: the A.E.P. Accounts Section, Government Offices, Nenagh, Co. Tipperary, Ireland

Хэрэв өргөдөл гаргагч этгээд нь энэхүү зөвшөөрөлтэй холбогдсон гаалийн асуудлаар төлөөлөгчөөрөө дамжуулан харьцахыг хүсч байгаа бол түүний нэр болон холбоо барих мэдээллийг өгсөн байна.

##### 2. Гаалийн горим

Өргөдөл гаргаж буй холбогдох горимыг чагтална.

##### 3. Өргөдлийн төрөл

Өргөдлийн төрлийг энэ нүдэнд оруулахдаа дараах кодуудаас дор хаяж нэгийг нь ашиглана:

1. = анхны өргөдөл
2. = зөвшөөрөлд өөрчлөлт оруулах, эсхүл түүнийг шинэчлэх өргөдөл (мөн холбогдох зөвшөөрлийн дугаарыг бичнэ)
3. = нэгээс дээш тооны гишүүн оронд хамаарах зөвшөөрлийн өргөдөл.
4. = дараагийн зөвшөөрөл авах өргөдөл

#### **4. Нэмэлт (үргэлжлэл) маягтууд**

Ямар нэмэлт (үргэлжлэл) маягт ашигласныг заана. Тайлбар: нэмэлт маягтууд (үргэлжлэл хуудсууд) нь дотоодод боловсруулах горим, гадаадад боловсруулах горим болон гаалийн агуулахын горимд зориулагдсан байгаа.

#### **5. Данс/бүртгэлийн байршил, төрөл**

Данс бүртгэл хаана явагдаж байгааг бичнэ. Энэ нь өргөдөл гаргагч этгээдийн арилжааны, татварын, эсхүл өөр бусад бүртгэлийн материал, эсхүл түүний нэрийн өмнөөс эзэмшиж буй тийм мэдээлэл байгаа газар юм. Мөн ашиглаж буй системийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх замаар данс бүртгэлийн төрлийг заана.

Мөн тухайн гаалийн горимд ашиглах бүртгэл тооцооны төрлийг заана. Бүртгэл тооцоо гэдэг нь: тухайн гаалийн горимыг гаалийн байгууллагаас хянах боломж олгож буй, шаардлагатай бүх мэдээлэл, техникийн үзүүлэлтийг агуулсан баримт мэдээ юм.

**Тайлбар:** Нэгээс дээш тооны гишүүн оронд хамааралтай өргөдөл гаргах тохиолдолд данс бүртгэл явагддаг үндсэн газар, данс бүртгэлийн үндсэн төрлийг заана.

#### **6. Зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаа**

**Эхлэх**

**Дуусах:**

Зөвшөөрөл хүчин төгөлдөр болохыг хүсч байгаа (зөвшөөрөл нь зарчмын хувьд хамгийн эртдээ гэхэд түүнийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болдог), мөн түүнийг дуусгавар болгохыг хүсч байгаа өдрийг заана.

7. Тухайн гаалийн горимд байршуулах бараа			
TARIC (тарифын ангиллын)-ийн код	Тодорхойлолт (бичиглэл)	Тоо хэмжээ	Үнэ

### **TARIC-ийн код**

TARIC (10 оронтой)-ийн дагуу бөглөнө.

Тайлбар: Эцсийн зориулалт:

(1) Хэрэв өргөдөл нь дараах 2 дахь хэсэгт дурдсанаас өөр бараанд хамааралтай бол TARIC-ийн 10 оронтой кодыг оруулна.

(2) Хэрэв өргөдөл нь Нэгдсэн жагсаалт (Combined Nomenclature)-ын урьдатгал заалтын тусгай заалт (А болон В хэсэг)-д хамаарах бараа (зарим төрлийн усан онгоц, завь болон өөр бусад усан онгоцны зориулалттай бараа, мөн өрөмдлөгийн буюу үйлдвэрлэлийн платформ/иргэний нисэх онгоцны зориулалттай бараа, бас иргэний нисэх онгоцон дотор ашиглах бараа)-нд хамааралтай бол Нэгдсэн жагсаалтын код шаардахгүй. Өргөдөл гарагч нь тухайлбал “Тодорхойлолт (бичиглэл)” гэсэн нүдэнд “нисэх онгоц болон түүний эд анги/Нэгдсэн жагсаалтын тусгай заалтын В хэсэг” гэж бичих ёстой.

Тайлбар: Гаалийн агуулах:

Хэрэв өргөдөлд өөр өөр төрлийн олон бараа дурдсан бол та “Нэгдсэн жагсаалтын код” гэсэн нүдэнд “төрөл бүрийн” гэж бичиж болно. Энэ тохиолдолд “Тодорхойлолт (бичиглэл)” гэсэн нүдэнд агуулахад хадгалах барааны шинж байдлыг

тодорхойлж бичнэ. Нэгдсэн жагсаалтын код, тоо хэмжээ, үнийн талаар нарийвчлан бичих шаардлагагүй.

### **Тодорхойлолт (бичиглэл)**

Тухайн барааны тодорхойлолт (бичиглэл) гэдэг нь арилжааны болон/эсхүл техникийн тодорхойлолт болно.

**Тайлбар:** Арилжааны болон/эсхүл техникийн тодорхойлолт нь холбогдох өргөдлийн талаар шийдвэр гаргах боломжтой хэмжээнд ойлгомжтой, дэлгэрэнгүй байх ёстой. Хэрэв адил бараа ашиглахаар төлөвлөсөн бол тэр барааны арилжааны чанар болон техникийн үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

### **Тоо хэмжээ**

Тухайн гаалийн горимд байршуулах төлөвлөсөн барааны тоо хэмжээг бичнэ.

### **Үнэ**

Тухайн гаалийн горимд байршуулахаар төлөвлөсөн барааны үнийг еврогоор бичнэ.

## **8. Боловсруулсан бүтээгдэхүүн**

Нэгдсэн жагсаалт (Combined Nomenclature)- ын код	Тодорхойлолт (бичиглэл)	Бүтээмжийн хувь хэмжээ

Холбогдох үйл ажиллагааны үр дүнд бий болох боловсруулсан бүх бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. Үүнд боловсруулсан үндсэн бүтээгдэхүүн, эсхүл боловсруулсан хоёрдогч бүтээгдэхүүн хамаарна.

### **Нэгдсэн жагсаалтын код**

Нэгдсэн жагсаалтын дагуу бөглөнө.

### **Тодорхойлолт (бичиглэл)**

Тухайн барааны тодорхойлолт (бичиглэл) гэдэг нь

арилжааны болон/эсхүл техникийн тодорхойлолт болно.

**Тайлбар:** Арилжааны болон/эсхүл техникийн тодорхойлолт нь холбогдох өргөдлийн талаар шийдвэр гаргах боломжтой хэмжээнд ойлгомжтой, дэлгэрэнгүй байх ёстай.

### **Бүтээмжийн хувь хэмжээ**

Орлох бүтээгдэхүүн бүрийн хувьд төлөвлөсөн бүтээмжийн хувь хэмжээг, эсхүл уг хувь хэмжээг тодорхойлох аргыг бичнэ.

### **9. Төлөвлөсөн үйл ажиллагааны дэлгэрэнгүй**

Тухайн гаалийн горимд байршуулах бараатай холбогдуулан төлөвлөсөн үйл ажиллагааны шинж төрхийг тодорхойлно. Мөн тухайн үйл ажиллагаа явагдах газар (газрууд)-ыг заана.

Хэрэв нэгээс илүү гаалийн байгууллагаа оролцох бол гишүүн орнуудын нэрс болон холбогдох үйл ажиллагаа явагдах газруудыг заана.

Шаардлагатай бол тухайн үйл ажиллагаанд оролцох бусад аж ахуйн нэгжийн нэр, хаяг, гүйцэтгэх үүргийг бичнэ.

Хэрэв эрх, үүргээ шилжүүлэх (Хуллийн 218-р зүйл) бол 9-р нүдэнд хүлээн авах этгээдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулна.

Эцсийн зориулалтаар нь хэрэглэх бол холбогдох барааны эцсийн зориулалт, хаана хэрэглэх талаар бичнэ.

### **10. Эдийн засгийн болзол нөхцөл**

Өргөдөл гарагч нь 7-р нүдэнд заасан TARIC-ын код тус бүрээр Зүүлт I-д байгаа хоёр оронтой кодноос дор хаяж нэгийг нь ашиглаж, эдийн засгийн болзол нөхцөлийг хангаж буй үндэслэлээ бичих ёстай. Эдгээр кодыг хавсралт 1-д зааж болно. (Мөн хориглосон, хязгаарласан бараа (эмзэг бараа)-ны хувьд Зүүлт II-ыг үз)

## **11. Гаалийн газар (газрууд)**

- a| оруулах газар**
- b| буцаан гаргах газар**
- c| хяналт тавих газар**

Ямар гаалийн газар болохыг заана.

## **12. Барааг ялган таних арга**

Дараах кодын дор хаяж нэгийг нь ашиглаж, барааг ялган таних аргыг 12-р нүдэнд бичнэ:

1. = Серийн, эсхүл үйлдвэрлэгчийн дугаар
2. = тугалга, ломбо, хавчаар, эсхүл ялгарч харагдах өөр бусад тэмдэг тавих
3. = тэмдэглэлийн (мэдээллийн) хуудас болох маягт INF бөглөх
4. = дээж (сорьц, загвар), дүрс зураг, эсхүл техникийн тодорхойлолт авах
5. = шинжилгээ хийх
6. = хавсралт 104-т заасан мэдээллийн багц бичиг баримт бөглөх (зөвхөн гадаадад боловсруулах горимын хувьд)
7. = ялган таних өөр бусад арга ("нэмэлт мэдээлэл" гэсэн 16-р нүдэнд тайлбарлах)
8. = ялган таних арга хэмжээ авахгүй (зөвхөн түр хугацаагаар оруулах горимын хувьд)

## **13. Холбогдох барааг буцаан гаргах/ оруулах хугацаа (сараар)**

Холбогдох үйл ажиллагаа явуулахад шаардагдах хугацааг бичнэ. Энэ хугацаа нь холбогдох баоаагтухайн гаалийн горимд

байршуулсан өдрөөс эхэлнэ. Энэ хугацаа нь бараа буюу бүтээгдэхүүнийг дараагийн аль нэг горимд байршуулснаар, буцаан гаргаснаар, эсхүл гадаадад боловсруулсан барааг чөлөөтэй өргөлтэд оруулж, импортын гаалийн татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлүүлэх тохиолдолд дуусгавар болно.

### Тайлбар:

Дотоодод боловсруулах горимын хувьд: тухайн горимд тодорхой нэг хугацаанд байршуулсан бүх барааны хувьд тэдгээрийг буцаан гаргах хугацаа дуусгавар болж байгаа бол тэр өдөр уг горимд байгаа бүх барааны хувьд буцаан гаргах хугацаа автоматаар сунгагдахаар холбогдох зөвшөөрөлд зааж өгсөн байж болно. Хэрэв ийнхүү хялбаршуулан зохицуулах шаардлагатай бол "174(2)-р зүйл" гэж оруулаад 16-р нүдэнд нарийвчилсан тайлбар өгнө.

Эцсийн зориулалтыг нь чухалчилсан горимын хувьд тухайн барааг эцсийн зориулалтаар нь ашиглах хугацааг заана, эсхүл уг барааг зөвшөөрөл эзэмшигч өөр этгээдэд шилжүүлэх хугацааг заана.

Гаалийн агуулахын горимын хувьд хугацаа хязгааргүй учир хоосон орхино.

### 14. Хялбарчилсан бүрдүүлэлт

a|

b|

### 14a нүд:

Дараах кодуудаас дор хаяж нэгийг нь ашиглаж, барааг холбогдох горимд байршуулах зорилгоор ашиглах мэдүүлгийн төрлийг заана:

- 1 = Стандарт мэдүүлэг (EX-ны Гаалийн хуулийн 162-р зүйлийн дагуу)
- 2 = Хялбарчилсан мэдүүлэг (EX-ны Гаалийн хуулийн 166-р зүйлийн дагуу)
- 3 = Мэдүүлэгчийн бүртгэлд тусгах (EX-ны Гаалийн хуулийн 182-р зүйлийн дагуу)

#### **14b нүд:**

Дээрх 14a-д заасан кодуудаас дор хаяж нэгийг нь ашиглаж, холбогдох горимыг дуусгавар болгох зорилгоор ашиглах мэдүүлгийн төрлийг заана.

Тайлбар: Эцсийн зориулалтыг нь чухалчилсан горимын хувьд 14-р нүдийг бөглөхгүй

#### **15. Шилжүүлэх**

Барааг шилжүүлэх аргыг заана. Эрх, үүрэг шилжүүлэх бол 9-нүдэнд дэлгэрэнгүй заана.

#### **16. Нэмэлт мэдээлэл**

Хэрэгтэй гэж үзсэн бүх нэмэлт мэдээллийг оруулах бөгөөд хэрэв шаардлагатай бол дараах нэмэлт мэдээллийг оруулна:  
Баталгааны төрөл

Баталгаа байгаа эсэх (тийм/үгүй)

Баталгаа байгаа гаалийн газар

Баталгааны дүн.

Тооцоолон бодох арга:

Дотоодод боловсруулах горимын хувьд хэрэв гаалийн байгууллага дээр өр төлбөр үүсэх бол импортын гаалийн татварыг EX-ны Гаалийн хуулийн 86(3)-р зүйлийн дагуу тооцоолон бодох уу? (тийм/үгүй)

**17. Гарын үсэг .....**

**Огноо .....**

**Нэр .....**

Хэрэв нэмэлт (ургэлжлэл) маягт бөглөсөн бол 17-р нүдийг бөглөх шаардлагагүй. Оронд нь 22, эсхүл 25-р нүдийг бөглөнө.

## БҮЛЭГ II

### Нэмэлт (үргэлжлэл) маягтын тайлбар Дотоодод боловсруулах горим

#### 18. Адил бараа

TARIC (Тарифын ангилал)-ын код	Тодорхойлолт (бичиглэл)

Адил бараа ашиглахаар төлөвлөсөн бол “ТИЙМ” гэж бичээд, гаалийн байгууллагууд импортын бараа болон адил барааг харьцуулж харах боломжтой байх үүднээс хавсралт З-т адил барааны TARIC (Тарифын ангилал)-ын арван оронтой код, арилжааны чанар болон техникийн үзүүлэлтийг заана. Ийнхүү харьцуулалт хийхэд 12-р нүдэнд заасан кодыг хэрэг болгон ашиглаж болно. Хэрэв адил бараа нь импортын барааг бодвол үйлдвэрлэлийн арай илүү шат дамжлагаар орсон бол 21-р нүдэнд холбогдох мэдээллийг оруулна.

#### 19. Эцсийн бүтээгдэхүүнийг урьдчилж гаргах (Prior exportation)

Эцсийн бүтээгдэхүүнийг импортын бараа орж ирэхээс өмнө урьдчилж гаргах систем ашиглахаар төлөвлөсөн бол “ТИЙМ” гэж бичээд, гадаадын/импортын (Европын холбооны бус) барааг уг зорилгоор мэдүүлэхээр төлөвлөсөн хугацааг заана. Ингэхдээ уг импортын барааг худалдан авах болон Европын холбоо руу тээвэрлэхэд зарцуулах хугацааг бодолцоно.

**20. Гаалийн мэдүүлэг бичилгүйгээр чөлөөт эргэлтэд оруулах уу?**

Орлох бүтээгдэхүүнийг, эсхүл өөрчлөлт оруулаагүй барааг ёс журмын ажиллагаа хийлгэлгүйгээр чөлөөт эргэлтэд оруулах хүсэлт гаргасан бол “ТИЙМ” гэж заана.

**21 Нэмэлт мэдээлэл**

18-20 дугаар нүдэнд бичигдсэн зүйлийн хувьд хэрэгтэй гэж үзсэн бүх нэмэлт мэдээллийг тусгана.

## **Нэмэлт (үргэлжлэл) маягтын тайлбар Гадаадад боловсруулах горим**

### **18. Систем**

Хэрэв аль нэг систем ашиглахаар төлөвлөсөн бол зохих кодыг (кодуудыг) оруулна:

1 = (экспортын барааг гаргахаас өмнө) барааг урьдчилан оруулалгүйгээр сольж тавих стандарт систем

2= (экспортын барааг гаргахаас өмнө) барааг урьдчилан оруулж сольж тавих стандарт систем

3= EX-ны Гаалийн хуулийн 223(2)(d)-р зүйлийн дагуух гадаад боловсруулалт IM/EX

### **19. Сольж тавих бараа**

Барааг сольж тавих стандарт систем (үүнийг зөвхөн засвар үйлчилгээ хийхэд ашиглах боломжтой) ашиглахаар төлөвлөсөн бол гаалийн байгууллагууд түр хугацаагаар гаргах бараа болон сольж тавих барааг харьцуулж харах боломжтой байх үүднээс сольж тавих барааны Нэгдсэн жагсаалтын 8 оронтой код, арилжааны чанар болон техникийн үзүүлэлтийг заана..

### **20. EX-ны Гаалийн хуулийн дагуу хамааралгүй**

### **21. EX-ны Гаалийн хуулийн дагуу хамааралгүй**

### **22. Нэмэлт мэдээлэл**

18-20 дугаар нүдэнд бичигдсэн зүйлийн хувьд хэрэгтэй гэж үзсэн бүх нэмэлт мэдээллийг тусгана.

## Нэмэлт (үргэлжлэл) маягтын тайлбар Гаалийн агуулах

### 18. Агуулах

Дараах төрлүүдээс нэгийг нь заана:

Нээлттэй агуулах - I төрөл

Нээлттэй агуулах - II төрөл

Хаалттай агуулах

### 19. Агуулах буюу хадгалах байгууламж

Гаалийн агуулахын буюу өөр хадгалах байгууламжийн журмаар ашиглах газрыг тодорхой зааж өгнө.

### 20. Барааны жагсаалт гаргаж өгөх эцсийн хугцаа

Барааны жагсаалт гаргаж өгөх багцаат хугцааг заана.

### 21. Алдагдлын хувь хэмжээ

Зүйтэй гэж үзвэл алдагдлын хувь хэмжээний талаар дэлгэрэнгүй бичнэ.

### 22. Гаалийн агуулахын горимд байршуулаагүй бараа хадгалж буй байдал

Нэгдсэн жагсаалтын код болон тодорхойлолт (бичиглэл)

Ердийн бараа, эсхүл адил барааг хадгалахаар төлөвлөж байгаа бол тэдгээр барааны Нэгдсэн жагсаалтын 8 оронтой код, арилжааны чанар болон техникийн үзүүлэлтийг заана. Зүйтэй гэж үзвэл тэдгээр барааг байршуулсан гаалийн горимыг заана.

**23. Барааг арчлан хамгаалах ердийн үйл ажиллагаа**

Барааг арчлан хамгаалах ердийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа бол үүнийг бөглөнө.

**24. Барааг агуулахаас түр гаргах**

Зорилго: Хэрэв барааг агуулахаас түр гаргахаар төлөвлөж байгаа бол үүнийг бөглөнө.

**25. Нэмэлт мэдээлэл**

18-20 дугаар нүдэнд бичигдсэн зүйлийн хувьд хэрэгтэй гэж үзсэн бүх нэмэлт мэдээллийг тусгана.

## ЗҮҮЛТ 1

### ДОТООДОД БОЛОВСРУУЛАХ ГОРИМЫН АЖИЛЛАГААНД ХАМААРАХ ЭДИЙН ЗАСГИЙН КОДУУД

#### Кодууд.

**01:** Хавсралт 71-02-т заагаагүй барааг боловсруулах

Хавсралт 71-02-т заасан барааг боловсруулах. Болзол нөхцөлүүд:

**10 (i)** боловсруулах зорилгоор импортлох барааны адил Нэгдсэн жагсаалтын 8 оронтой код, мөн түүний адил арилжааны чанар болон техникийн үзүүлэлт бүхий Европын холбоонд үйлдвэрлэсэн бараа байхгүй байх.

**11 (ii)** ижил төстэй бараа ашиглах гэхээр түүний үнэ нь төлөвлөж буй арилжааны үйл ажиллагааг эдийн засгийн хувьд ашиггүй болгох учир тийм бараа ашиглах боломжгүй тохиолдолд Европын холбоонд үйлдвэрлэсэн бараа болон импортлох гэж байгаа барааны хооронд үнийн зөрүү байх.

**12 (iii)** ижил төстэй бараа нь боловсруулсан бүтээгдэхүүнийг худалдан авагч гуравдагч орны этгээдтэй байгуулсан гэрээний шаардлагад нийцэхгүй байх тохиолдолд, эсхүл боловсруулсан бүтээгдэхүүнийг аж үйлдвэрийн буюу арилжааны өмчийн эрхийг хамгаалах тухай заалтуудыг дагаж мөрдөх зорилгоор дотоодод боловсруулах горимд байршуулах бараагаар боловсруулсан байх ёстой гэж гэрээнд заасан байх тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүрэг байх.

**30.7 (iv)** Нэгдсэн жагсаалтын 8 оронтой код бүрийн хувьд нэг өргөдөл гаргагч этгээдийн нэр дээр, мөн хуанлийн нэг жилийн хугацаанд дотоодод боловсруулах горимд байршуулах барааны үнийн дүн нийтдээ 150,000 еврогоос хэтрэхгүй байх.

**30.1** арилжааны бус бараа боловсруулах.

**30.2** зөвшөөрөлээмшигчийн шууд, эсхүл шууд бусээмшилд байгаа барааг Европын холбооны нутаг дэвсгэрийн гадна байгуулагдсан этгээдийн нэрийн өмнөөс гаргасан техникийн тодорхойлолтын дагуу, ерөнхийдөө зөвхөн боловсруулалтын зардлыг төлсөн тохиолдолд боловсруулах.

**30.3** барааг арчлан хамгаалахтай холбогдуулан EX-ны Гаалийн хуулийн 220-р зүйлд заасан ердийн үйл ажиллагаа.

**30.4** Засвар үйлчилгээ

**30.5** эдийн засгийн болзол нөхцөлийг хангасан гэж үзсэний үндсэн дээр өмнө нь олгосон зөвшөөрлийн дагуу олж авсан барааг боловсруулах.

**30.6** хатуу улаанбуудай (durum wheat)-г боловсруулж гоймон үйлдвэрлэх.

**31** барааг (EX-ны) Зөвлөлийн 510/2014 тоот журмын 18-р зүйлийн дагуу тодорхойлсон үлдэгдэл тоо хэмжээний хүрээнд дотоодод боловсруулах горимд байршуулах.

**40** барааг чөлөөт эргэлтэд оруулах техникийн шаардлагыг хангах зорилгоор боловсруулах.

**41** дал модны тосны цул болон шингэн хэсэг, наргил модны самрын тос, наргил модны самрын тосны шингэн хэсэг, дал модны үрийн тос, дал модны үрийн тосны шингэн хэсэг, бабассу модны самрын тос, эсхүл тосон туулга (castor oil) боловсруулж, хүнсний салбарт гаргаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

**42** нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ бүхий нисэх онгоц үйлдвэрлэхэд зарцуулах буюу ашиглах бүтээгдэхүүн боловсруулах.

**43** (EX-ны) Зөвлөлийн 150/2003 тоот журмын дагуу зарим буу зэвсэг, байлдааны (цэргийн) тоног төхөөрөмжийн импортын гаалийн татварыг шууд хойшлуулах боломжтой болох бүтээгдэхүүн боловсруулах.

**44** барааг боловсруулж, загварын бараа үйлдвэрлэх.

**45** цахим бүрдэл хэсэг, эд анги, иж бүрдэл, эсхүл өөр бусад материал боловсруулж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

**46** Нэгдсэн жагсаалтын 2707, эсхүл 2710 кодод хамаарах барааг боловсруулж, Нэгдсэн жагсаалтын 2707, 2710, эсхүл 2902 кодод хамаарах бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

**47** хаягдал болон өөдөс болгох, устгах, эд анги буюу бүрдэл хэсгийг нөхөн сэргээх.

**48** динатурат болгох (хүнсний бүтээгдэхүүнийг шууд хэрэглэж болохгүйгээр өөрчлөн ямар нэг зүйлийг холих).

**49** Нэгдсэн жагсаалтын 8 оронтой код бүрийн хувьд нэг өргөдөл гаргагч этгээдийн нэр дээр, мөн хуанлийн нэг жилийн хугацаанд дотоодод боловсруулах горимд байршуулах барааны үнийн дүн нийтдээ хавсралт 71-02-т хамаарах барааны хувьд 150,000 еврогоос хэтрэхгүй, бусад барааны хувьд 300,000 еврогоос хэтрэхгүй байх. Гэхдээ дотоодод боловсруулах горимд байршуулах бараанд демпингийн эсрэг татвар, нөхөн төлөөсийн (саармагжуулах) татвар түр, эсхүл бүр ногдуулах, эсхүл хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эсхүл чөлөөт эргэлтэд оруулахаар мэдүүлсэн бол татварын хөнгөлөлтийг зогсоосноос үүдэлтэй аливаа нэг нэмэлт татвар ногдуулах бол энд хамаarahгүй.

## ЗҮҮЛТ 2

(Хавсралт 71-02 (Дагавар хууль))

### ЭМЗЭГ БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮН

Энэхүү хавсралтад дараах бараа хамаарна:

- (1) Нийтийн зах зээлийн байгууллагын дараах салбарын нэгэнд хамаарах хөдөө аж ахуйн дараах бүтээгдэхүүн:

Үхэр, тугалын махны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын 1(2)(o) дугаар зүйлд заасан бөгөөд хавсралт I-ийн XV хэсгийн жагсаалтад орсон бүтээгдэхүүн;

Бодон гахайн махны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын 1(2)(q) дугаар зүйлд заасан бөгөөд хавсралт I-ийн XVII хэсгийн жагсаалтад орсон бүтээгдэхүүн;

Хонь, ямааны махны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын 1(2)(r) дугаар зүйлд заасан бөгөөд хавсралт I-ийн XVIII хэсгийн жагсаалтад орсон бүтээгдэхүүн;

Өндөгийн салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын 1(2)(s) дугаар зүйлд заасан бөгөөд хавсралт I-ийн XIX хэсгийн жагсаалтад орсон бүтээгдэхүүн;

Шувууны махны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын 1(2)(t) дугаар зүйлд заасан бөгөөд хавсралт I-ийн XX хэсгийн жагсаалтад орсон бүтээгдэхүүн;

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн: Европын холбооны 1308/2013 тоот журмын 1(2)(v) дугаар зүйлд заасан бөгөөд хавсралт I-ийн хэсгийн жагсаалтад орсон бүтээгдэхүүн;

Үр тарианы салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын хавсралт I-ийн I хэсгийн 1(2)(a) зүйлд заасан бүтээгдэхүүн;

Будааны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын хавсралт I-ийн II хэсгийн 1(2)(b) зүйлд заасан бүтээгдэхүүн;

Саахарын салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын хавсралт I-ийн III хэсгийн 1(2)(c) зүйлд заасан

бүтээгдэхүүн;

Оливын тосны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын хавсралт I-ийн VII хэсгийн 1(2)(g) зүйлд заасан бүтээгдэхүүн;

Сүү, сүүн бүтээгдэхүүний салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын хавсралт I-ийн XVI хэсгийн 1(2)(p) зүйлд заасан бүтээгдэхүүн;

Дарсны салбар: Европын холбооны 1308/2013 тоот журмын хавсралт I-ийн XII хэсгийн 1(2)(l) зүйлд заасан бөгөөд Нэгдсэн жагсаалтын дараах кодод хамаарах бүтээгдэхүүн:

0806 10 90

2009 61

2009 69

2204 21 (PDO ба PGI чанарын дарснаас бусад)

2204 29 (PDO ба PGI чанарын дарснаас бусад) 2204 30

Нэгдсэн жагсаалтын дараах кодод хамаарах этилийн спирт болон спиртний төрлийн бүтээгдэхүүн:

2207 10

2207 20

2208 40 39 – 2208 40 99

2208 90 91 – 2208 90 99

хуучин 2401 - болосвруулаагүй тамхи

1 ба 2 дахь хэсэгт зааснаас бусад, хөдөө аж ахуйн экспортын буцаан олголтод хамрагдах бүтээгдэхүүн.

Загас агнуурын аж ахуйн болон далайн амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн (fishery and aquaculture products)-ий нийтийн зах зээлийн байгууллагын тухай Европын зөвлөлийн 1379/2013 тоот журмын хавсралт I-д заасан загас агнуурын аж ахуйн бүтээгдэхүүн, мөн энэ журмын хавсралт V-д заасан, татварыг нь автоматаар (шууд) хэсэгчлэн хойшлуулах схемд хамрагдсан бүтээгдэхүүн.

Автомат квотад хамаарах загасны агнуурын аж ахуйн бүх бүтээгдэхүүн.

## ЗҮҮЛТ 3

(Хавсралт 71-03 (Дагавар хууль))

### БАРААГ АРЧЛАН ХАМГААЛАХ ЕРДИЙН ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮЙЛ АЖИЛАГААНЫ ЖАГСААЛТ

EX-ны Гаалийн хуулийн хэрэгжүүлэх заалт	EX-ны Гаалийн хуулийн эрх олгосон заалт	Дотоодод боловсруулах горимын одоогийн заалт	Хавсралт	Үндэслэл
Зүйл 220	Зүйл 221(b)	Зүйл 531, 809	Хуучин хавсралт 72	Дагавар хууль

Өөрөөр заагаагүй бол дараах хэлбэрүүдийн аль нь ч Нэгдсэн жагсаалтын 8 оронтой шинэ код үүсгэхгүй.

- (2) агаар, салхи оруулах, тоос шороог цэвэрлэх, зайлуулах, ердийн цэвэрлэгээ хийх, баглаа боодлыг засах, тээвэрлэлт, эсхүл хадгалалтын явцад учирсан гэмтлийг засах энгийн үйл ажиллагаа явуулах, тээвэрлэлтийн зориулалтаар хамгаалалтын бүтээлгээр хучих, бүтээлгийг авах;
- (3) барааг тээвэрлэлтийн дараа сэргээн босгох;
- (4) тоолох, дээж авах, ялгаж ангилах, шигшэх, гар аргаар шүүх, барааг пүүлэх (жигнэх);
- (5) гэмтсэн, эсхүл бохирдсон бүрдэл хэсгүүдийг ялгаж хаях;
- (6) хоргуйжүүлэх, ариутгах, гэрэлтүүлэг тавих, эсхүл ялзарч муудахаас сэргийлсэн бодис нэмэх замаар хадгалж хамгаалах;
- (7) нян бактерийг цэвэрлэх (мэрэгч хорхой, хортон шавьжийг устгах);
- (8) зэврэхээс хамгаалах;
- (9) дараах төрлийн боловсруулах үйл ажиллагаа явуулах:

- цаашнь боловсруулах үйлажиллагаа явуулалгүйгээр, эсхүл нэрэх ажиллагаа явуулалгүйгээр дулаан (температур)-ыг ердийн байдлаар өсгөх, эсхүл дулаан (температур)-ыг ердийн байдлаар бууруулах; ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно;
- (10) электростатик боловсруулалт хийх, үрчийж хумирсан сёмол, нэхмэл, сүлжмэл эдлэлийг тэнийлгэх (үрчгэр, нугалааг арилгах), индуудэх;
- (11) дараах төрлийн боловсруулах үйл ажиллагаа явуулах:
- жимсийг үндэс, навч, цэцэгнээс нь салгаж цэвэрлэх, ясыг нь авах, хатаасан жимс, ногоог зүсэх, хэсэгчлэн хуваах, жимсийг услах, эсхүл жимсийг хатаах, ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно;
- (12) арьс, ширний давсыг цэвэрлэх, арьс ширийг угааж цэвэрлэх, идээлэх;
- (13) харьцангуй хязгаарлагдмал байдлаар, эсхүл техникийн стандартад нийцүүлэх зорилгоор, гэхдээ тухайн барааны шинж байдлыг өөрчлөлгүйгээр, эсхүл анхны үзүүлэлтийг нь сайжруулалгүйгээр бараанд нэмэлт, өөрчлөлт оруулах, туслах чанарын бүрдэл хэсгийг солих, ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно;
- (14) цааш нь боловсруулах үйл ажиллагаа явуулалгүйгээр, эсхүл нэрэх ажиллагаа явуулалгүйгээр шингэннийг шингэрүүлэх (сулруулах), эсхүл өтгөрүүлэх (баяжуулах), ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно;
- (15) ижил төрлийн боловч чанарын ялгаатай барааг тогтонги чанартай болгох, эсхүл харилцагчийн хүссэн чанарт хүргэх зорилгоор тухайн барааны шинж байдлыг өөрчлөлгүйгээр хооронд нь хольж нийлүүлэх;
- (16) биодизель агуулаагүй хий, түлшийг тогтонги

чанартай болгох, эсхүл харилцагчийн хүссэн чанарт хүргэх зорилгоор тухайн барааны шинж байдлыг өөрчлөлгүйгээр Нэгдсэн жагсаалтын 27-р бүлэгт ангилагдах биодизель агуулсан хий, түлштэй холих, ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно;

- (17) хий, эсхүл түлшнийг биодизельтэй холих, ингэснээр уг хольц дахь биодизелийн хэмжээ нь 0,5 хувиас бага байх, мөн биодизелийг хий, эсхүл түлштэй холих, ингэснээр уг хольц дахь хий, эсхүл түлшний хэмжээ нь 0,5 хувиас бага байх;
- (18) зөвхөн энгийн үйл ажиллагаа хийгдэх тохиолдолд барааг хувааж жижиглэх, эсхүл хэмжээг нь багасгах;
- (19) баглаж боох, баглаа боодлыг задлах, баглаа боодлыг солих, өөр саванд юулэх, өөр саванд хийх, ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно, тэмдэглэгээ, лац ломбо, шошго, үнийн шошго, эсхүл ялган таних өөр бусад тэмдэглэгээ тавих, авах, өөрчлөх;
- (20) зөвхөн энгийн үйл ажиллагаа хийгдэх тохиолдолд машин, аппарат, автотээврийн хэрэгслийг ялангуяа техникийн стандартад нийцэж байгаа эсэхийг нь шалгах зорилгоор турших, тохируулга хийх, тааруулах, ажиллуулах.
- (21) хоолойн холболтуудыг тодорхой зах зээлд зориулж бэлтгэхийн тулд тохируулж янзлах;
- (22) динатурат болгох (хүнсний бүтээгдэхүүнийг шууд хэрэглэж болохгүйгээр өөрчлөн ямар нэг зүйлийг холих), ингэснээр Нэгдсэн жагсаалтын код 8 орны түвшинд өөрчлөгдж болно;
- (23) импортын барааны гадна байдал, эсхүл борлогдох чанарыг сайжруулах, эсхүл түүнийг түгээх, дахин борлуулахад бэлтгэх зорилгоор дээр дурдсанаас өөр арчлан хамгаалах ердийн үйл ажиллагаа явуулах, гэхдээ тухайн барааны шинж байдлыг өөрчлөхгүй, эсхүл анхны үзүүлэлтийг нь сайжруулахгүй байх.

## ЗҮҮЛТ 4

(Хавсралт 71-04 (Дагавар хууль))

### АДИЛ БАРААНЫ ТУХАЙ ТУСГАЙ ЗААЛТУУД

#### I. Гаалийн агуулах, дотоодод болон гадаадад боловсруулах горим

Энгийн аргаар үйлдвэрлэсэн бараа болон органик бараа бүтээгдэхүүн

Органик бараа бүтээгдэхүүнийг энгийн аргаар үйлдвэрлэсэн бараагаар солих, мөн энгийн аргаар үйлдвэрлэсэн барааг органик бараа бүтээгдэхүүнээр солихыг зөвшөөрөхгүй.

#### II. Дотоодод боловсруулах горим

##### **(24) Будаа**

Нэгдсэн жагсаалтын 1006 кодтой будааг хэрэв тэр нь Нэгдсэн жагсаалтын 8 оронтой нэг ижил кодод хамаарахгүй бол адил бараа гэж үзэхгүй. Гэхдээ 6,0 мм-ээс хэтрэхгүй урттай, урт/өргөний харьцаа нь 3-тай тэнцүү, эсхүл түүнээс их байх будаа, мөн 5,2 мм-тэй тэнцүү, эсхүл түүнээс бага урттай, урт/өргөний харьцаа нь 2-той тэнцүү, эсхүл түүнээс их будааны хувьд адил бараа мөн эсэхийг зөвхөн урт/өргөний харьцааг тодорхойлох замаар тогтооно. Будаа (ширхэг будаа, үр)-г хэмжихдээ будааны нийтийн зах зээлийн байгууллагын тухай EX-ны 3072/95 тоот журмын хавсралт A(2)(d)-г баримтална.

##### **(25) Улаанбуудай**

Зөвхөн гуравдагч улсад хурааж, чөлөөт эргэлтэд оруулсан улаанбуудай болон Нэгдсэн жагсаалтын 8 оронтой нэг ижил кодод хамаарах бөгөөд арилжааны чанар болон техникийн үзүүлэлт нь ижил Европын холбооны бус улаанбуудайг хооронд нь адил бараа болгон ашиглаж болно.

Гэхдээ:

улаанбуудайн хувьд адил бараа ашиглахыг хориглосон хоригийг Комиссоос гишүүн орнуудтай харьцаж, түүнийг нь Хорооноос нягтлан шалгасны дараа өөрчилж болно,

Европын холбооны хатуу улаанбуудай (durum wheat) болон туравдагч улсын гарал үүсэлтэй хатуу улаанбуудайг хэрэв Нэгдсэн жагсаалтын 1902 11 00 болон 1902 19 кодод хамаарах гоймон үйлдвэрлэх зориулалттай бол адил бараа болгон ашиглахыг зөвшөөрнө.

## **(26) Саахар**

Европын холбооны бус түүхий нишингийн саахар (Нэгдсэн жагсаалтын 1701 13 90 болон/эсхүл 1701 14 90 кодтой) болон чихрийн манжин (Нэгдсэн жагсаалтын 1212 91 80 кодтой)-г хэрэв Нэгдсэн жагсаалтын 1701 99 10 кодтой боловсруулсан бүтээгдэхүүн (цагаан саахар) гарган авах нөхцөлөөр хооронд нь адил бараа болгон ашиглахыг зөвшөөрнө.

Европын холбооны 1308/2013 тоот журмын III хавсралтын В хэсгийн III-т тодорхойлсон стандарт чанар бүхий түүхий нишингийн саахарын адил тоо хэмжээг тооцоходоо цагаан саахарын too хэмжээг 1.0869565 коэффициентээр үржүүлнэ.

Стандарт бус чанартай түүхий нишингийн саахарын адил тоо хэмжээг тооцоходоо цагаан саахарын too хэмжээг 100 гэсэн тоог түүхий нишингийн саахарын гарцад хуваан гаргаж авсан коэффициентээр үржүүлнэ. Түүхий нишингийн саахарын гарцыг Европын холбооны 1308/2013 тоот журмын III хавсралтын В хэсгийн III-т тодорхойлсны дагуу тооцно.

## **(27) Амьд мал, амьтад ба мах**

Амьд мал, амьтад, эсхүл махыг дотоодод боловсруулах горимын хувьд адил бараа болгон ашиглахгүй.

Махны хувьд адил бараа ашиглахыг хориглосон хоригийг Комиссоос гишүүн орнуудтай харьцаж, түүнийг нь гишүүн орнуудын гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн

байгууллага нягтлан шалгасны дараа, хэрэв өргөдөл гаргагч нь тийнхүү адилтган авч үзэх явдал эдийн засгийн хувьд шаардлагатай гэдгийг нотлох чадвартай байх, мөн гаалийн байгууллагууд уг үйл ажиллагааг хянах журмын төслийг боловсруулж хүргүүлсэн бол өөрчилж болно.

### **(28) Эрдэнэшиш**

Европын холбооны болон Европын холбооны бус эрдэнэшишийг зөвхөн дараах тохиолдолд, мөн дараах болзол нөхцөлтэйгөөр адил бараа болгон ашиглах боломжтой:

Малын тэжээл үйлдвэрлэхэд ашигладаг эрдэнэшишийн хувьд яг Европын холбооны бус эрдэнэшишийг боловсруулан малын тэжээл үйлдвэрлэж байгаа гэдгийг хянах гаалийн хяналтын систем тогтоосон тохиолдолд адил бараа ашиглаж болно.

Цардуул болон цардуулан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг эрдэнэшишийн хувьд зөвхөн өөр хоорондоо адил бараа болж чадах, амилопектинээр баялаг эрдэнэшиш (лав адил эрдэнэшиш (*wax-like maize*), эсхүл “лав хэлбэрийн” эрдэнэшиш (*‘waxy’ maize*))-ээс бусад бүх төрлийн эрдэнэшишийг адил бараа болгон ашиглах боломжтой.

Хоол хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг эрдэнэшишийн хувьд зөвхөн хоорондоо адил бараа болж чадах төрөл бүрийн эрдэнэшиш (“Duro” төрлийн “Plata” эрдэнэшиш, “Flint” эрдэнэшиш)-ээс бусад бүх төрлийн эрдэнэшишийг адил бараа болгон ашиглах боломжтой.

### **(29) Оливын тос**

А. Адил барааг зөвхөн дараах тохиолдолд, мөн дараах болзол нөхцөлтэйгөөр ашиглах боломжтой:

Оливын цэвэр тос (virgin olive oil)

Европын холбооны 1308/2013 тоот журмын VII хавсралтын VIII хэсгийн 1(а)-д заасан тодорхойлолтод

нийцсэн, Нэгдсэн жагсаалтын 1509 10 90 кодод хамаарах Европын холбооны оливын маш цэвэр тос (extra virgin olive oil) болон Нэгдсэн жагсаалтын мөн адил кодод хамаарах Европын холбооны бус оливын маш цэвэр тосны хооронд, гэхдээ тухайн боловсруулалтын үйл ажиллагааны үр дүнд Нэгдсэн жагсаалтын нэг ижил кодод хамаарах, дээрх 1(a)-д заасан шаардлагыг хангасан оливын маш цэвэр тос үйлдвэрлэх тохиолдолд; Европын холбооны 1308/2013 тоот журмын VII хавсралтын VIII хэсгийн 1(b)-д заасан тодорхойлолтод нийцсэн, Нэгдсэн жагсаалтын 1509 10 90 кодод хамаарах Европын холбооны оливын цэвэр тос болон Нэгдсэн жагсаалтын мөн адил кодод хамаарах Европын холбооны бус оливын цэвэр тосны хооронд, гэхдээ тухайн боловсруулалтын үйл ажиллагааны үр дүнд Нэгдсэн жагсаалтын нэг ижил кодод хамаарах, дээрх 1(b)-д заасан шаардлагыг хангасан оливын цэвэр тос үйлдвэрлэх тохиолдолд;

Европын холбооны 1308/2013 тоот журмын VII хавсралтын VIII хэсгийн 1(c)-д заасан тодорхойлолтод нийцсэн, Нэгдсэн жагсаалтын 1509 10 10 кодод хамаарах Европын холбооны лампантे оливын цэвэр тос (lampante virgin olive oil, чанар муутай оливын тос) болон Нэгдсэн жагсаалтын мөн адил кодод хамаарах Европын холбооны бус лампанте оливын цэвэр тосны хооронд, гэхдээ дараах бүтээгдэхүүнийг боловсруулах тохиолдолд:

- дээр дурдсан VII хавсралтын VIII хэсгийн 2-т заасан тодорхойлолтод нийцсэн, Нэгдсэн жагсаалтын 1509 90 00 кодод хамаарах оливын цэвэршүүлсэн тос (refined olive oil), эсхүл
- дээр дурдсан VII хавсралтын VIII хэсгийн 3-т тодорхойлолтод нийцсэн, Нэгдсэн жагсаалтын 1509 90 00 кодод хамаарах, гэхдээ Нэгдсэн жагсаалтын 1509 10 90 кодод хамаарах Европын холбооны оливын цэвэр тостой холин гаргаж авах оливын тос.

Оливын зөөлөн хэсгийн тос (olive-pomace oil, оливын зөөлөн хэсгээс эхний удаагийн шахалтаар гаргаж авсан тос) Европын холбооны 1234/2007 тоот журмын VII хавсралтын VIII хэсгийн 4-т заасан тодорхойлолтод нийцсэн, Нэгдсэн жагсаалтын 1510 00 10 код хамаарах Европын холбооны оливын зөөлөн хэсгийн цэвэршүүлээгүй тос болон Нэгдсэн жагсаалтын мөн адил кодод хамаарах Европын холбооны бус оливын зөөлөн хэсгийн цэвэршүүлээгүй тосны хооронд, гэхдээ оливын зөөлөн хэсгийн тосыг боловсруулж гарган авсан, Нэгдсэн жагсаалтын 1510 00 90 кодод хамаарах, дээр дурдсан VII хавсралтын VIII хэсгийн 6-д заасан тодорхойлолтод нийцсэн бүтээгдэхүүнийг Нэгдсэн жагсаалтын 1509 10 90 кодод хамаарах Европын холбооны оливын цэвэр тостой холих замаар гаргаж авсан байх тохиолдолд.

**B.** A.1(c)-ийн 2 дахь догол мөр болон A.2-т заасан холимог тосыг түүнтэй ижил байдлаар ашигладаг Европын холбооны бус оливын цэвэр тостой зөвхөн экспортын холимог тосны нийт тоо хэмжээнд эзлэх Европын холбооны бус оливын цэвэр тосны хувь хэмжээг тодорхойлох боломжтой байдлаар горимын хяналтыг зохион байгуулсан байх тохиолдолд холихыг зөвшөөрнө.

**C.** Боловсруулсан бүтээгдэхүүний шууд савлагаа нь 220 литр, эсхүл түүнээс бага байх ёстой. Энэ зарчмаас ухарч, тохиролцсон савлагаа нь хамгийн ихдээ 20 тонн байх тохиолдолд гаалийн байгууллагууд тухайн экспортын бүтээгдэхүүний тоо, чанарыг системтэй хянадаг байх нөхцөлтэйгөөр өмнөх заалтуудад дурдсан тосыг экспортлохыг зөвшөөрч болно.

**D.** Адил бараа мөн эсэхийг холимог тос хийх зорилгоор ашиглаж буй тосны тоо хэмжээг хянах зорилго бүхий худалдааны (арилжааны) бүртгэл мэдээ ашиглах замаар, түүнчлэн, холбогдох барааны чанарыг баталгаажуулах зорилгоор, Европын холбооны бус тосыг холбогдох горимд байршуулах үед авсан дээжийн техникийн үзүүлэлтийг

холимог тос үйлдвэрлэхэд ашигласан бөгөөд боловсруулсан бүтээгдэхүүнийг бодитоор гаргах үед, гарах цэг дээр авсан дээжийн техникийн үзүүлэлтийн дагуу тухайн боловсруулсан бүтээгдэхүүнийг боловсруулах үед авсан Европын холбооны тосны дээжийн техникийн үзүүлэлттэй харьцуулах замаар, шалгана. Дээжийг олон улсын стандарт EN ISO 5555 (дээж авах) болон EN ISO 661 (дээжийг лабораториуд руу илгээх, дээжийг шинжилгээнд бэлдэх)-ийн дагуу авна. Шинжилгээг Европын эдийн засгийн комиссын 2568/91 тоот журмын I хавсралтад заасан үзүүлэлттэй харьцуулан хийнэ<sup>4</sup>.

Сүү, сүүн бүтээгдэхүүн

Адил бараа ашиглахыг дараах тохиолдолд зөвшөөрнө:

Тухайн импортын барааны хуурай, тослогтой болон уурагтай бүрдэл хэсэг (milk dry matter, milk fat matter and milk protein) бурийн жин нь адил барааны эдгээр бүрдэл хэсэг тус бурийн жингээс хэтрэхгүй байна.

Гэвч дотоодод боловсруулах горимд байршуулах барааны эдийн засгийн үнэ цэнэ нь дээр дурдсан бүрдэл хэсгүүдийн зөвхөн нэг, эсхүл хоёроор нь тодорхойлогдох бол тухайн нэг буюу хоёр бүрдэл хэсгийг үндэслэн жинг тодорхойлж болно. Зөвшөөрөлд нарийвчилсан мэдээлэл, тухайлбал, энэхүү нийт жинг хэзээ тодорхойлохыг заасан тодорхой хугацаа тусгагдсан байна. Энэ хугацаа нь 4 сараас хэтрэхгүй.

Дотоодод боловсруулах горимд байршуулах барааны болон адил барааны холбогдох бүрдэл хэсгийн (хэсгүүдийн) жинг гаалийн мэдүүлэг болон маягт INF-д зааж өгсөн байна. Ингэснээр гаалийн байгууллагууд эдгээр бүрдэл хэсгийг үндэслэн адил бараанд хяналт тавих боломжтой болно.

### **III. Гадаадад боловсруулах горим**

Хавсралт 71-02-т заасан барааны оронд адил бараа ашиглахыг зөвшөөрөхгүй.

---

4 Европын хамтын нийгэмлэгийн албан ёсны сэтгүл, L 248, 5.9.1991, хуудас 1.

**ХАВСРАЛТ 1**  
**ГААЛИЙН ХОЛБОГОДХ ГОРИМД БАЙРШУУЛАХ БАРАА**

TARIC (Тарифын ангилал)- ын код	Тодорхойлэлт (Бичиглэл)	Тоо хэмжээ 3 жилийн тутамд (Хэрэв эзлэх код ашиглал бол тоо хэмжээг хувийн нэг жилийр зөвнэ)	Үнэ 3 жил тутам ЕВРО (Хэрэв 30(7) гээн код ашиглал бол үнийг ашиллах бол үнийг хувийн нэг жилийр зөвнэ)	Эдийн засгийн Код

**ХАВСРАЛТ 2**  
**ОРЛОХ, ЭСХҮЛ БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН**

Нэгдсэн жагсаалтын код	Тодорхойлолт (Бичиглэл)	Бүтээмжийн хувь

**ХАВСРАЛТ З**  
**АДИЛ БАРАА**

TARIC (Тарифын ангилал)-ын код	Тодорхойлолт (Бичиглэл)



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

**Сангийн яам**  
**Холбооны гаалийн газар**  
**Гаалийн ерөнхий газар**

Дотоодод боловсруулах горимын зөвшөөрөл		Шийдвэр	
<b>1. Зөвшөөрөл эзэмшигч</b>	<b>Зөвшөөрлийн №</b>		
	<b>Зөвшөөрөл олгосон байгууллага</b> Гаалийн ерөнхий газар Эдийн засгийн арга хэмжээний секц (хэлтэс) Monbijoustrasse 40 3003 Берн		
Файлын дугаар Хүсэлт гаргасан этгээд	Файлын дугаар Файл боловсруулсан этгээд Утас Факс		
<b>2. Гаалийн горим</b>	Боловсруулалт Бодит/Гэрээнд заасан	Татвар буцаалт/ Татвар хойшлуулалт	Тухайн бараа/ адил бараа ашигласан байдал
<b>3. Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа</b>			
Импорт саатсан	Гаргах (экспортлох) өдөр Холбогдох барааг оруулснаас хойш	Буцаан тоолох цаг хугацаа 60 хоног	
<b>4. Тухайн гаалийн горимд байршуулж болзошгүй бараа</b>			
Барааны тодорхойлолт	Тарифын ангиллын код	Тоо хэмжээ	
<b>5. Боловсруулалтын хэлбэр</b>			
<b>6. Барааны гарал үүслийн улс (4-т заасан бараа бүрээр)</b>			
<b>7. Орлох барааг хүлээн авах улс</b>			
<b>8. Бараа оруулах үед төлсөн НӨАТ</b>			
<b>9. Хяналт тавих газар</b>			
<b>10. Ашигласан бараа</b> Тухайн бараа / Адил бараа			

**11. Импортын, эсхүл экспортын гаалийн мэдүүлэг**

Импортын болон экспортын гаалийн мэдүүлгийг мэдээллийн хуудас "In-Service Development / Taxation Under the Suspension System or in the Reimbursement Process"-нд заасан маягт (маягт 47.81)-ын дагуу үйлдсэн байна.

**12. Бусад төлбөр**

**13. Гарал үүслийн тухай заалтууд (Татвар буцаан олгох)**

Экспортлох үед, зөвхөн холбогдох хэлэлцээрт заасан гарал үүслийн анхны нөхцөлүүд хангагдсан тохиолдолд хөнгөлөлттэй гарал үүслээ нотлон харуулахыг зөвшөөрнө. Татвар буцаан олгох (татвар хорогдуулан тооцох, мөн гаалийн татвараас чөлөөлөх)-ийг хориглосон хэлэлцээрүүдийн хувьд, ялангуяа боловсруулах горим ашиглан хийгдэх энэхүү худалдаа (нэмүү өртөн шингээн энэхүү худалдаа)-ны нэг хэсэг болгон гадаадад гаргах бүтээгдэхүүн уг хэлэлцээрт заасан, мөн холбогдох зөвшөөрлийн дагуу оруулсан (эсхүл магадгүй эквивалент дээр сууриссан тэзвэрлэлтийн дагуу солилцсон) гуравдагч талын материал агуулж байгаа тохиолдолд анхны нөхцөлүүд хангагдаагүй гэж үзнэ.

**14. Бараа оруулах, гаргахад тавигдах өөр бусад шаардлагууд хангагдсан байх ёстай.**

**15. Гаалийн газруудад зориулсан заавар**

**16. Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга зам**

Энэхүү зөвшөөрлийн Захиргааны журмын тухай Холбооны хууль (PA; RS 172.021)-ийн дагуу гаргасан шийдвэр гэж үзнэ; Энэ шийдвэрийг Холбооны захиргааны хэргийн шүүх (Шуудангийн хайрцаг, 3000 Берн 14)-д 30 хоногийн дотор давж заалдаж болно. Захиргааны журмын тухай Холбооны хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, давж заалдах өргөдөл дүгнэлт, шалтгаан, нотлох баримт, мөн өргөдөл гаргагч этгээдийн, эсхүл түүний төлөөний хүний гарын үсэг байх ёстай. Маргаантай шийдвэр (дугтуйг оруулаад) болон нотолгоог гарти нь өгнө.

**Хууль эрхэзүйн үндэс**

Гаалийн тухай хууль (RS, RS 631.0)

Зүйл: 12, 41, 59

Гаалийн байгууллагын тухай тогтоол (OD; RS 631.01)

Зүйл: 40 - 44

Зүйл: 94 - 98

Зүйл: 165 - 169

Бараа боловсруулах тухай Сангийн сайдын тушаал (RS 631.016)

Заалт: 1

НӨАТ-ын тухай Холбооны хууль (VAT Act, SR 641.20)

Зүйл: 53

**17. Гомдол (Нэхэмжлэл)**

Швейцарь франк

**18. Огноо / Байгууллага / Гарын үсэг**

Холбооны гаалийн газар

Эдийн засгийн арга хэмжээний секц (хэлтэс)

Маягт Но. I.P.R.1



**ZWS ISO 9001:2008 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ**

**ЗИМБАБВЕ УЛСЫН ТАТВАР ОРЛОГЫН ГАЗАР ГААЛЬ, ОНЦГОЙ  
АЛБАН ТАТВАРЫН ГАЗАР ДОТООДОД БОЛОВСРУУЛАХ ГОРИМЫН  
ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

(хоёр хувь бичиж илгээх)

---

---

(Өргөдөл гаргагчийн нэр, хаяг)

Компанийн регистрийн дугаар.....

Бүс нутгийн менежер.

ZIMRA

Шуудангийн хаяг.....

Огноо.....

Эрхэм хүндэт танаа

Би/бид 1992 оны Гааль, онцгой албан татварын газрын (дотоодод боловсруулах горимын тухай) (татварын хөнгөлөлт олгох тухай) журмын 4 дэх хэсэгт заасан нөхцөлөөр бүртгүүлэхээр өргөдөл гаргаж байна.

Би/бид энэхүү өргөдөл (гаалийн) даргын шаардсан мэдээллийн дэлгэрэнгүйг хавсаргав\*.

Би/бид 1992 оны Гааль, онцгой албан татварын газрын (дотоодод боловсруулах горимын тухай) (татварын хөнгөлөлт олгох тухай) журмын холбогдох заалтуудыг уншиж, ойлгосон бөгөөд миний/бидний өргөдлийг нааштай шийдсэн тохиолдолд би/бид тэдгээр заалтыг бүрэн дагаж мөрдөнө.

Хүндэтгэсэн,

.....  
(Гарын үсэг)

.....  
(Нэр, албан тушаал)

CEF 0080

ГААЛЬ & ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ГАЗАР

ХУВИЛБАРЫН №: 1

ХЭВЛЭСЭН ОГНОО: 01/08/2016

ХЭВЛЭСЭН №: 1

НҮҮР ХУУДАС 1/2

Маягт Но. I.P.R.1



**ZWS ISO 9001:2008 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН СИСТЕМ**

**ЗИМБАБВЕ УЛСЫН ТАТВАР ОРЛОГЫН ГАЗАР  
ГААЛЬ, ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ГАЗАР  
АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАВ  
ГААЛИЙН АЖИЛТНЫ ИЛТГЭХ ХУУДАС**

Бүс нутгийн менежер

Дээр дурдсан өргөдлийг хяналт шалгалт хийсэн тухай өөрийн хавсралт тайлангийн хамт та бүхнээр шийдүүлэхээр 1992 оны Гааль, онцгой албан татварын газрын (дотоодод боловсруулах горимын тухай) (татварын хөнгөлөлт олгох тухай) журмын 4 дэх хэсэгт заасны дагуу илгээж байна.

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Өртөөний менежер (бүтэн нэр, гарын үсэг)

Огноо

\*(Гаалийн) даргын шаардсан мэдээллийг дор жагсаав.

**ЖАГСААЛТ**

Дараах зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусдаа хуудсан дээр бичнэ үү: -

1. Байгууллагын бизнес нэр, хаяг.
2. Барилга, байгууламж эзэмшигчийн нэр.
3. Барилгын зураглал, хэмжээ, загвар, барилга барьсан материал, Г.М..
4. Барилга, байгууламжийн үнэ өртөг (эзэмшдэг бол), түрээсийн гэрээ (түрээслдэг бол).
5. Үйлдвэрийн газар, машин төхөөрөмжийн зураглал, тоног төхөөрөмжийн үнэ.
6. Баталгаан дээр хариуцагч этгээдээр гарын үсэг зурах ажилтны нэр.
7. Баталгаа гаргагч байгууллага (Банкны, эсхүл даатгалын компанийн нэр).
8. Зохицуулалтад хамаарах үйлдвэрлэл/боловсруулалтын төрөл (гэрээний дагуу явагддаг бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү)

9. Материал ашиглах гэж буй бүтээгдэхүүн тус бүрийг үйлдвэрлэх/ боловсруулах үйл ажиллагааны шат дараалсан зураглал
10. Тухайн байгууламжид явуулах үйлдвэрлэлийн, эсхүл худалдааны бусад үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (хэрэв өөр аливаа нэг үйл ажиллагаа явуулах бол).
11. Боловсруулах эд зүйл, энэ зорилгоор оруулах бөгөөд гаалийн татварын хөнгөлөлт хүссэн бараа.

Дараах загварыг ашиглана:

Боловсруулах эд зүйлийн нэр төрөл	Гаалийн татварын хөнгөлөлт хүссэн импортын орц	Нэгж бараанд зарцуулах материалын тооцоо (тоо хэмжээ, үнэ)
-----------------------------------	--	--

12. Татварын хөнгөлөлт хүссэн импортын барааг өөр зүйлд ашиглах эсэх (хэрэв тодорхой бол)
13. Дотоодын үйлдвэрийн бараа, эсхүл гаалийн татвар төлсөн бараа ашиглах эсэх.
14. Үйлдвэрлэх/боловсруулах үйл ажиллагаа эхэлсэн эсэх, эхлээгүй бол хэзээ өхлэх.
15. Үйлдвэрлэх/боловсруулах үйл ажиллагааны явцад холбогдох эд материалын (эд зүйлийн, бүтээгдэхүүний) хувьд туслан гүйцэтгэгч татан оролцуулах шаардлагатай эсэх.
16. Үйлдвэрлэх/боловсруулах үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа, гаалийн татварын хөнгөлөлт хүссэн барааг импортлох өдөр болон бэлэн бүтээгдэхүүн экспортлох өдөр хоорондын зайлгийн эхлэх хугацаа.
17. Сүүлийн 12 сард нэхэмжилсэн гаалийн татварын буцаан олголтын хэмжээг бүтээгдэхүүн бүрээр гаргасан дэлгэрэнгүй мэдээлэл.
18. Сүүлийн 12 сард экспортолсон бүтээгдэхүүний үнэ, бүтээгдэхүүн тус бүрээр.
19. Таны өргөдлийг үнэл цэгнэхэд хэрэгтэй байх гэж үзсэн өөр бусад мэдээлэл.  
1992 оны Гааль, онцгой албан татварын газрын (дотоодод боловсруулах горимын тухай) (татварын хөнгөлөлт олгох тухай) журмын заалтуудыг анхаарна уу.

## Хавсралт 5. Гишүүн орнуудын нөхцөл байдлын судалгаа

**Хятад Улс дахь боловсруулах горим ашиглан хийгдэж буй худалдаа  
(нэмүү өртөг шингэсэн худалдаа)**

**1. Хятад Улсад боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) хөгжиж ирсэн эдийн засгийн нөхцөл шалтгаан, өвөрмөгц онцлог, мөн түүнчлэн худалдааны тийм систем нь янз бүрийн салбарын хөгжилд хэрхэн нөлөөлж буй талаар**

1979-2016 оны хооронд Хятадын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны импорт, экспортын нийт дүн нь 235 сая ам.доллараас 1,112,58 тэрбум ам.доллар болж өссөн бөгөөд түүний Хятадын гадаад худалдаанд эзлэх хувь хэмжээ нь 1.5%-иас 30.2% болжээ. Худалдааны барааг боловсруулах ийм үйл ажиллагааны үр дүнд шууд байдлаар 40 сая, шууд бус байдлаар 60 сая ажлын байр бий болжээ. Хятадын өөрчлөлт, шинэчлэлт, нээлттэй бодлогын ачаар Хятадын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) хурдацтай өсч, улмаар Хятадын аж үйлдвэржүүлэлтийн процессыг түргсгэх, аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөх, шинэчлэх ажил идэвхжин өрнөх, шинэ ажлын байр бий болгох, Хятадын эдийн засгийг дэлхийн эдийн засагтай нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) гэдэг нь аливаа нэг үйлдвэрийн газар түүхий эд, эсхүл туслах материал, сэлбэг хэрэгсэл, бүрдэл хэсэг болон баглаа боодлын (сав боодлын) материал оруулж, боловсруулах, эсхүл угсрах үйл ажиллагаа явуулсны дараа бэлэн бүтээгдэхүүнийг буцаан гаргах үйл ажиллагаа

юм. Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) нь ихэнх тохиолдолд захиалгчийн материал (customer-supplied materials)-ыг, эсхүл гаднаас худалдаж авсан материалыг боловсруулах замаар явагддаг.

Хятад улс нь боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны хувьд мөрддөг суурь бодлогын системтэй. Нэгдүгээрт, (гаалийн) баталгаат горимын бодлогын хүрээнд эд анги, материал боловсруулахаар оруулж ирэхэд гаалийн татвар, НӨАТ авдаггүй; зөвхөн тэдгээрийн заримыг дотоодын зах зээл дээр борлуулсан тохиолдолд л татвар ногдуулдаг. Хоёрдугаарт, боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны хувьд хатуу бус хяналтын бодлого мөрддөг. Цөөн тооны эмзэг (хориглосон, хязгаарласан) барааг эс тооцвол импортын материалд холбогдох зөвшөөрөл (лиценз) шаарддаггүй; тийм зөвшөөрөл (лиценз)-ийг зөвхөн зарим материалыг дотоодын зах зээлд борлуулах тохиолдолд шаарддаг. Гуравдугаарт, гадаадын талаас дотоодын талд үнэ төлбөргүй өгсөн боловсруулах тоног төхөөрөмжийг гаалийн татвар, лицензээс чөлөөлдөг. Гэхдээ энэхүү бодлого нь үндэсний хууль тогтоомжийн дагуу цөөн тооны бараанд үл хамаарна. Эдгээр бодлогыг үндэслэн, боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны хувьд дагаж мөрдөх өөр хоорондоо харилцан хамаарал бүхий (гаалийн) баталгаат горимын бодлогын тогтолцоо бий болж тогтсон байдаг. Үүнд дараах зүйлс хамаарна: боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны бүртгэл тооцооны хуудас (буюу данс бүртгэлийн дэвтэр) нээж, хасалт хийх систем; материал зарцуулалтын менежмент; дотоодод борлуулах үйл ажиллагааны менежмент; автоматжуулсан хяналт; гаалийн хяналт, шалгалт ба хорио цээрийн хяналт; гаалийн татвар хураан авах ба түүнээс чөлөөлөх систем; мөн гадаад валютын тооцооны хаалт.

## **2. Боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-нд мэдээллийн технологи хэрхэн хэрхэн тус дэм болдог вэ?**

Хятадын гаалийн байгууллагаас (гаалийн) баталгаат горимын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэд хэдэн үе шаттайгаар явуулдаг байна. Хяналтын зорилгоор эхлээд цаасан хэлбэрийн бүртгэл тооцооны дэвтэр хөтөлж байсан байна. Харин одоо боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны баталгаат горимын бараанд хяналт тавихдаа улс даяараа “Н2010” гэсэн мэдээллийн систем ашиглаж байна. Аливаа нэг үйлдвэрийн газар нь боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны бизнес эрхэлж эхлэхээс өмнө гаалийн байгууллага дээр худалдааны барааг боловсруулах бүртгэл тооцооны хуудас (буюу данс бүртгэлийн дэвтэр) нээлгэх ёстой; тухайн үйлдвэрийн газар нь импортын материалын, мөн түүнчлэн буцаан гаргасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг бүртгэж байхын зэрэгцээ бас оруулсан материал болон гаргасан бүтээгдэхүүн хоорондын тоон хамаарлыг нэгж зарцуулалтын зарим төрлийн стандартын дагуу тооцож, бүртгэл тооцооны хуудас (буюу данс бүртгэлийн дэвтэр)-ны хаалтыг тогтмол хийж байх ёстой байна. Үүнтэй холбогдуулан 2 төрлийн загвар (модуль), тухайлбал бүртгэл тооцооны цахим хуудасны загвар болон данс бүртгэлийн цахим дэвтрийн загварыг боловсруулсан байна. Бүртгэл тооцооны цахим хуудасны загварын хувьд менежментийг гэрээ тус бүрээр явуулна, өөрөөр хэлбэл, цахим дансанд анх тусгагдсаны дагуу гэрээ тус бүрээр нэг бүртгэл тооцооны хуудас хөтөлж, тооцоог нэг бүрчлэн хийнэ.

Данс бүртгэлийн цахим дэвтрийн загварын хувьд менежментийг үйлдвэрийн газар тус бүрээр явуулна, өөрөөр хэлбэл, холбогдох нэг үйлдвэрийн газрын бүх гэрээнд данс бүртгэлийн зөвхөн нэг цахим дэвтэр хөтөлнө. Данс бүртгэлийн

цахим дэвтрийн загвар нь гаалийн хяналтын тусгай бүсэд ажилладаг үйлдвэрийн газруудад, мөн эдгээр бүсийн гадна ажилладаг хэдий ч том бөгөөд нэр хүнд өндөртэй зарим үйлдвэрийн газарт хамааралтай.

### **3. Сургалт**

Гадна талдаа, боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны янз бүрийн бодлогын талаар үйлдвэрийн газруудад бүрэн ойлголт өгөхийн тулд Хятадын гаалийн байгууллага эдгээр бодлогыг нэвтрүүлсний дараа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж танилцуулга, тайлбар хийдэг. Мөн эдгээр бодлогыг ухуулан таниулах ажлыг бүс нутгийн хэмжээнд ойр ойрхон зохион байгуулдаг. Дотооддоо, эл асуудлаар Хятадын гаалийн байгууллага жил бүр сургалт зохион байгуулж, бас боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны хяналтын талаар гадаадын гаалийн байгууллагуудад мэдээлэл хүргүүлэн ажилладаг.

### **4. Тулгамдсан асуудлууд (сорилт) болон боломжууд**

Өнөөдөр Хятадын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) нь голчлон захиалагчийн материалд тулгуурлаж, үндсэндээ хувцас хунар зэрэг бараа үйлдвэрлэдэг салбар байхaa болжсон. Одоо шинэ нүүр төрхтэй болсон. Нэгдүгээрт, олон олон үйлдвэрийн газрууд өөрсдийн брэндийг бий болгохын тулд хараат бус судалгаа, хөгжүүлэлтийн ажил (R&D) хийж, үндсэн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч нар (OEMs - Original Equipment Manufacturers)-аас бага хамааралтай болсон. Хоёрдугаарт, өнгөрсөн үетэй харьцуулахад, боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-

нд дотоодоос худалдаж авсан материал ашиглах явдал улам бүр нэмэгдэж, бас эцсийн бүтээгдэхүүнийг гадаадын төдийгүй дотоодын зах зээлийн аль алинд нь нийлүүлж байна. Гуравдугаарт, энэ салбарын гинжин хэлхээ (бараа нийлүүлэх сүлжээ) тэлсээр, дотоодоос дэмжлэг үзүүлэх хүчин чадал тасралтгүй нэмэгдсээр байна. Дөрөвдүгээрт, баталгаат горимын дагуу явагдах ложистикийн ажиллагаа болон баталгаат горимын дагуу явагдах үйлчилгээ эрс сайжирч байна. Үйлдвэрийн газрууд судалгаа, хөгжүүлэлтийн ажил болон засвар үйлчилгээнд илүү их ач холбогдол өгч байна.

Хятадын гаалийн байгууллага нь боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-г удирдан зохицуулах явдлыг улам бүр хялбаршуулж, эрх мэдлийг доод түвшинд шилжүүлэн өгөх болно; гаалийн байгууллага бас зохицуулалтыг оновчтой болгох, Гаалийн байгууллагын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) болон баталгаат горимын журмыг шинэчлэх хөтөлбөрийг судалж, хэрэгжүүлэх, боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-г одоо хүчин төгөлдөр мөрдэж буй хууль тогтоомжийн хүрээнд боловсронгуй болгох, өөрчлөн шинэчлэх, шинэ шатанд гарган хөгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

